

IUU 한국학연구 제6호

이 학술지는 2022년 대한민국 교육부와
한국학중앙연구원(한국학진흥사업단)의 해외한국학중핵대학육성사업의
지원을 받아 수행된 연구임 (AKS-2022-OLU-2250006)

국제울란바타르대학교 한국학연구소
2024



IUU 한국학연구 제6호

IUU Солонгос судлал

Эрдэм шинжилгээний сэтгүүл 6 дахь хэвлэл

Эрхэлсэн:

Кан Сонь Хуа (Олон улсын Улаанбаатарын их сургуулийн
Солонгос судлалын хүрээлэнгийн захирал)

Сэтгүүлийн редакцын зөвлөлийн гишүүд:

И Мёнми (БНСУ, Кёнбүг их сургууль)
Ким Хён-Ү (БНСУ, Жусон их сургууль)
И Тан Ми (ОУУБИС)
Б.Туяа (ОУУБИС)
Ц.Баярмаа (ОУУБИС)
Л.Мөнхнаран (ОУУБИС)

ISSN 3007-4754

©Энэхүү сэтгүүлийг эрхлэгч, найруулагчдын зөвшөөрөлгүйгээр цахим хайлтад оруулах, зураг болгох, хэвлэх, олшруулахыг хориглоно. Зохиогч бүтээлийнхээ шинжлэх ухааны үнэнийг батлан хариуцна.

Цаасны хамжээ: 176x250

Хэвлэлийн хуудас: 12.3хх

“Мөнхийн үсэг” ХХК-д хэвлэв.

Хэвлэсэн он: 2024.10.

ОУУБИС, Солонгос судлалын хүрээлэн

목차

경제학

1. 경제 개발 결과로 격상된 대한민국의 국제 위상 5
데.막마르

국제관계

2. 20세기 몽골인의 추억 속의 한국인 19
제.바트투르
3. 한국 디지털화의 새로운 추세와 몽골의 기회 35
데.올람바야르
4. 러시아 "즈베즈다(Звезда)" 채널에 방송된 한반도 분단에 대한 고찰 ..58
데.나랑토야

사회, 문화

5. 한국과 몽골어 여성 관련 속담에 나타난 언어문화적 특성 비교 68
이승훈

철학

6. 한국철학의 기본 개념 정리..... 92
김현우

언어학, 교육학

7. 한국어 문법 연구 현황 및 연구 동향 - 형태론을 중심으로..... 109
강선화
8. 한국어 '오빠'의 신조어 의미 분석..... 128
체. 바야르마
9. 한국어 학습자의 전공 선택에 미치는 요인 분석..... 135
베.토야

ГАРЧИГ

Эдийн засаг

1. Эдийн засгийн хөгжлийн дүнд өөрчлөгдсөн БНСУ-ын олон улсын тавцан дахь байр суурь..... 5
Д.Мягмар

Олон улсын харилцаа

2. 20-р зууны Монголчуудын дурсамж дахь Солонгосчууд..... 19
Ж.Баттөр
3. БНСУ-ын дижитал хөгжлийн шинэ чиг хандлага ба Монголын боломж 35
Д. Уламбаяр
4. ОХУ-ын зурагтын “Звезда” суваг Солонгосын хуваагдлын тухай..... 58
Д.Нарантуяа

Нийгэм, соёл

5. Эмэгтэйчүүдтэй холбоотой солонгос, монгол зүйр цэцэн үгсийн хэл, соёлын онцлогийг харьцуулах нь 68
И Сын Хүн

Гүн ухаан

6. Солонгосын гүн ухааны үндсэн ойлголтуудын хураангуй 92
Ким Хён-Ү

Хэл шинжлэл, боловсрол судлал

7. Солонгос хэлний хэл зүйн дүрмийн судалгааны өнөөгийн байдал: Үг зүйн жишээгээр..... 109
Кан Сонь Хуа
8. Солонгос хэлний “ubbā (ax)” хэмээх үгэнд илэрч буй неологизм утга..... 128
Ц.Баярмаа
9. Солонгос хэл суралцагчдын мэргэжил сонголтод нөлөөлж буй хүчин зүйлсийг судлах нь..... 135
Б.Туяа

ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ДҮНД ӨӨРЧЛӨГДСӨН БНСУ-ЫН ОЛОН УЛСЫН ТАВЦАН ДАХЬ БАЙР СУУРЬ

Д.Мягмар¹

myagmar_d@mas.ac.mn

Хураангуй

БНСУ солонгосын дайны дараа нэн ядуу улсын ангилалд багтаж байсан бол 1960-аад оноос Засгийн газар нь экспортод чиглэсэн аж үйлдвэрлэлийг тууштай дэмжсэний хүчинд эдийн засаг огцом хурдтай өсөж, аж үйлдвэрлэл, технологийн өндөр хөгжилд хүрснээр 2000 он гэхэд хөгжингүй орнуудын жишигт хүрчээ. Эдийн засгийн хөгжлийг дагаад тус улсын олон улсын тавцан дахь байр суурь огцом дээшилсэн. Уг сэдвийн хүрээнд төрийн бодлогоор дотоодын үйлдвэрлэгчдийг хэрхэн дэмжиж, ямар үр дүнд хүрсэн тухай өгүүлэх болно.

Түлхүүр үг: БНСУ, аж үйлдвэрлэл, экспорт, эдийн засаг

Удиртгал

Аливаа орон олон улсын харилцааны системд өөр өөр байр суурь (статус) эзэлдэг. Улс орны энэхүү байр суурийг өнөө цагт нийгэм, эдийн засгийн хөгжлийн үзүүлэлтээр гол төлөв тодорхойлж байна. Байр суурийн тухай нэгдсэн томъёолол байхгүй ч эрдэмтэд дараах байдлаар тодорхойлжээ. Өндөр байр суурь бүхий улсууд нь доор нэгнээс өөр эрх, үүрэгтэй байдаг (MacDonald & Parent, 2021, 363). Улс орны байр суурь нь тухайн улсын онцлогоос хамаарах бөгөөд олон улсын байгууллагын гишүүнчлэлээр тодорхойлогдоно. Энэхүү гишүүнчлэлийн хүрээнд ижил байр суурь бүхий улсуудтай үнэ цэн, үзэл бодлоо хуваалцах нь илүү сэтгэл

ханамжийг өгдөг бөгөөд гишүүн бус орнуудтай харьцуулахад давуу тал болдог (Larson & Shevchenko, 2010; Murray, 2019). Улс орны байр суурь нь олон улсын тавцанд нөлөө бүхий бүлэглэлийн гишүүнчлэлээр тодорхойлогдох бөгөөд эрэмбийг заана. Бага байр суурь бүхий улсууд нь өндөр байр суурь эзэлдэг улсуудын ашиг сонирхлоос хамааралтай байдаг (Pratt, 2018)². Эдгээр судлаачдын тодорхойлолтоос дүгнэж үзвэл улс орнуудын олон улсын тавцан дахь байр суурийг илэрхийлэх чухал үзүүлэлт нь олон улсын байгууллагын гишүүнчлэл гэж үзэж болохоор байна.

¹ ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

² Lauren Ferry, Cleo O'Brien-Udry, "The possibilities and limits of international status: Evidence from foreign aid and public opinion", 2024.

Учир нь олон улсын байгууллагууд нь үйл ажиллагааны зорилгод үндэслэн гишүүнчлэлийн шалгуур үзүүлэлтээ тогтоодог. Эдийн засаг, нийгмийн өндөр хөгжилд хүрсэн, өндөр орлоготой улс орнууд л OECD, Их-20, Парисын бүлэг зэрэг байгууллагад гишүүнээр элсэх боломжтой. Эдгээр байгууллагын гишүүнчлэлийн гол шалгуур нь нийгэм, эдийн засгийн хөгжлийн үзүүлэлтүүд байдаг. Тухайлбал, улс төрийн тогтолцоо, хүний хөгжлийн индекс, иргэдийн боловсролын түвшин, нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ, аж үйлдвэрлэлийн бүтэц, худалдааны чөлөөт байдал зэрэг үзүүлэлтүүдийг голчлон авч үздэг байна.

Нөгөөтээгүүр улс орнуудыг хөгжингүй болон хөгжиж буй, өндөр орлоготой болон бага, дунд орлоготой гэж ангилах жишиг байдаг. Уг ангилалд багтаагүй улсуудыг ядуу буурай орон гэж үздэг. Энэ нь мөн л нийгэм, эдийн засгийн хөгжлийн түвшнээр улс орнуудыг эрэмбэлж буй хэлбэр юм. Тухайлбал, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (UNDP) нь боловсрол, эрүүл мэнд, орлого, дундаж наслалт зэрэг хувь хүнд чиглэсэн үзүүлэлтэд үндэслэн хүний хөгжлийн индексийг (HDI) тодорхойлдог. Уг индексэд үндэслэн улс орнуудыг хөгжлийн түвшнээр хөгжингүй болон хөгжиж буй гэж ангилдаг³. Олон улсын

валютын сан болон Дэлхийн банк нь санхүүгийн чадвар, үндэсний нийт бүтээгдэхүүн, экспортын хэмжээ, аж үйлдвэрлэл, технологийн түвшин зэрэг улс орны хэмжээний эдийн засгийн үзүүлэлтүүдэд үндэслэн өндөр болон бага дунд орлоготой гэж ангилдаг. Хөгжингүй болон өндөр орлого бүхий ангилалд багтсан орнууд нь OECD, Их-20, Парисын бүлэг зэрэг байгууллагын гишүүд байх бөгөөд дэлхий дахины байгаль орчин, нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх, санхүүжүүлэх үүрэг хариуцлага хүлээдэг. Гишүүнчлэлийн хураамж буюу санхүүжилтийн хэмжээг тухайн улсын төлбөрийн чадварт үндэслэн тогтоодог.

Хөгжингүй буюу өндөр орлоготой ангилалд багтсан улс орнуудын олон улсын тавцан дахь байр суурь нь хөгжиж буй болон ядуу буурай орнуудынхаас илүү байдаг. Аль ч улс өндөр хөгжилд хүрч, олон улсын тавцан дахь байр сууриа ахиулахыг зорьдог. Зарим улс өндөр хөгжилд хүрэхэд урт хугацаа зарцуулдаг бол зарим улс харьцангуй богино хугацаанд зорилгодоо хүрдэг. Бидний стратегийн түнш БНСУ нь 1950-аад оны сүүлээр дамбуурлын ирмэгт очсон, нэн ядуу улс байсан бол экспортод чиглэсэн аж үйлдвэрлэлийг төрөөс тууштай, ухаалаг, оновчтой бодлогоор дэмжсэний дүнд эдүгээ хөгжингүй орны статустай болжээ. БНСУ нь газар нутаг багатайн дээр нийт газар нутгийн 70 хувийг уул нурууд эзэлдэг учир хөдөө аж ахуй

³ Classifications of Countries Based on Their Level of Development: How it is Done and How it Could be Done; by Lynge Nielsen; IMF Working Paper 11/31; February 1, 2011

зэрэг их талбай шаарддаг үйлдвэрлэл эрхлэхэд тохиромжгүйн дээр байгалийн нөөц баялаггүй. Гэвч Хятад, Япон, Зүүн болон Өмнөд Ази, Австрали зэрэг томоохон зах зээлүүдтэй далайн тээврээр шууд холбогдох боломж бүхий газар зүйн онц ашигтай байршил, уур амьсгалын таатай нөхцөлтэй. Эдгээр давуу талд тулгуурлан, олон тооны ажиллах хүчээ ашиглан төрийн бодлого зохицуулалтаар 1960-аад оноос аж үйлдвэрлэлийг тууштай хөгжүүлж өндөр амжилтад хүрсэн.

Арга зүй

Судалгааны зорилго нь нэн ядуу, дампуурлын ирмэгт байсан БНСУ-ыг хөгжингүй орны эгнээнд элсэхэд хүргэсэн гол хүчин зүйл болох экспортод чиглэсэн аж үйлдвэрлэлийг дэмжих зарим голлох бодлого хөтөлбөрүүд, түүний үр дүнг тодруулахад оршино. Энэ зорилгын хүрээнд баримт бичгийн судалгааг дараах 3 дэд сэдэвт хуваан авч үзнэ.

1. БНСУ-ын дайны дараах эдийн засгийн нөхцөл байдал
2. Экспортод чиглэсэн аж үйлдвэрлэлийг дэмжих бодлого
3. Хөгжингүй орны жишигт хүрсэн 2000 оны эдийн засгийн нөхцөл байдал

Дайны дараах үе буюу 1960 оноос 2000 он хүртэлх 40 жилийн хугацаанд тус улсын эдийн засаг хэрхэн хөгжсөнийг нэг хүнд ноогдох ДНБ-ий хэмжээ, экспортын хэмжээ,

аж үйлдвэрлэлийн бүтэц, технологийн түвшин, хүний хөгжлийн индекс зэрэг үзүүлэлтээр, байр суурь хэрхэн дээшилснийг олон улсын байгууллагын гишүүнчлэлээр харьцуулан авч үзнэ. БНСУ нь 2000 онд өндөр хөгжингүй орны жишигт хүрсэн байсан учир уг оныг сонгож харьцуулсан.

1. Дайны дараах БНСУ-ын эдийн засгийн нөхцөл байдал

Дэлхийн хоёрдугаар дайны өмнө, колоничлолын он жилүүдэд Япон улс нь Солонгосын хойгийг цэргийн ханган нийлүүлэх бааз болгон ашиглаж байв. Ингэхдээ солонгосын умард хэсгийг эрчим хүч, уул уурхай, аж үйлдвэрлэлийн зориулалтаар, өмнөд хэсгийг хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж байжээ⁴. Улмаар дэлхийн хоёрдугаар дайн дуусаж, Япон улс бууж өгснөөр 1948 онд тусгаар тогтносон БНСУ-ыг албан ёсоор тунхагласан. 1950-1953 онд өрнөсөн солонгосын дайны дараа тус улсын дэд бүтэц, аж үйлдвэрлэл, бүтээн байгуулалт үндсэндээ бүрэн сүйдэж, Умардын тал эрчим хүчээ тасалсан байна. Ийнхүү БНСУ нь 1950-аад оны дундуур өлсгөлөнд нэрвэгдсэн, валютын нөөцгүй, дайны хөлд сүйдсэн, нэн ядуу улсын ангилалд багтаж байв. Эдгээр он жилүүдэд улсын төсвийн ихэнх хэсгийг зээл тусламжаар бүрдүүлж байжээ. Гол хандивлагч болох АНУ нь 1954-1970 он

⁴ Milan Lajciak "South korean development model", 2016.

хүртэлх хугацаанд 1.9 тэрбум долларын санхүүгийн тусламжийг БНСУ-д үзүүлжээ. Мөн 1951–1962 оны хооронд БНСУ-ын импортын талаас дээш хувийг АНУ-ын тусламжийн бараа бүтээгдэхүүн эзэлж байв⁵. БНСУ-ын шинэ Засгийн газар улс орноо өлсгөлөн ядуурлаас гаргах зорилго тавин 1954–1960 оны хооронд хөдөө аж ахуй болон өргөн хэрэглээний барааны үйлдвэрлэлийг дэмжсэн. Импортыг орлох зорилго бүхий энэхүү бодлогын үр дүнд хүнсний хангамжийн асуудал цэгцэрч, хөнгөн үйлдвэрлэл сэргэсэн ч БНСУ ядуу улсын зэрэглэлд багтсан хэвээр байв. 1960 оны байдлаар нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 158 ам. доллар, нийт экспортын хэмжээ 32.8 сая ам. доллар⁶, аж үйлдвэрлэл болон технологийн түвшин нэн доогуур, иргэдийн амьдралын чанар тун муу байжээ. Ажиллах хүчний 83 хувь нь ХАА-н салбарт, үлдсэн 17 хувь нь хөнгөн үйлдвэрлэл болон үйлчилгээний салбарт ажиллаж байв⁷. Улс орон ерөнхийдөө дампуурлын ирмэгт, гадаадын зээл тусламжид түшиглэсэн байдалтай байв.

2. Аж үйлдвэрлэл, эдийн засгийн хөгжлийн он жилүүд

Улс орноо гадаадын зээл тусламжийн хараат байдлаас гаргах, цаашилбал экспортлогч орон болох зорилго тавин тус улсын Засгийн газар нь 1960 оноос хөнгөн үйлдвэрлэлийг дэмжихэд анхаарах болсон. Уг зорилгын хүрээнд Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн тухай хуулийг баталжээ. 1961 онд Эдийн засгийн төлөвлөлтийн хороог байгуулж, олон тооны эрдэмтдээс бүрдэх судалгааны багийг дэргэдээ ажиллуулах болсон. Үүний зорилго нь эдийн засгийн бодлого төлөвлөлтөд эрдэмтдийн судалгаа, санал зөвлөмжийг тусгахад оршиж байв. БНСУ-ын ерөнхийлөгч Пак Жөн Хий нь тус улсын эдийн засгийн урт болон дунд хугацааны төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх зорилгоор төсөв, татвар, аж үйлдвэрлэл, гадаад худалдаатай холбоотой бүх эрх мэдлийг Эдийн засгийн төлөвлөлтийн хороонд⁸ төвлөрүүлсэн. Улмаар холбогдох чиг үүрэг бүхий байгууллагуудыг нэгдсэн бодлогын хүрээнд харилцан уялдаатай, үр өгөөжтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлжээ. Өөрөөр хэлбэл экспортод чиглэсэн эдийн засгийн бодлого төлөвлөн хэрэгжүүлэх төрийн байгууллагуудын тогтолцооны үндсийг тавьжээ.

Улмаар Эдийн засгийн төлөвлөлтийн хороо нь 1962 оноос эдийн засгийн хөгжлийг таван жилээр

⁵ pdacy151.pdf (usaid.gov)

⁶ South Korea GDP Per Capita 1960-2024 | MacroTrends

⁷ 우리나라의 산업 구조 (naver.com)

⁸ 경제기획원 (naver.com)

төлөвлөн хэрэгжүүлэх болсон байна. Энэхүү төлөвлөгөөнд экспортыг дэмжих бодлого хөтөлбөрүүдээ тусган хэрэгжүүлж иржээ. 1992 он хүртэл харилцан уялдаатайгаар 6 удаа хэрэгжүүлсэн энэхүү төлөвлөгөөний үр дүнд тус улсын нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 80 дахин өссөн⁹.

2.1 Хөнгөн үйлдвэрлэлийг дэмжих бодлого

Эдийн засгийн анхдугаар 5 жилийн төлөвлөгөөний хүрээнд 1965 оноос торго, нэхмэл даавуу, зүймэл модон хавтан, савхи, гар урлалын бүтээгдэхүүн, шаазан эдлэл, резин бүтээгдэхүүн, радио болон цахилгаан хэрэгсэл, төмөр лааз, модон эдлэл, бэлэн хувцас зэрэг хөнгөн үйлдвэрлэлийн салбарын экспортыг төрөөс онцгойлон дэмжиж эхэлсэн. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн тухай хуулийн дагуу 1964 оноос экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн ашгийн татварыг 80 хүртэл хувиар хөнгөлж эхлэв. 1966 онд Үндэсний татварын албыг байгуулж татварын реформ хийжээ.

Улс орноороо валютын хомсдолтой байсан тэр цаг үед үйлдвэрлэгчдэд хамгийн чухал дэмжлэг нь санхүүгийн дэмжлэг байв. Үйлдвэрлэгчдийн санхүүгийн хомсдолыг шийдвэрлэх үүднээс бага хүүтэй зээлийг 1960–

аад оноос олгож эхэлжээ. 1961 оноос экспортын санхүүжилтийг хөнгөн үйлдвэрлэлийн салбарт олгож эхэлсэн. Үйлдвэрлэгч нь экспортын гэрээнд үндэслэн банкнаас зээл авах замаар импортлогч талаас шилжүүлэх төлбөрийг хүлээхгүйгээр санхүүгийн асуудлаа шийдвэрлэх, үйлдвэрлэлээ хэвийн явуулахад уг үйлчилгээ тусалдаг байна. Экспортын санхүүжилт нь 1961 оноос өнөөг хүртэл хэрэгжиж буй экспортыг дэмжих санхүүгийн гол арга хэрэгслүүдийн нэг юм. Экспортын санхүүжилтийн хүү нь тухайн үеийн банкны зээлийн хүүгээс хавьгүй бага байснаараа, мөн валютын ханшийн зөрөөнөөс багагүй өгөөж өгдгөөрөө үйлдвэрлэгчдэд ашигтай байв. Засгийн газар 1969 онд үйлдвэрлэгчдийн гадаад худалдааны эрсдэлийг бууруулах зорилгоор Экспортын даатгалын тухай хуулийг баталжээ. Хуулийн хүрээнд Экспортын даатгалын санг байгуулж даатгалын үйлчилгээг нэвтрүүлсэн.

2.2 Хүнд болон химийн аж үйлдвэрлэлийг дэмжих бодлого

Эдийн засгийн хоёрдугаар таван жилийн төлөвлөгөөний дагуу 1970-аад оноос хүнд болон химийн үйлдвэрлэлийг төрийн бодлогоор дэмжиж эхэлсэн. Хөнгөн үйлдвэрлэл нь олон тооны ажиллах хүч шаарддаг салбар аж. Цалингийн зардлын эрчимтэй өсөлт, нэмүү өртөг харьцангуй бага бүтээдэг зэрэг шалтгаан нь төрөөс илүү өндөр үр өгөөжтэй аж үйлдвэрлэлийн салбарыг

⁹ Мягмар, Д. (2023) . БНСУ-ын Засгийн газраас үндэсний үйлдвэрлэл, экспортоо дэмжиж буй хэлбэрүүд, Олон улс судлал сэтгүүл, №115, х.48-62,

дэмжихэд хүргэжээ. Засгийн газар нь ган төмөр, зэвэрдэггүй металл, усан онгоц, электроник болон химийн үйлдвэрлэлийг хүнд болон химийн аж үйлдвэрлэлийн гол салбараар сонгон хөгжүүлсэн¹⁰. Хүнд болон химийн аж үйлдвэрлэл нь олон төрлийн нарийн технологи, стандарт шаарддаг учир уг бодлогын хүрээнд Туршилт судалгааны хүрээлэн, Аж үйлдвэрлэлийн технологийн хүрээлэн зэрэг технологи, стандартыг хөгжүүлэх, хянах үүрэгтэй байгууллагуудыг үүсгэн байгуулжээ.

Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн тухай хуулийн дагуу 1973 оноос хүнд болон химийн аж үйлдвэрлэл эрхлэгчдийг эхний 3 жилд ашгийн татвараас бүрэн чөлөөлж, дараагийн 2 жилд 50 хувийг хөнгөлж байв. Мөн экспортын зориулалттай үйлдвэрлэлийн түүхий эдийг импортын татвараас чөлөөлөх тухай хуулийг 1975 оноос батлан хэрэгжүүлж эхэлжээ. Уг хуульд зааснаар гадаадаас импортолсон түүхий эдийг 13 сарын дотор үйлдвэрлэлийн процессоор дамжуулан экспортод гаргасан бол импортын татварыг буцаан олгодог

байв. Импортын татварын буцаан олголтын хэмжээ 1975 онд 0.1 их наяд вон байсан бол 1990 онд 3.2 их наяд вон болон нэмэгджээ. Уг хууль өнөөг хүртэл хүчинтэй хэрэгжиж байна.

Үйлдвэрлэгчдэд дотоодын болон гадаадын эх үүсвэрээр таатай нөхцөл бүхий зээл олгож байв. 1973 онд байгуулагдсан Үндэсний хөрөнгө оруулалтын сан нь дотоод санхүүгийн нөөцийг аж үйлдвэрлэлийн салбар луу чиглүүлж байв. 1960–аас 1980–аад оны сүүл хүртэл Аж үйлдвэрлэлийн банк, Эксим банк, Жижиг, дунд бизнесийн банк зэрэг арилжааны банкнууд төрийн мэдэлд байсан бөгөөд зээлийн хүүг төрөөс зохицуулдаг байжээ. Үйлдвэрлэл эрхлэгчдэд бага хүүтэй зээл олгохын хажуугаар зээлийн шимтгэлд ихээхэн хөнгөлөлт үзүүлж байсан. Экспортыг дэмжих зээлийн нөхцөл шалгуур нь бусад зээлтэй харьцуулахад амар, мөн зээлийн шимтгэл харьцангуй бага байсан ч зээл олгосны дараа зарцуулалтыг нарийн хянадаг байв. Зээлийн бага хүүг зарим судлаачид экспортыг дэмжих татаас гэж үзэх нь бий.

Хүснэгт 1. Экспортыг дэмжих зээлийн хүүгийн түвшин

Он	1964	1967	1975	1977	1980	1982
Бизнесийн зээлийн хүү	14	24	15.5	16	20	10
Экспортын зээлийн хүү	8	6	7	8	12	10
Зөрөө	6	18	8.5	8	8	

Эх сурвалж: Yun Hwan Kim, The role of Government in export expansion in the ROK: A revisit, 1994.

¹⁰ 경제개발계획 (naver.com)

Мөн Засгийн газар нь гадаадын банк санхүүгийн байгууллагуудаас хөнгөлөлттэй зээл, санхүүжилт авах боломжийг үйлдвэрлэл эрхлэгчдэд олгожээ. Хүнд болон химийн аж үйлдвэрлэлийг дэмжих бодлогын үндсэн хэсэг болох “Гадаадын зээлийг дэмжих журам”-ын хүрээнд Засгийн газраас нэр заасан тодорхой салбарын үйлдвэрлэгчид гадаадаас хөнгөлөлттэй зээл авах тохиолдолд зээлийн баталгааг Засгийн газар гаргаж өгдөг байв. Төрийн баталгаа бүхий гадаадын хөнгөлөлттэй зээлийн жилийн хүү нь дунджаар 9 хувь буюу дотоодын банкныхаас (зээлийн хүү 20 орчим хувь байсан) хавьгүй бага, эргэн төлөх хугацаа урт байсан нь үйлдвэрлэгчдэд үлэмж давуу тал олгожээ. Хөтөлбөрт хамрагдсан компани нь зээлийн гэрээний нарийвчилсан нөхцөл болон зарцуулалтаа Засгийн газарт тайлагнадаг, Засгийн газар нь эргээд хяналт тавьдаг журамтай байв. Хүнд болон химийн аж үйлдвэрлэлийг гадаадын хөнгөлөлттэй зээлээр дэмжих бодлогод хийсэн Чой Жэду, А.Левченко нарын судалгаагаар уг зээлд хамрагдсан компаниудын дараагийн 30 жилийн борлуулалт нь хамрагдаагүй компаниудтай харьцуулахад үлэмж өндөр дүнтэй гарсан байна¹¹.

Экспортын санхүүжилтийг хэрэгжүүлдэг мэргэшсэн байгууллага болох банк 1976 онд, Зээлийн

батлан даалтын сан 1974 онд тус тус байгуулагджээ. Зээлийн батлан даалтын сангаас¹² гаргасан баталгаанд үндэслэн Эксим банк¹³ нь экспортын санхүүжилтийг олгож иржээ. Ийнхүү экспортын санхүүжилтийн үйлчилгээ нь Хүнд болон химийн аж үйлдвэрлэлийг дэмжих бодлоготой зэрэгцэн мэргэжлийн түвшинд хүрч, илүү өргөн хүрээг хамрах болжээ. Экспортын санхүүжилтийн маш бага хүүгийн түвшин нь 1960–1980 оны хооронд экспортлогчдод асар өндөр өгөөжтэй байв¹⁴.

1970-аад онд аж үйлдвэрлэлийн салбарын дийлэнх хувийг хөнгөн үйлдвэрлэл эзэлдэг байсан бол 2008 он гэхэд 83.5 хувийг хүнд болон химийн үйлдвэрлэл, 16.5 хувийг хөнгөн үйлдвэрлэл эзлэх болжээ¹⁵. Ийнхүү тус улсын эдийн засгийн гол зүтгүүр нь хүнд болон химийн аж үйлдвэрлэл болсон байна.

2.3 Төвлөрсөн худалдаа эрхлэгч хөтөлбөр

Гуравдугаар таван жилийн төлөвлөгөөний хүрээнд 1975 оноос дотоодын үйлдвэрлэгчдийн экспортыг нэмэгдүүлэх, төрөлжүүлэх зорилгоор Төвлөрсөн худалдаа эрхлэгч (종합무역회사) нэртэй хөтөлбөр хэрэгжүүлсэн. Тухайн цаг үед Засгийн газар нь

¹² 신용보증기금 (kodit.co.kr)

¹³ Home : Korea Eximbank

¹⁴ Mah, Jai S., “Export Promotion and Economic Development of Korea”, Journal of World Trade, February 2006.

¹⁵ 중화학공업 (naver.com)

¹¹ Jaedo Choi, Andrei A. Levchenko, The long-term effects of industrial policy, NBER Working paper 29263, 2022.

хөгжлийн шатандаа яваа үндэсний үйлдвэрлэгчдийг гадны өрсөлдөгчдөөс хамгаалах үүднээс гадаад худалдааг харьцангуй хаалттай, зохицуулалттай байлгах бодлого барьж байв. Уг зорилгын хүрээнд бүх ААН-үүдэд бус цөөн тооны томоохон корпорацад гадаад худалдааны өргөн боломж, давуу тал олгох замаар экспортыг төрөлжүүлэх, гадаад зах зээлийн орон зайг нэмэгдүүлэх, худалдааны суваг бий болгоход уг хөтөлбөр чиглэгджээ. Уг хөтөлбөрт хамрагдах компанийн экспортын хэмжээ нь БНСУ-ын нийт экспортын 2 хувиас илүү, хөрөнгийн хэмжээ 2 тэрбум воноос дээш, гадаадын 20 улсад салбартай, 20-оос дээш улсад экспорт хийдэг байх ёстой аж¹⁶. Самсунг, Хёндэ, Дэү, Күүкжэ зэрэг 13 корпорац уг шалгуурыг хангаж төрийн дэмжлэг авсан¹⁷. Хөтөлбөрт хамрагдагсад Засгийн газраас олон төрлийн боломж, давуу тал олгожээ. Үүнд:

1. Экспортын холбоо, эвсэлд гишүүнээр элсэх нөхцөлийг хөнгөвчлөх
2. Олон улсын тендерт давуу талтайгаар оролцох
3. Түүхий эдийн импортод давуу эрх олгох
4. Экспортын зээл болон санхүүжилтийн хялбар нөхцөл
5. Дотоодын үйлдвэрлэгчдээс

¹⁶ 신장철, “한국의 종합상사제도에 관한 연구”, 2017.

¹⁷ 조동성, 한국의 종합무역상사 (수정판), 법문사, 1987.

худалдан авсан бараанд төлбөрийн баталгаа (Local L/C) гаргах эрх

6. Гадаад валютын гүйлгээг 3-аас дээш банкаар дамжуулан хийх эрх
7. Банкнаас олгодог гэрээний гүйцэтгэлийн болон тендерийн баталгааны бичгийг (Stand-by Credit) олон дахин ашиглах эрх
8. Гадаад дахь салбаруудаа бизнесийн зориулалтын дагуу төрөлжүүлэх эрх
9. Гадаад дахь салбарт 500 мянгаас дээш ам.доллар хадгалах эрх

Дээр дурдсан дийлэнх боломж нь өнөө цагт бүх ААН-үүдэд нээлттэй болсон боловч тухайн цаг үед зөвхөн хөтөлбөрт хамрагдсан корпорацуудад олгогдож байв. Төрөөс олгосон давуутал нь корпорацуудад санхүүгийн, гадаад валютын гүйлгээний, мөн бусад жижиг, дунд үйлдвэрлэл (ЖДҮ) эрхлэгчдийг удирдах болон хянах өргөн боломж олгожээ. ЖДҮ эрхлэгчдийн хувьд бие даан экспорт болон импорт хийх нь Төвлөрсөн худалдаа эрхлэгчдээр (ТХЭ) дамжуулан хийснээс хавьгүй төвөгтэй, өндөр өртөгтэй, мөн тэднээр дамжуулан экспортолсон барааны төлбөр нь баталгаатай, эрсдэлгүй байв. Товчоор хэлбэл ТХЭ-чид нь гадаад худалдааны найдвартай суваг болжээ. Мөн ТХЭ-чид нь олон улсын томоохон тендерт бусад ААН-үүдтэй хамтарсан консорциум байгуулж давуу эрхтэйгээр оролцох боломж нээлттэй байв. ТХЭ нь бараа үйлчилгээний худалдаанаас гадна уул уурхай, хөрөнгө оруулалт, технологи дамжуулалт гэх зэрэг бүх

төрлийн хил дамнасан бизнест давуу эрх эдэлж байж. Гадаад худалдаанд татвар, санхүүгийн хөнгөлөлтүүдийг эдэлж, бусдаас давуу нөхцөл, бага хүүтэй зээл авч байсны дүнд тэдний бизнесийн цар хүрээ, борлуулалт хурдацтай өсөж, дотоодын зах зээлд

үлэмж байр суурь эзлэх болсон¹⁸. Уг хөтөлбөрийг хэрэгжүүлсний үр дүнд 1970, 1980-аад онуудад БНСУ-ын экспортын зах зээл их хэмжээгээр тэлж, экспортын барааны нэр төрөл олширч, худалдааны хэмжээ өссөн. Мөн дотоодын үйлдвэрлэл нэмэгдэж, эдийн засгийн өсөлт дагуулжээ¹⁹.

Хүснэгт 2. БНСУ-ын экспортын мэдээлэл

Он	Экспортын хэмжээ /мянган ам. доллар/	Гадаад худалдааны зөрөө	Экспорт хийсэн улсын тоо
1975	5.081.016	-2.193.418	137
2000	172.267.519	11.786.492	238

Эх сурвалж: 한국무역통계 총괄 - K-stat 수출입 무역통계 (kita.net)

Уг хөтөлбөрийг эхлүүлсэн 1975 онд экспортын хэмжээ 5 тэрбум, гадаад худалдааны алдагдал 2 тэрбум ам.доллар байсан бол 2000 оны байдлаар экспортын хэмжээ 172 тэрбум болон 34 дахин өсөж гадаад худалдаа 12 тэрбум долларын ашигтай гарчээ. Мөн 1975 онд 71 улсад нэг сая доллароос дээш дүнтэй экспорт хийж байсан бол 2000 онд 185 болж өсжээ.

1990-ээд оноос олон улсын худалдааны орчин сайжирч, технологийн хөгжил нь олон төрлийн дэвшил авч ирснээс үүдэн уг хөтөлбөрийн ач холбогдол буурч эхлэв. Нөгөөтгээгүүр 1990-ээд оноос Засгийн газраас эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулж, гадаад худалдааг либералчлах бодлого барих болсон

нь уг бодлогыг зогсооход нөлөөлжээ. 2009 онд нэгэнт үр дүнгээ өгсөн ТХЭ хөтөлбөрийг зогсоосны дараа гадаад худалдааны хуульд өөрчлөлт оруулж, дунд үйлдвэрлэгчдийн шууд бус экспортыг дэмжих зорилгоор Мэргэшсэн худалдаа эрхлэгч (전문 무역상사) хөтөлбөрийг 2014 оноос албан ёсоор хэрэгжүүлж эхэлсэн. Уг хөтөлбөр нь дотоод гадаад зах зээлд компанийн нэр хүндийг өсгөж, гадаад худалдаанд бусдаас давуу тал олгож байгаагаараа ТХЭ хөтөлбөртэй төстэй юм. Өнөөгийн байдлаар БНСУ-д 627

¹⁸ Role of Subsidy in Evolution of Platform Intermediary: Focus on Government Support for General Trading Companies, Chanhi Park, 2022. E-Trade Review, Vol.20, No.4 (November 30, 2022) pp.63-87.

¹⁹ 신장철, “한국의 종합상사제도에 관한 연구”, 2017.

мэргэшсэн худалдаа эрхлэгч компани үйл ажиллагаа явуулж байна²⁰.

2.4 Тооноос илүү чанарын өсөлтөд анхаарах болсон нь

Санхүүгийн хэт өргөн хүрээний дэмжлэг, мөн эдийн засаг дахь төрийн оролцоо өндөр байснаас үүдэн 1980-аад оны эхээс аж үйлдвэрлэлийн салбарын үр ашиг буурч эхэлжээ. Үүнд мөн газрын тосны хоёр дахь удаагийн хямрал ч нөлөө үзүүлсэн. Аж үйлдвэрлэлийн салбарын өндөр алдагдал, бүтээмж бууралт, их хэмжээний гадаад валютын өр зэрэг нь тус улс бүтцийн өөрчлөлт хийх үндсэн шалтгаан болжээ. 1980-аад оны дундаас гадаад худалдааг чөлөөлөх, эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулж либералчлах замаар санхүүгийн нөөцийг чөлөөтэй хөрвөх боломжийг бий болгох бодлого барих болжээ²¹. Энэ хүрээнд аж үйлдвэрлэлийн салбарт олгож байсан таатай нөхцөл бүхий зээлийг зогсоох, гадаад худалдааны тарифыг бууруулах, дотоод зах зээл дэх мөнгөний нийлүүлэлтийг бууруулах зэрэг хэд хэдэн чухал алхам хийсэн. Бодлогын хүрээнд арилжааны 5 банкиг хувьчилж, гадаадын банк санхүүгийн байгууллага дотоод зах зээлд нэвтрэх боломжийг нээж өгчээ. Улмаар газрын тосны хямралын нөлөө арилж, долларын ханш тогтворжиж, инфляц

буурахтай зэрэгцэн 1980-аад оны сүүлээс тус улсын гадаад худалдааны тэнцэл өндөр ашигтай гарч, эдийн засаг эрчимтэй өсөж эхэлсэн. Энэ үеэс БНСУ-ын Засгийн газар эдийн засгийг төрөлжүүлэх, тооноос илүү чанарыг дэмжих үүднээс тоног төхөөрөмжийн болон ур чадварын экспорт (хилийн чанадад томоохон бүтээн байгуулалтын төсөл зэрэг), технологи хөгжүүлэлтэд түлхүү анхаарч эхэлсэн.

1970-аад оны дундаас хэрэгжүүлсэн Хүнд болон химийн аж үйлдвэрлэлийг дэмжих бодлого, Төвлөрсөн худалдаа эрхлэгч зэрэг хөтөлбөр нь үндэсний томоохон үйлдвэрлэгчдийг далайцтай дэмжсэний дүнд Самсунг Хёндэ зэрэг томоохон корпорацууд дэлхийн хэмжээний үйлдвэрлэгч болж тус улсын эдийн засгийн гол зүтгүүр болсон²². Гэвч нөгөө талаар ЖДҮ эрхлэгчид зах зээлээс шахагдах, орлого тэгш бусаар хуваарилагдах зэрэг сөрөг үр дагаврууд гарах болсон учир Засгийн газар 1990-ээд оны сүүлээс нийгэм эдийн засгийн тэнцвэрийг хангах үүднээс уг салбарыг бодлогоор дэмжих болсон. ЖДҮ эрхлэгчдийг дэмжих бодлого хөтөлбөрүүд нь экспорт хийдэггүй ЖДҮ эрхлэгчдийг экспортлогч болгох, экспорт хийдэг ЖДҮ эрхлэгчдийн экспортын потенциалыг дээшлүүлэхэд чиглэж байна. Мөн улс орны эдийн

²⁰ 한국무역협회 전문무역상사 CTCnet (kita.net)

²¹ Yun Hwan Kim, The role of Government in export expansion in the ROK: A revisit, 1994.

²² Мягмар, Д. (2023). БНСУ-ын Засгийн газраас үндэсний үйлдвэрлэл, экспортоо дэмжиж буй хэлбэрүүд, Олон улс судлал сэтгүүл, №115, х.48-62,

засгийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх үүднээс шинэ технологи, инноваци бүхий гарааны бизнес, мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих болжээ.

3. 20-ийн бүлэгт гишүүнээр элссэн 2000 оны эдийн засгийн нөхцөл байдал

Хүснэгт 3. БНСУ-ын эдийн засгийн хөгжлийн харьцуулсан үзүүлэлт

Үзүүлэлт	1960 он	2000 он
1 Нэг хүнд ноогдох ДНБ-ий хэмжээ /\$/	158	12.257
2 Экспортын хэмжээ /мянган ам. доллар/	32.827	172.267.519
3 Аж үйлдвэрлэлийн бүтэц /%/ (ажил эрхлэлтийн статистик)	ХАА – 83	ХАА – 8.9
	Үйлдвэрлэл– 4.5	Үйлдвэрлэл – 20.2
	Үйлчилгээ – 12.5	Үйлчилгээ – 68.9
4 Технологийн түвшин	тодорхойгүй	Дижитал, нано зэрэг орчин үеийн дэвшилтэт
5 Хүний хөгжлийн индекс	тодорхойгүй	0.83 very high

Эх сурвалж: *Human Development Index | Human Development Reports (undp.org)*, *한국무역통계 총관 - K-stat 수출입 무역통계 (kita.net)*, *우리나라의 산업 구조 (naver.com)*, *South Korea GDP Per Capita 1960-2024 | MacroTrends*

Дөчин жилийн хугацаанд тус улсын нэг хүнд ноогдох ДНБ-ий хэмжээ 77 дахин, экспортын хэмжээ 5.247 дахин өсжээ. Бага, дунд орлоготой орнуудын аж үйлдвэрлэлийн салбарт ХАА-н үйлдвэрлэл дийлэнх хувийг байдаг. Энэ жишгээр 1960 онд тус улсын нийт ажиллах хүчний 83 хувь нь ХАА-н салбарт ажиллаж байсан бол 2000 оны байдлаар ажиллах хүчний 70 хувь нь үйлчилгээ, 20 хувь нь үйлдвэрлэл, үлдсэн 9 хувь нь ХАА-н салбарт хамрагдах болжээ. 1960-аад онд ХАА-н анхан шатны боловсруулах

үйлдвэрлэл, түүнтэй холбоотой технологи, арга барил эзэмшиж байсан бол 2000 онд дижитал, нано, химийн орчин үеийн технологиудыг эзэмших болсон. Хүнс болон валют, санхүүгийн хомсдолоос үүдэн иргэдийн амьдралын чанар туйлын муу байсан бол энэ хугацаанд хүний хөгжлийн индексээр (0.83 very high) өндөр хөгжилтэй орнуудын жишигт хүрчээ.

Дампуурлын ирмэгт, хандив тусламжаар оршин тогтнож байсан тус улс экспортод чиглэсэн аж үйлдвэрлэлийг төрийн бодлогоор

тууштай дэмжсэний хүчинд 40 жилийн дотор нийгэм, эдийн засгийн хөгжлийн хувьд хөгжингүй орны жишигт хүрчээ. Улмаар дэлхий дахины тулгамдсан асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхэд оролцдог, олон улсын тавцанд нөлөө бүхий хандивлагч улс болж, байр суурь нь огцом дээшилсэн. Тухайлбал, 1996 онд нийгэм, эдийн засгийн өндөр хөгжилтэй, хандивлагч орнуудын бүлэг болох Эдийн засгийн хамтын ажиллагаа ба хөгжлийн байгууллагад (OECD), 2000 онд дэлхийн дахины эдийн засаг, санхүү, байгаль орчны тулгамдсан асуудлуудыг хэлэлцэн зөвлөлддөг их 20-ийн бүлэгт (G20) гишүүнээр тус тус элсжээ.

БНСУ-ын эдийн засгийн хөгжилд тус улсын экспортыг дэмжих тогтолцоо гол үүрэг гүйцэтгэсэн. Засгийн газар нь экспортод чиглэсэн аж үйлдвэрлэлийг хөгжлийн замаар сонгосон 1960 оноос эхлэн бодлого хөтөлбөр төлөвлөх үүрэгтэй яам болон хэрэгжүүлэгч агентлагуудаас бүрдэх экспортыг дэмжих тогтолцоог бүрдүүлжээ. Тухайлбал, Худалдаа, хөрөнгө оруулалтын агентлагийг 1962 онд, Эксим банкийг 1964 онд, Туршилт судалгааны хүрээлэнг 1969 онд, Зээлийн батлан даалтын санг 1974 онд, Худалдааны даатгалын корпорацыг 1992 онд тус тус байгуулжээ. Эдгээр агентлагууд нь өнөөдөр тус улсын экспортыг хариуцсан Үйлдвэрлэл, худалдаа, нөөцийн яамны харьяанд ажиллаж байна. Экспортыг дэмжих

тогтолцооны гол ажлыг гүйцэтгэдэг, олон жилийн туршлагатай, дотоодод өндөр нэр хүнд бүхий мэргэшсэн агентлагуудгүйгээр тус улсын экспортыг төсөөлөхөд бэрх.

Дүгнэлт

Солонгосын дайны дараа хандивлагч орнуудын зээл тусламжид түшиглэн оршин тогтнож байсан БНСУ нь газар зүйн ашигтай байршил, цаг уурын таатай нөхцөл, олон тооны ажиллах хүч, төрийн ухаалаг, оновчтой, тууштай бодлогын үр дүнд 40 жилийн дотор хөгжингүй орнуудын жишигт хүрч чаджээ. 1960 оноос хэрэгжүүлсэн хөнгөн болон хүнд аж үйлдвэрлэлийг дэмжих бодлого хөтөлбөрүүд үр өгөөжөө өгч, аж үйлдвэрлэлийн потенциал нэмэгдэхтэй зэрэгцэн 1975 оноос үйлдвэрлэгчдэд гадаад зах зээлийн орон зай гаргах, гадаад худалдааны суваг нээхэд чиглэсэн бодлого хэрэгжүүлсэн. Эдгээр бодлого хөтөлбөрүүдийн үр дүнд экспортын хэмжээ огцом хурдтай өсөж, эдийн засаг эрчимтэй тэлсэн. Аж үйлдвэрлэл болон экспортын потенциал их хэмжээгээр нэмэгдсэн учир 1990-ээд оноос эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулж либералчлах, технологи инновацыг дэмжих бодлого барих болсон. Мөн дотоод зах зээлд корпорацууд давамгайлах болсон учир 1990-ээд оны дундаас жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг төрөөс бодлогоор дэмжих болжээ. Хүчирхэг үйлдвэрлэгч,

экспортлогч улс болоход дараах хэдэн хүчин зүйлс гол нөлөө үзүүлжээ. Үүнд:

1. БНСУ-ын Ерөнхийлөгч Пак Жөн Хий харилцан уялдаа холбоо, үр өгөөж багатай ажиллаж байсан төсөв, татвар, аж үйлдвэрлэл, гадаад худалдааны эрх мэдэл бүхий байгууллагуудыг нэг удирдлага дор төвлөрүүлэн харилцан уялдаатай, зохион байгуулалттайгаар, нэг зорилгын хүрээнд үр ашигтай ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлж өгсөн. Энэ нь ирээдүйн экспортыг дэмжих тогтолцооны суурь болсон.
2. Эдийн засгийн төлөвлөлтийн хороо эрдэмтдийн судалгааны багийг дэргэдээ ажиллуулж байсан нь шинжлэх ухааны үндэслэл бүхий, тооцоо судалгаатай, оновчтой шийдвэр гаргахад тус болсон. Өнөөдөр ч БНСУ-ын худалдаа, эдийн засгийн судалгааны хүрээлэнгүүдийн санал зөвлөмж тус улсын бодлого шийдвэр гаргалтад чухал нөлөө үзүүлдэг.
3. Тууштай байдал нь амжилт олох үндэс болсон. 1960-аад оноос эхлэн аж үйлдвэрлэлийг дэмжих бодлого хөтөлбөр хэрэгжүүлэх явцдаа экспортыг дэмжих үүрэгтэй мэргэшсэн агентлагуудыг байгуулж, бүтэц зохион байгуулалт, чиг үүргийг нь өөрчлөлгүй өнөөг хүрчээ. Олон жил нэг чиг үүрэгтэй ажиллаж, салбартаа мэргэшсэн,

асар их туршлага хуримтлуулсан мэргэшсэн агентлагууд нь экспортыг дэмжих ажилд гол үүрэг гүйцэтгэж байна.

Цаг үетэйгээ нийцсэн, ухаалаг, оновчтой бодлого шийдвэрүүд нь амжилт олоход гол нөлөө үзүүлсэн. Ажиллах хүчний хямд, арвин нөөцөд тулгуурлан хөнгөн үйлдвэрлэлийг дэмжсэн, эдийн засгийн өндөр өгөөж, өндөр бүтээмж бүхий хүнд болон химийн аж үйлдвэрлэлийг дэмжсэн, гадаад худалдааны давуу эрхийг цөөн хэдэн корпорацад төвлөрүүлсэн, эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулж, либералчилсан зэрэг нь бүгд цаг үетэйгээ уялдсан, оновчтой шийдвэрүүд байж, эдийн засгийн өсөлтийг авч ирсэн.

ЭХ СУРВАЛЖ

1. Lauren Ferry, Cleo O'Brien-Udry, The possibilities and limits of international status: Evidence from foreign aid and public opinion, 2024.
2. Classifications of Countries Based on Their Level of Development: How it is Done and How it Could be Done; by Lynge Nielsen; IMF Working Paper 11/31; February 1, 2011
3. Milan Lajciak "South korean development model", 2016.
4. pdacy151.pdf (usaid.gov)
5. South Korea GDP Per Capita 1960–2024 | MacroTrends
6. 우리나라의 산업 구조 (naver.com)
7. Мягмар,Д. (2023). БНСУ-ын Засгийн газраас үндэсний үйлдвэрлэл, экспортоо дэмжиж буй хэлбэрүүд, Олон улс судлал сэтгүүл, №115, х.48–62,
8. 경제기획원 (naver.com)
9. Yun Hwan Kim, The role of Government in export expansion in the ROK: A revisit, 1994.
10. 경제개발계획 (naver.com)
11. Jaedo Choi, Andrei A. Levchenko, The long-term effects of industrial policy, NBER Working paper 29263, 2022.
12. 신용보증기금 (kodit.co.kr)
13. Home : Korea Eximbank
14. Mah, Jai S., "Export Promotion and Economic Development of Korea", Journal of World Trade, February 2006.
15. 중화학공업 (naver.com)
16. 신장철, "한국의 종합상사제도에 관한 연구", 2017.
17. 조동성, 한국의 종합무역상사 (수정판), 법문사, 1987.
18. Role of Subsidy in Evolution of Platform Intermediary: Focus on Government Support for General Trading Companies, Chanh Park, 2022. E-Trade Review, Vol.20, No.4 (November 30, 2022) pp.63–87.
19. 한국무역통계 총괄 – K-stat 수출입 무역통계 (kita.net)
20. 한국무역협회 전문무역상사 CTCnet (kita.net)
21. Human Development Index | Human Development Reports (undp.org)

20-Р ЗУУНЫ МОНГОЛЧУУДЫН ДУРСАМЖ ДАХЬ СОЛОНГОСЧУУД¹

Ж. Баттөр²

battur_j@num.edu.mn

Abstract

The intricate history of Korea and Koreans in the 20th century finds its essence predominantly in the oral histories and memories preserved by Mongolians whose fates are intertwined with Korea.

These biographies of individuals lead us to unexplored territories in historical studies, shedding light on aspects less known to us. For instance, during the mid-1940s, the account of a Korean woman who disguised herself as a man to avoid divorcing her husband, enlisted in the Kwantung Army of the Imperial Japanese Army, presents a rare occurrence in war history. Additionally, the life story of a Korean teacher who revitalized harp music, a tradition forgotten by Mongolians for many centuries, holds a significant place in the Mongolian national music heritage. This narrative unfolds not only as a history of individuals but also as a tale of musical instruments and cultural exchanges. Memories of Korean Mongolian diplomats also require us further research and investigation.

Түлхүүр үг: Солонгосчууд, Японы олзлогдогч, ятга, Ким Зон ам, дипломат харилцаа

Удиртгал

Ерөнхийдөө 20-р зууны эхнээс буюу Солонгос улс Японы колони болсон цагаас Солонгосчууд бусад улс орон руу олноороо гарч эхэлсэн бөгөөд тэдгээр иргэдээс цөөн хүн Монгол улсад ирж байв. Миний бие энэ сэдвээр судалгаа хийж, эрдэм шинжилгээний өгүүлэл, нэг сэдэвт зохиол бичсэн нь БНСУ-д хэвлэгдсэн юм⁴. Тэрхүү

судалгаанд голлон 1910-1930-аад оны үеийг хамруулан бичсэн.

Харин энэхүү өгүүлэлд 1940-өөд он, 1960-аад он болон 1980-аад оны сүүл буюу нэгтгэж хэлбэл 20-р зууны дунд үеэс сүүлч үе хүртэлх 3 хүний талаарх дурсамж, дуртгалыг аман түүхэнд тулгуурлан бичив. Энд заавал тэмдэглэх ёстой зүйл бол аман түүх нь хэдийгээр түүх бичлэгт өргөн ашигладаг

¹ This work was supported by the Core University Program for Korean Studies of Ministry of Education of Republic of Korea and the Korean Studies Promotion Service at the Academy of Korean Studies (AKS-2022-OLU-2250006)

² МУИС, УТСОУХНУС-ийн Олон улсын харилцааны тэнхимийн дэд профессор, доктор

³ Жамъянгийн Баттөр, XX зууны Монгол Солонгосын харилцаа. МК Медиа хэвлэлийн газар. 2011. 127-150. (Солонгос хэлээр.)

ч тодорхой хэмжээнд хязгаарлагдмал арга зүй юм. Өөрөөр хэлбэл аман түүх нь хувь хүмүүсийн дурсамж, хууч ярианд тулгуурладаг тул түүнийг цааш цаашдаа нотлох, дэлгэрүүлэх, баримтжуулах, гүнзгийрүүлэх ажлуудыг үргэлжлүүлэн хийх шаардлагатай болдог. Тиймээс миний энэхүү судалгаа нь цаашид улам бүр нягтлан архивын хөдөлшгүй баримтуудаар илүү баяжуулах зайлшгүй зорилгуудыг тээж байна.

Монголчуудын хувьд хууч яриа, хууч, аман түүх гэхчлэн эртнээс нааш оршсоор иржээ. Аман түүхийн нэг томоохон хэсэг нь хувь хүмүүсийн намтар, дурсамж байдаг. Аман түүх нь аливаа үйл явдлыг тодруулах, эрэл хайгуул хийхэд ихээхэн тус нэмэртэй байдаг. Дэлхий дахинаа төдийгүй Монголчуудын дунд ч аман түүхийн хэв маяг бүр эрт үеэс нааш оршсоор ирсэн байна. Харин орчин үеийн арга зүйгээр аман түүхийг судлах ажил 1930-аад оноос эхэлсэн бололтой. Тухайлбал, Монгол судлалын нэрт эрдэмтэн Ж. Цэвээн 1931 онд “Монгол газар орны байдал” хэмээх өгүүлэлдээ “Хүн төрөлхтний олон аймаг овог ба тэдгээрийн соёл, боловсрол, амьдралга, зан суртал, ёс заншил мэтийг шинжлэх” хэмээн онцлоод цааш нь хүн төрөлхтний боловсрол, соёл, түүх, харилцаа гээд өнгөрсөн одоогийн өргөн хүрээнд авч үзээд, шинжлэх ухааны социологи, хэл шинжлэх, хүн судлалтай холбоо хамааралтайгаар авч үзэх хэрэгтэй гэжээ⁴.

⁴ Л.Санчир, Л. (2021). Ц. Дамдинсүрэнгийн

Харин дэлхий дахинаа аман түүхийг орчин үеийн Түүхийн шинжлэх ухааны нэгэн салбар болгосон эрдэмтдийн тоонд АНУ-ын түүхч Аллан Нэвинсийг дурддаг. Тэрээр 1938 онд хэвлүүлсэн “The Gateway to History” бүтээлдээ “Өнгөрсөн 60 жилийн хугацаанд улс төр, эдийн засаг, соёлын салбарт оролцсон нөлөө бүхий америк хүний дурсамжийг бичиж тэмдэглэх, цуглуулах, хадгалах үйл ажиллагаа зохион байгуулах байгууллага хэрэгтэй хэмээн бичиж байжээ. Аллан Нэвинс энэхүү байгууллагаа байгуулахын тулд 10 жил хөөцөлдсөний эцэст Bancroft сангийн дэмжлэгтэйгээр 1948 онд Колумбын их сургуульд “Аман түүхийн судалгааны танхим” байгуулсан.⁵ Гэхдээ аман түүх нь улс орон болгонд эртнээс нааш оршсоор ирсэн бөгөөд одоо өөрийн гэсэн салбаруудтай, сэтгүүлтэй, холбоо нийгэмтэй болон хөгжсөөр байгаа юм. Энэхүү өгүүллийг аман түүхийн аргад тулгуурлан бичихийг оролдсон бөгөөд 20-р зууны дунд болон сүүл үеийн Монголд ирж байсан Солонгосчуудын амьдрал үйлсийг гурван дуртгал, дурсамжид тулгуулан бичсэн болно.

аман өгүүллэг аман түүх болох нь, *Studia Historica, Institute Historiae Ethnologici, Academie Scientiarum Mongoli. Tomus L, Fasciculus 1-19. 2021.203-р тал, Уб.*,

⁵ Мөн тэнд.

Судалгааны үндсэн хэсэг

1. Олзлогдсон Япон цэргүүдтэй хамт Монголд ирсэн Солонгос хоёр⁶

Энэхүү түүхийг би 1990-ээд оны үед Лувсан-Очир хэмээх нэгэн ахмад настнаас бичиж авсан юм. Түүнийг ярьсныг баталж нотлох зарим нэг бүтээл буйг энд дурдъя.⁷ Учир нь яг энд өгүүлэх сэдвийн тухай баримтыг архиваас эрж хайх нь хязгаарлагдмал байсан бөгөөд үнэндээ үй олон баримт дундаас нэг л үйл явдлыг эрж олно гэдэг өвсөн дундаас зүү хайж бэдрэхтэй адил хэцүү адармаатай ажил юм. Магадгүй миний хайгуул дутуудсан байж болно, эсвээс Лувсан гуайн өгүүлснийг нотлох баримт нэлээд гүн далд газар хадгалаастай ч байж болно.

Энэхүү баримт нь нэлээд ховор баримтад орох ч Монгол Солонгос хоёр орны харилцаанд юмуу, Монгол Японы харилцаанд ч шууд холбогдохгүй ч байж магадгүй юм. Харин уг дайнд аргагүйн эрхэнд хүчин мөхөстөж дайчлагдсан эгэл хүмүүсийн амьдралын түүх гэвэл үнэнд дөхөж ойртоно. Тийм учраас өнгөрсөн хугацаанд судлаач миний

санаанд үе үе орохын хэрээр хүмүүсээс асуун лавлаж, архивд хайсан боловч амжилтыг олсонгүй. Тиймд энэхүү түүх хүмүүст танигдалгүй таг мартагдахаас урьтаж өөрийн санаанд буй хэр хэмжээгээр энд буулгалаа. Магадгүй хэзээ нэгэн цагт хэн нэгэн судлаач илүү сайн судалж шинжлээд далайцтай том ном өгүүлэл туурвиж болох юм, эсвээс аль нэг орны юмуу, хэд хэдэн орны уран бүтээлчид нийлээд дайн байлдаан, хүмүүний хувь тавилан, гэр бүл, олзны амьдралын тухай кино, түүхэн роман зэргийг туурвих ахул санаа сэдэл авах ч юм билүү хэмээн бодож энд оруулав.

Уг түүх нь Дэлхийн 2-р дайны төгсгөлд Монгол-Зөвлөлтийн арми Японы Квантуны армийг ялж Зүүн Хойд Азийг Японы колоничлол, милитаризмаас чөлөөлсөн үйл явцтай шууд холбогдоно. Түүнчлэн Японы колони байсан Солонгосын эгэл жирийн иргэд үй олноороо энэ дайны хөлд нэрвэгдэн гашуун зовлон туулсан бөгөөд энд өгүүлэх түүх бол тэр их туулсан зовлон бэрхшээлийн нэг л хэсэг юм.

1945 оны 8-р сарын 8-нд ЗХУ Японд дайн зарлаж, дайны ажиллагааг эхлүүлсэн бол Монгол улс (Тухайн үеийн албан ёсны нэршлээр БНМАУ) хоёр өдрийн дараа буюу 8-р сарын 10-ны өдөр Японд дайн зарласан юм. Энэ үед Японы цэргийн үлэмжхэн их хүч Монгол улсын зүүн хязгаар, Хятадын хилийн дагуу байрлаад байсан билээ. Ийнхүү дайн өрнөж, 1945 оны сүүл

⁶ Лувсан-Очир, Ч. (1998). Дайны дараа Монголд байсан япончуудын хувь заяа, УБ.,

⁷ Тухайлбал, Ж. Урангуа, Б. Эрдэнэбилэг “Дайны золиос болсон хүмүүс”, УБ. 2018. Монгол улсын их сургууль, Тагнуулын Ерөнхий газар, Шова Эмэгтэйчүүдийн их сургуулиас хамтран эрхлэн хэвлүүлсэн. Энэ номын 8-р бүлэг нь “Олзлогдсон Япончуудтай ажиллаж байсан Монголчуудын дурдатгалаас” гэсэн гарчигтай. Уг бүлэгт есөн Монгол хүний дурсамж яриаг сийрүүлэн буулгасан.

гэхэд Япон улс бүрэн ялагдсан юм. Ингээд Японы армийн 575,000 гаруй цэргийг асар олон буу зэвсэг, техникийн хамт олзолсон. Үүнээс 12,000 гаруй цэргийг Монголд ирүүлсэн билээ. Энэхүү Японы 12,000 олзны цэргийг Монголд ирүүлснээр голлон барилга байгууламжуудыг ихээр барьж байгуулсан. Ялангуяа дайны дараа Улаанбаатар хотыг ид барьж байгуулж байсан тул нэлээд олон тооны барилгыг нийслэлд барьжээ. Тухайлбал, өнөөгийн Улаанбаатар хотын нүүр царай гэж хэлж болох Засгийн газрын Ордон, Улсын Дуурь бүжгийн Академик театр, Гадаад харилцааны Яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын барилга, хуучнаар 1-р төрөх эмнэлэг гээд олон барилга, байгууламжуудыг барьж босголцсон юм.

Монголд олзлогдон ирсэн, ирээд барилга байгууламж барьж, хүнд хүчир гурван жилийг ардаа орхисон энэхүү түүх нь Монгол, Японы харилцаанд нэлээн өвөрмөц байр суурийг эзэлдэг бөгөөд Монголд байсан Япончууд хожим нь Монголтой холбоотой байсаар ирсэн юм. Японы эдгээр аман түүх, яриа, дурсамж, бичлэг зэргийг нэлээд олноор хэвлэсэн болно. Гэхдээ би энд арай өөр түүхийг өгүүлье гэж бодож байна.

Өөрөөр хэлбэл, өмнө дурдсан ахмад настны ярьсан түүх болно. Тэрбээр олзны Япончуудыг Монголд ирэхэд харгалзагч, хянагч зэрэг ажлыг хийж байсан цэрэг армийн буюу хүчний байгууллагын хүн юм.

1990 онд Монголд ардчилсан хувьсгал ялж, дэлхийн улс орнууд, түүний дотор хуучин хөрөнгөтөн гэгдэж байсан орнуудтай нээлттэй харилцах болсноор иргэд хоорондоо чөлөөтэй харилцаж, зорчих болсон билээ. Монголд ажиллаж байсан олзлогдсон Япон цэргүүдийн амьдрал ахуйд энэхүү Чөлөөлөх дайн болон тэдний олзлогдсон хийгээд улмаар Монгол улсад гурван жилийн турш ажиллаж амьдарсан нь томоохон ул мөрөө үлдээсэн нь тодорхой бөгөөд энэ талаарх судалгаа, сонирхол хоёр орны эрдэмтэд судлаачид төдийгүй иргэдийн хооронд нэмэгдсэн болно. Тиймээс тухайн үед энэ сэдвээр цөөнгүй ярилцлага, дурсамж, ном туурвил гарсан юм. Үүний нэг нь Лувсан-Очир гуайн энд өгүүлж буй дурсамж өгүүлэл юм.

Тэрбээр уг жижгэвтэр дурсамждаа Япон цэргийн олзлогдогсод хэрхэн Монголд ирсэн, хаана хаана байрлаж байсан, ямар барилга байгууламжийг барьж байгуулсныг нэлээн тодорхой өгүүлсэн болно. Түүний нэг гол санаа нь тухайн үед Монголын хэвлэлд, ялангуяа Япончууд дээрх барилга байгууламжуудыг “Япончуудаар бариулсан, Япончууд л барьсан” гэж нэршил, нэр томьёо ихээхэн түгээмэл байгааг шүүмжилж, үгүй, бид хамт барилцсан, дан ганц япончуудын бүтээн байгуулсан ажил биш юм. Харин Монголчуудын удирдлага дор Япончууд уг бүтээн байгуулалтын

ажилд оролцсон тул, “Хамтран барилцсан” гэж нэрлэх нь зүйтэй гэж асуудалд нэлээн өргөнөөр хандахыг уриалж байсан юм.

Түүний номд байсан нэгэн сонирхолтой үйл явдлыг уншиж би Лувсан-Очир гуайтай уулзаж байсан билээ. Ерөнхийдөө, олзлогдсон цэргүүдийг бусад улсын нэгэн адил Монголын тал ч эмнэлгийн үзлэгт оруулдаг байж. Ингээд, хэрэв ямар нэгэн өвчтэй юмуу, эрүүл мэндийн хувьд эмчилгээ шаардлагатай олзлогдсон цэргийн албан хаагч байвал боломжийн хэрээр эмчилж, сувилдаг байсан байна. Мөн ариун цэврийн байдлыг сахиулахын тулд халуун усанд оруулдаг байжээ. Гэтэл Лувсан гуай дээр харгалзагч нарын нэг нь ирж “нэгэн Япон цэрэг үзлэгт ч орохгүй, асуусан асуулт болгонд нь эрүүл гээд байна” гэсэн рапорт өгсөн аж. Мөн тухайн цэргийг бусад цэргүүдтэй усанд орохоос цааргалж, эсэргүүцэж буй тухай мэдээ рапорт ирсэн байна. Ингээд түүнийг яаралтай арга хэмжээ авахыг хүсжээ.

Тухайн үеийн журмаар олзлогдсон Япон цэрэгт хүч хэрэглэж болохгүй, хатуу харгис хандаж болохгүй, илүү хүнлэг хандахыг зааварчилсан тул ерөнхийдөө олзлогдогсод болон Монголын харгалзагч нарын хооронд хурц зөрчил байсангүй. Ямар нэгэн асуудал гарвал илүү хүнлэг аргаар шийдвэрлэсээр ирсэн байжээ. Ер нь сүүлд гарсан

дурсамж тэмдэглэлд Монгол талын харгалзагч нар харгис хэрцгий хандаж байсан гэх өгүүлбэр байдаггүй. Харин ч тухайн үед Монгол харгалзагч нар, цэргийнхэн олзлогдогсод боломжийн хэрээр тусалж байсныг тэмдэглэсэн байдаг. Тухайлбал, зарим хүний дурсамжид шөнө даараад байсан тул харгалзагч нь түүнд тоосго халааж байгаад өгдөг байсан, уг цэрэг хөлийхөө хавьцаа уг халуун тоосгоо тавиад унтдаг байсан тухай гардаг. Иймэрхүү хандлага, харилцааны талаар нэлээд гардаг. Тиймээс өмнө өгүүлсэн эрүүл мэндийн үзлэгт орохгүй, усанд орохгүй байгаа уг цэргийн хэргийг шийдэхийн тулд түүнтэй хэлмэрчээр дамжуулж ганцаарчлан уулзсан аж. Уулзалтын үед харгалзагч, Япон олзлогдогч, Лувсан-Очир гуай гурав л байжээ. Эхний үед уг олзлогдогч нэр усаа хэлсэн ч яагаад эрүүл мэндийн үзлэгч орохгүй бас халуун усанд орохгүй байгаа шалтгаанаа хэлэхгүй дув дуугүй байж. Түүнийг хэрэв одоо үзлэг, халуун усанд орохгүй бол шийтгэл онооно гэж сүрдүүлж үзэж. Тэгтэл хариуд нь дуугарсангүй. Бас хоолыг нь хасна ч гэж сүрдүүлж үзсэн байна. Мөн л дуугарсангүй. Тэгээд өөрөөс нь ямар хүсэлтэй байгааг нь асуужээ. Энэ үед л нөгөө япон олзлогдогч ам нээж, халуун усанд зөвхөн ганцаараа, бусад цэргүүдтэй хамт орохгүй байхыг хүссэн байна.

Эмчийн үзлэгийн талаар асуухад дуугарсангүй. Харахад харьцангуй

эрүүл, залуу хүн байсан тул энэ удаад эрүүл мэндийн үзлэгт оруулахгүй байхаар шийдэв. Гэхдээ шалтгааныг нь олж чадаагүй ч гэсэн энэ уулзалт ингээд дууссан байна. Учир нь олон зуун олзлогдсон цэргүүдтэй ажиллаж байхад нэг хүний асуудлыг шийднэ гэдэг амаргүй байсан. Мөн түүнчлэн тэр олзлогдогч ажлаа шаламгай хийдэг гэсэн харгалзагч нарын яриа ч нөлөөлсөн буй заа. Яагаад ингээд байгааг нь мэдэхээр уг олзлогдсон цэргийг гаргаж явуулсны дараа харуулд түүнийг анхааралтай ажиглахыг даалгасан байна.

Арваад хоног өнгөрсний дараа Лувсан гуай нөгөө ажиглах үүрэг авсан харгалзагчийг дуудаж, байдал ямар байгааг асуужээ. Харгалзагч түүнд хэлэндээ: “Онц зүйл ажиглагдаагүй, ажлаа шаргуу сайн хийдэг болох”-ыг яриад “харин нэг цэргийг үргэлж дагаж явдаг” гэж ярьсан байна. “Үргэлж дагаж явдаг нь ямар учиртай вэ?” гэж дахин лавлахад “Энэ цэрэг өөр нэг цэргийг хоолон дээр ч үргэлж дагаж хажууд нь суудаг, өглөө, өдөр, орой алхам ч холддоггүй юм, бас зэргэлдээ унтдаг” гэж хариулж.

Лувсан гуайд эхний цэрэг нь ноён, энэ цэрэг түүний зарц нь юм болов уу гэж бодогдоод өнгөрчээ. Удалгүй эрүүл мэндийн үзлэгт ахин орох шаардлага гарав. Учир нь цөөнгүй цэрэг уушгины хатгаа туссан байв. Гэтэл нөгөө цэрэг мөн л эсэргүүцэв. Тэгэхэд нь дахин уулзжээ. Ингээд “Хэрэв эрүүл мэндийн

үзлэгт орохгүй бол таныг ганцааранг чинь хорих болно” гэж анхааруулсан байна. Нөгөө олзны цэрэг дуугүй сууж, сууж байснаа гэнэт өөрийг нь эмэгтэй эмчид үзүүлэхийг хүсжээ. Гэвч яагаад заавал эмэгтэй эмчид үзүүлэх хүсэлтэй байгаа гэдгээ ч хэлсэнгүй.

Ингээд удалгүй түүнийг эмэгтэй эмч дээр үзүүлсэн байна. Учир нь уг олзны цэрэг хатгаа туссан тул зайлшгүй эмчид үзүүлэх ёстой байжээ. Ийнхүү үзлэг дууссаны дараа олзны цэрэгт эм өгөөд явуулсан бөгөөд харин Лувсан гуай эмчийг дуудаж уулзжээ. Гэтэл тэр эмч гайхсан янзтай чимээгүй сууж байснаа “Энэ хүн чинь эмэгтэй хүн байна” гэж хэлсэн бөгөөд мөн энийг сонссон Лувсан гуай болон тэд нар мэл гайхсан аж.

Үнэндээ уг эмчийн хэлсэнд үгэнд ч итгэсэнгүй. Учир нь тухайн үед бүх олзны цэргийн албан хаагчид нь эрэгтэй хүмүүс байсан юм. Гэтэл тэр олон олзлогдогсдын дунд эмэгтэй хүн ороод явж байна гэж хэний ч санаанд багтахгүй нь ойлгомжтой.

Ийнхүү уг цэргийг ганцаарчлан байлгаж, байцаалт авах болсон байна. Тэр олзны цэрэг ч өөрийнх нь нууж байсан нууц нэгэнт илэрсэн тул байцаалтад нэлээд дэлгэрэнгүй хариу өгөх болжээ.

Лувсан гуайн санаж буйгаар үнэндээ тэр олзны цэрэг нь Солонгос хүн байсан бөгөөд үргэлж дагаж явж байсан хүн нь нөхөр нь болж таарчээ. Японы арми дайны эхний үеэс дунд үе

хүртэл голлон Япон цэргүүд байлдаан тулаанд оролцож байсан тул яваандаа олон Япон цэрэг алагдаж, шархдан цэргийн хүчин хүрэлцэхгүй болсноор өөрийн эрхшээл дор байсан Солонгос зэрэг орны эрчүүдийг цэрэгт илгээх болжээ. Ингэж хүчээр шахуу цэрэгт татагдсан залуусын дунд энэхүү Солонгос эмэгтэйн нөхөр нь багтсан аж. Гэр бүл болоод удаагүй байсан тэднийх нөхөр нь нэгэнт цэрэгт татагдсан тул тэр Солонгос эмэгтэй эр нөхрөө дагаж цэрэгт бүртгүүлэн хамт явжээ. Ингэхдээ эмэгтэй хүн гэдгээ мэдэгдэхгүйн тулд эр хүний хувцас хунар өмсөж, гадна төрхөө ч эрэгтэйлэг харагдахуйцаар “дүрд хувирчээ”. Үг дуу цөөтэй, хааяахан л хэд гурван үг хэлдэг нь ч тус нэмэр болж, дээр нь Японы армийнхан түүнийг Япон хэл бараг сураагүй, дээр нь хэл яриа муутай Солонгос хүн гэж бодсон уу, тэгсгээд тоохгүй орхижээ.

Дээр нь ширүүн дайн тулаан өдөр өнжилгүй гаарч, үхэл амьдралын зааг дээр амьдарч явсан цэргийнхэн түүнийг ганцааранг нь айхтар ажиж харах ч боломж төдийлөн хомс ховор байсан нь мэдээж.

Ингээд эр хүн шиг аяглан дайны байлдааны дундуур өөрийгөө эмэгтэй хүн гэдгийг огт мэдэгдэлгүй байж чадсан төдийгүй, дагаж явсан эр нөхөртөө ч анхаарал тавьж, асарч явсан байна. Яагаад ийм алхам хийх болсныг нь асуухад “Нөхрийгөө цэрэгт татагдах үед түүнд ямар нэгэн өөр бодол

төрөөгүй, гагцхүү нөхрөөсөө л холдож болохгүй” гэсэн бодол л толгойд нь бат суусан аж. Хэрвээ гэр бүл болоод удаагүй тэр хоёрт энэ том дайн тулааны хөл үймээнд нэг л салбал эргэж уулзах боломж байхгүй ч бодсон буй заа.

Ингэж дайн тулаанд орж явтал Монгол Зөвлөлтийн арми Квантуны армийг бут цохисноор нөхөртэйгөө хоёул олзлогдож, улмаар Монголд ирж хамтдаа нэг тасагт хуваарилагдаж, барилга байгууламжин дээр ажилласаар иржээ.

Монголын талын хувьд энэ хэргийг ерөнхийд нь хаалттай байлгахаар шийдсэн байна. Учир нь олзлогдсон цэрэг гэдэг бол нэгэн төрлийн эрх мэдлээ хасуулсан хоригдол гэж хэлж болно. Тийм учраас олон нийтэд дэлгэх нь угаасаа хууль зөрчсөн хэрэг байв.

Монголын талын ажлыг эрхэлсэн хүмүүс ярилцаж байгаад нэгэнт энэ хүртэл яваад ирсэн хүмүүсийг бас ажил төрлөө сайн хийж байгаа гэдгийг анхаарч нэг бригадад хэвээр нь ажиллуулсан бөгөөд тэр эмэгтэйг гал тогооны ажил, цэвэрлэгээ зэрэг арай хөнгөн ажил хийлгэхээр шийдвэрлэжээ. Мөн ганцаарчилж усанд орох, эмэгтэй эмчид үзүүлэх гэсэн хүсэлтийг нь хүлээж авсан аж. Ийнхүү Япон цэргүүдийн хоригдож хугацаа дуусаж, нутаг буцах үед нь Лувсан гуай биечлэн уулзаж тэр гэр бүлийг сайн сайхан амьдрахыг хүсэж ерөөсөн гэдэг. Тэр хоёр ч мөн цаашид Япон явахгүй, харин Солонгос юмуу, Манжуурт үлдэх

хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн байна. Харамсалтай нь тэр хоёрын тухай сураг тийнхүү тасарсан юм. Лувсан гуайн хэлж буйгаар Япон олзлогдогсдын дунд цөөнгүй Солонгос гаралтай цэрэг байсан бөгөөд тэдний дийлэнх нь Япон овог хүчээр авсан байсан тул Япон, Солонгосыг ялгахад хэцүү байжээ.

2. Орчин үед ятга хөгжмийг Монголд дэлгэрүүлсэн Солонгос багш

Монгол улсад ятга хөгжих, ятгачдыг дэлхийн тавцанд алдаршуулах үйлсийг гол үндэслэгч нь Солонгосын иргэн Ким Зон Ам багш билээ. 1960 онд (хуучин нэрээр) Хөгжим бүжгийн дунд сургууль “Ятгын анги” шинээр нээж, анхны элсэлтээрээ 16 хүүхэд авсны 12 нь эмэгтэй, 4 нь эрэгтэй хүүхэд байж. Харамсалтай нь тэр үед Монгол улсад ятгыг мэргэжлийн түвшинд заах сургах багш байгаагүй, ятгачны уламжлал үндсэндээ тасарсан байсан тул Хойд Солонгосоос тийнхүү мэргэжилтэн багш авахад хүрсэн байлаа. Гэхдээ ятга нь чухамдаа Монголчууд 20-р зуунд сурч эзэмшсэн хөгжим бус эрт үеэс оршсоор, Монголчууд хөгжимдсөөр ирсэн зэмсэг билээ. Ятга хөгжмийн тухай Монголын хуучны домог хэд хэд байдгаас энд нэгийг жишээ болон оруулав.

Уг домогт өгүүлэхдээ:

“Тоо үзэсгэлэнтэй, сайхан дуулдаг, эрдэм төгс нэгэн эмэгтэй нөхрөө дайн тулаанд явж орон гэртээ ховор үзэгдээд

байхаар нь эв эеийг хичээн, тайван амгалан гэртээ байхыг ятгасан боловч үгэнд нь орохгүй байжээ. Тэгэхэд нь үзэсгэлэнт эмэгтэй эргэж хэзээ ч хүн болохгүй гээд гоо бие нь хөгжим болж, урт сайхан үс нь утас болон, уянгат хоолой нь ая хөг болж ятга хөгжим болон хувирчээ. Нөхөр нь хэчнээн гуйвч эргэж хүн болоогүй ба түүнээс хойш нөхөр нь эхнэрээ санан дурсаж уяхан дуутай уянгат ятгаар хөгжимддөг болсон гэнэ”⁸

Бас Жангар туульд ятгын тухай өгүүлдэг.

Ерэн нэгэн чавхдастай

Ендэр мөнгөн хуураа аваад

татахул

Хулсан дунд өндөглөсөн

Хунгийн дуу гаргаад

Нууран дунд өндөглөсөн

Нугасны дуу гаргаад

Арван хоёр аясаар жишүүрдээд⁹

Солонгос анх Монголоос ятга хөгжмийг авч дэлгэрүүлсэн гэх аман яриа бий. Энэ тухай аман ярианд өгүүлэхдээ: XII-XIII зуунд монголын нэгэн хаан Солонгосын хаанд Энгүүн нэртэй нэгэн хатныг бэлгэнд өгчээ. Тэр бүсгүй ятга хөгжмөөр маш сайн тоглодог байсан бөгөөд Солонгост ятгыг зааж дэлгэрүүлсэн гэдэг. Солонгос улсад ятга хөгжим дэлгэрүүлсэн сайхан үйлсийнх

⁸ Зохиолч Д. Баасанжав гуайгаас бичиж авав. 2005.10.26. Л.Хэрлэнгийн бүтээлээс тодруулан үзнэ үү.

⁹ Хэрлэн, Л. (2022). Монгол хөгжмийн зэмсгийн өв соёл, 55-р тал, Уб.,

нь төлөө Энгүүн хатанд зориулан гэрэлт хөшөө босгосон байна. Энэ хөшөө саяхан болтол байсан гэх бөгөөд монголын төрийн элч төлөөлөгчид, эрдэмтэн мэргэдэд үзүүлэн таниулдаг байснаа 1960-аад оноос хойш үзүүлэхээ больсон гэж ахмад буурлууд дурсан ярьдаг байв.¹⁰

Гэвч цагийн явцад ятгын дэг сургууль тасарсан байна. Өмнө дурдсан Хойд Солонгосын ятгын багш Ким Зон Ам “Миний энэ зааж сургаж байгаа ятга хөгжим нь Монгол улсаас гаралтай бөгөөд энэ хөгжмийг дахин сэргээж та бүгдэд зааж байгаадаа их баяртай байна. Иймээс та нар энэ хөгжмийг сайн сурч, цааш нь улам баяжуулан хөгжүүлэх ёстой юм шүү” хэмээн захидаг байсан гэж түүний шавь нар дурсан ярьдаг. 1960-аад оны үед хэрэглэгдэж байсан 13 чавхдаст 2 ятга Монголын театрын музейд хадгалагдаж байна.

Түүний шавь нарын дуртгалд: “Ученик” гэдэг ганц орос үг мэддэг багш маань Монгол хэл мэдэхгүй, сурагчид нь Солонгос хэл мэдэхгүй, орчуулагчгүй бид нэлээд хэцүүхэн байдалд хичээл эхэлсэн боловч, тэр хүний сургах гэсэн чин хүсэл эрмэлзэл, хүүхэд бидний суралцах гэсэн үнэнхүү сонирхол нийлээд бүтээлч аянд хөлгийн жолоо шуударсан билээ. Багш маань анхны өдөр бидний нэрийг бичиж аваад, маргаашаас нь нэрээр нь дуудаж эхэлж байсан бол гурван сарын дараа ойр зуур ярьдаг, хагас

жил болоход “Үнэн” сониныг захиалан уншиж, чөлөөтэй ярьдаг байсан нь энэ хүний ямар их хөдөлмөрчийн нэгэн тод жишээ буй заа. Ким Зон Ам багш 1962 онд өөрийн эхнэр, 2 хүүгээ авчирснаар одоогийн Улсын их дэлгүүрийн зүүн талын байшингийн 1-р орцны 1-р давхарт 1 тоотод амьдрах болсон. Бид 1962 он гэхэд алдсан нэг жилийн программаа бүрэн нөхөөд зогсоогүй, сургуулийнхаа найрал хөгжимд сууж хөгжимддөг байв.

Ким Зон Ам багш хүүхэд бүртэй тулж ажилладаг, өөрөө зэрэгцэж хөгжмөө бариад л заадаг, заасан зүйлээ заавал сургаж байж өрөөнөөс гардаг байв. Ятгын 16 хүүхэд нь ерөнхий эрдмийн багш Ч.Ичинхорлоо, Т.Цэвэгмэд гэж бидний ээж мэт хоёр сайхан эмэгтэй багштай хоёр ангиас нийлсэн юм. 2 багш маань Ким багшийг харийн хүн гэдгээр нь онцлон биднийг үгэнд нь сайн орж, сайн давтаж, ирээдүйн сайн хөгжимчин болохыг үргэлж захиж сургаж байсан юм. Заримдаа бид Ким Зон Ам багшийгаа гомдоож байсан байх гэж хожим нь бодож харамсдаг юм.

Багш Ким зон Ам сурагчдынхаа гэрээр очин, амьдрал ахуйтай нь танилцан, өөрт нь санаж бодогдсон зүйлээ хоёр багшид маань хэлдэг байв. Нэг удаа Ч.Ичинхорлоо багшид “Лхагвасүрэнгийн гэрийн чийдэн гэрэл нь бага, муу байна” гэж хэлжээ. Багш маань тэднийд байнга очдог боловч үүнийг анзаараагүй тухайгаа

¹⁰ Хэрлэн, Л. 64-р тал

дурсан ярьдаг. Ким Зон Ам багш зарим хүүхдийн гэрт очин эцэг эхийг нь хүлээх зуур түлээг нь хагалж, эцэг эхэд нь ерөнхий болон мэргэжлийн хичээлийг нь сайн хийлгэх зөвлөгөө өгдөг байсан. Хүүхдийг нь эцэг эхэд нь муу хэлнэ гэж байхгүй. Ким Зон Ам багш маань зөвхөн хөгжим заагаад зогсоогүй цаашдын амьдралыг нь үргэлж бодож зөвлөдөг байв.

1966 онд багшийн ажиллах хугацаа дуусаад буцаж, 1967 оны эхээр эргэн ирж биднийг төгсгөсөн юм. Ялангуяа сүүлийн ажилласан жил ятгаар жинхэнэ сонгодог хэлбэрээр хөгжимдөх хамгийн их техник шаардсан солонгос зохиолуудаа заасан юм.

Ли Мен Саны зохиол “Пхеньяны хавар” концертыг Д.Нарантуяа, Д.Алтантуул хоёр тус тусдаа багштайгаа хамт хөгжимдөж төгсгөсөн юм.

Багш минь ийм л хүн байсан даа. Хожим 1970 онд БНАСАУ-д тоглолтын бүрэлдэхүүнд Д.Нарантуяа, Д.Алтантуул хоёрыг очиход хүүхдүүд нь их том болцгоосон, тэр 2-той хүмүүсээс далд ёсолж мэндлэх төдий халтихан уулзсан байсан. Хатуу чанга дэглэмтэй улсын хүүхдүүд нь ч айхтар ойлгоцтой байдаг бололтой. Монголд байдгаас тэс өөр уулзсан гэнэ билээ. Тэр хоёр их гайхсан гэдэг.

Анхны эрэгтэй дөрвөл ятгачид маань 1971 онд манай улсын рок поп урлагийн үндэс суурь болсон “Соёл Эрдэнэ” хамтлагийг байгуулсан намтар түүхтэй хүмүүс юм. Анхны

ятгачдаас ДЗО-ны их наадмууд, олон улсын уралдаан тэмцээнд оролцож алт, мөнгө, хүрэл медалиар энгэрээ мялааж, улсынхаа нэрийг дэлхийн тавцанд цуурайтуулж явсан нь Ким Зон Ам багшийн минь байгуулсан гавьяа, үнэнч хөдөлмөрч хичээнгүй зүтгэлийн үр дүн хэмээн бид бүхэн дурсан санаж явдаг.¹¹

3. Монгол Солонгосын дипломат харилцаа тогтоосон тухай дурсамж

Энэхүү түүхийг Монголын нэгэн дипломатч дурсан ярьсан бөгөөд өмнө нь мэргэжлийн дипломатчийн хувиар хэд хэдэн оронд алба хашиж явжээ. Тэрбээр Монголын гадаад бодлогыг боловсруулах, шинэчлэх чиглэлээр багагүй ажилласан нэгэн билээ. Тийнхүү олон чухал үйл хэрэгт оролцож бүтээлцэж явсан ч төдийлөн нэрээ гаргахыг үл хүсдэг дипломатч байсан бөгөөд энэ удаад ч өөрийнх нь хүсэлтээр нэр усыг нь дурдаагүй болно. Түүний хууч яриан дундаас Монгол Солонгосын харилцаатай холбоотой хэсгийг миний бие олзуурхаж энд оруулав.¹²

1980-аад оны сүүлчээс Монгол улсын гадаад, дотоод байдал төвөгтэй, зөрчилтэй болж ирсэн төдийгүй манай бүс нутагт ихээхэн өөрчлөлт гарсан юм. Юун түрүүнд манай улсын өмөг түшиг, ивээн тэтгэгч болж байсан ЗХУ маань

¹¹ Цэрэндорж, М. (2007). Алтан гадас одонт С. Гончигсумлаагийн нэрэмжит Хөгжим бүжгийн Коллеж, 161-162-р тал. Уб.,

¹² Үүнээс цаашид өгүүлэх “Би” гэдэг энэхүү дипломатчийг хэлж байгаа болно.

“Орших уу, эс орших уу” гэдэг зааг руу эргэлт буцалтгүй шилжиж, үүнийг дагаад социалист хамтын нөхөрлөл хэмээх орнууд маань зөрчилдөж эхэлсэн. Монгол улсад эдийн засгийн хямрал болох нөхцөл бүрдэж буйн шинж ажиглагдаж эхэлж байв. Би гадаад оронд ажиллаж байгаад буцан ирээд байсан үе буюу 1980-аад оны сүүлчээр ЗХУ-ын сүүлчийн удирдагч болсон Михаил Горбачев БНХАУ-тай харилцаагаа сайжруулах үүднээс Монгол улс, Вьетнам, Афганистан дахь цэргээ гаргахаа албан ёсоор мэдэгдсэн юм.¹³ Энэ мэдээ нь манай улсын гадаад бодлогод томоохон өөрчлөлт шинэчлэлт, бас сорилт болоод эрсдэлийг ч авч ирсэн юм.

Өөрөөр хэлбэл Монгол улс аюулгүй байдлаа хамгаалах, гадаад харилцаагаа яаж хөгжүүлэх вэ гэдэг тал дээр ухаалаг хандахаас аргагүй байдалд хүрч, идэвхтэй санаачилгатай, бүтээлч, шинэлэг байдлаар сэтгэх шаардлагатай болж юун түрүүнд ГХЯ-ны хуралдаан дээр бидэнд санал боловсруулахыг даалгав. Тиймээс уг ажлыг хариуцаж авсан салбар зөвлөл буюу багийнхан энэ чиглэлээр шургуу ажиллаж, ажил дээрээ байнгад зөвлөлдөн оройдоо тус тусдаа гэр гэртээ, эсвэл ажил дээрээ сууж уг санал төслөө нухсаар нэлээд хугацааны дараа өөрсдийн саналаа нэгтгэн боловсрууллаа. Энэ үед дэлхий ертөнцийг төмөр хөшгөөр хуваасан

Хүйтэн дайны үзэл суртал, цэрэг эдийн засгийн өрсөлдөөн сөргөлдөөнөөс болж их гүрнүүд хийгээд бага буурай улсуудын аль аль нь ялгаагүй Хүйтэн дайныг дуусгахыг хүсэж байлаа. Мөн 1988 оны БНСУ-ын нийслэлд Сөүлийн олимп нь зохион байгуулагдахад хэдий шүүмжлэл, үгүйсгэл дунд байсан ч Өмнөд Солонгос нь бодит байдал дээр хөгжил өндөр, ард түмэн нь хоол ундтай, баяр хөөртэй, эдийн засаг, бизнес цэцэглэсэн орон болж буй нь бүхний нүдэнд илт харагдаж байлаа.

Бид тухайн үеийн олон улсын болон бүс нутгийн байдал, хүчний шилжилт, ЗХУ-д өрнөж байсан өөрчлөн байгуулалт, ил тод байдал¹⁴ зэргийг бололцоогоороо судалж, харьцуулалт хийсэн юм. Ингээд ГХЯ-ны тайлан товлосон хуралдаан болов. Бидний илтгэлийг ч бүгд сонсож дуусаад, хэлэлцэж эхлэв. Учир нь бидний тайлан илтгэлд “БНМАУ-ын хөгжлийн нэгэн шинэ гарц бол Өмнөд Солонгос буюу БНСУ боллоо. Бид Өмнөд Солонгостой албан ёсны дипломат харилцаа тогтоох нь сонголт бус зайлшгүй шаардлага болж эхэллээ. Юун түрүүнд эдийн засгийн хөгжил нэн хэрэгтэй болоод байгаа бөгөөд ЗХУ задарч, магад мөхөж, оронд нь 15 тусгаар тогтносон улс бий болж, задрах үйл явц дунд Монгол улс эдийн засгийн маш том хямралд нэрвэгдэх нь өнөө маргаашийн

¹³ Тэрбээр Владивосток, Красноярск хотуудад хэлсэн үгэндээ дээрх бодлогуудаа албан ёсоор илэрхийлсэн.

¹⁴ Тухайн үед ЗХУ-ын сүүлчийн удирдагч М. Горбачевийн дэвшүүлсэн “Перестройкай, Гласность” гэдэг нэр томъёог Монгол улсад ингэж орчуулж байв. Ж. Б.

зайд тулгамдсан асуудал болоод байна” гэсэн юм.¹⁵ Энэ талаар ч илтгэл тайландаа дэлгэрэнгүй ярьж, БНСУ-тай дипломат харилцаа тогтоохын зайлшгүй шаардлагыг нэлээн хэдэн үндэслэлтэйгээр хэлсэн юм. Тухайн үед БНМАУ-ын Гадаад Явдлын Яамны сайд байсан Гомбосүрэн гуай ч БНСУ-тай дипломат харилцаа тогтоохын зайлшгүй шаардлагыг нэлээн хэдэн үндэслэлтэйгээр хэлсэн юм. Улмаар бидний саналыг сонсоод, нэлээд сайтар “Би дээш нь уламжилъя” гэлээ.

“Дээш” гэдэг нь Монгол Ардын хувьсгалт намын Төв Хороог хэлж буй нь хэрэг юм. Улмаар биднийг тухайн үеийн Монгол улсын нам, төрийн удирдагч Ж. Батмөнх гуайтай уулз гэв. Бид ч өмнө нь бэлдсэн тайлан сэлтээ эргэн харж “Ямар асуулт асуух бол, ийм асуулт асуувал ингэж хариульа, тийм асуулт асууж магад тэгвэл тэгж хариулна даа” гэх мэтээр бэлдсээр байтал Ж. Батмөнх гуайтай уулзах өдөр, цаг товлогдсон мэдээ ирэв. Удалгүй Гадаад явдлын яамны сайдын нарийн бичиг бидэнд уулзалтын товыг хэлэв.

Долоо хоног өнгөрөөд л товлосон өдөр ч хаяанд ирлээ. Налгар намрын нар ээсэн тэр өдрийг би сайн санадаг. Яагаад гэхээр гэрээсээ гаран ажил дээрээ ирээд багийнхантайгаа хэлэх үг, гаргах гаргалгаа баримтаа харан дахин дахин харав. Бага зэрэг сандарч байсан ч нөгөөтээгүүр дутуу юм үлдээчихгүй юм сан гэж хичээж байгаа минь

энэ байлаа. Гэнэт багаараа явахгүй төлөөлөөд намайг оч гэсэн тул эртлэн гараад 10 гэхэд Засгийн газрын ордонд очин, дотогш орж Ж. Батмөнх гуайн өрөөний гадна очиж нарийн бичигт нь бүртгүүлээд суулаа. Өмнөх хүн гаралгүй лав 30 минут хэртэй хүлээн сууж байтал хаалга гэнэт онгойн Статистикийн газрын дарга гарч, миний ээлж боллоо.

Нарийн бичгийн дарга нь гарч ирэн “Та орно уу” гэж хэллээ. Төрийн тэргүүний өргөөнд сүрдэсхийн яваад оров. Ж. Батмөнх гуай төрөлхийн гэмээр тайван, энгүүн зангаараа “Та ойртоод суугаарай” гэв. “Ажил төрөл ямар байна, та нарыг их ажилтай байгаа гэж сонссон” гэсээр бидний яриа эхлэв.

Юун түрүүнд эхний хэсэгтээ би дэлхийн дахины нөхцөл байдал, ялангуяа Зүүн ази, Солонгосын хойгийн талаар тоймлон яриу. Ингээд Хойд Солонгосын эдийн засаг, аж ахуйн байдал амаргүй байгааг дуулгаад, улмаар ЗХУ хэрвээ задарч коммунист систем нурахдаа хүрвэл байдал нөхцөл байдал улам хүндрэх талаар хэлэхэд Ж. Батмөнх дарга миний үгийн сонсож байгаад “Хойд Солонгос гэлтгүй манай улс ч бас хүндхэн байдалд орж магадгүй байна. Бид ингээд хүлээгээд суугаад байж болохгүй, шат дараатайгаар арга хэмжээ авах хэрэгтэй” гэв. Улмаар би яриагаа үргэлжлүүлэн Солонгосын хойгийн өмнөд хэсэг рүү чиглүүллээ. БНСУ-ын талаар бэлдэж ирсэн эдийн засгийн баримтуудыг

¹⁵ ГХТА. Х-112, хн. 1-13.

дэлгэн “Та мэдэж байгаа, БНСУ-ын эдийн засаг нэн хурдацтай хөгжиж байна, жилийн өсөлтийн хэмжээ нь ийм байна” гэх мэт нэлээн олон тоо баримт, гадаад худалдааны хэмжээ зэргийг танилцуулав. Мөн “Энэ улс эдийн засагтаа хамаарах хоол хүнсний асуудлаа шийдсэн байна, дээрээс нь хөнгөн, хүнд болон химийн аж ахуйн салбарууд зэрэг хөгжиж байна. Тэр бүү хэл авто машин, хөлөг онгоц, цахилгаан бараа бүтээгдэхүүнийг жил ирэх тусам сайжруулж, чанартай үйлдвэрлэн гадаадын улс орнуудад их хэмжээгээр зарж долларын урсгалыг улс руугаа татаж буй талаар өгүүлэн, экспорт руу чиглэсэн эдийн засгийн бүтэцтэй улс болсон байна” гэж яриад экспортын хэмжээг хүснэгтлэн танилцуулсан юм. Ингээд хамгийн гол хэсэгт оров. Энэ хэсэгтээ гадаад харилцааг үзэл суртлаас салгах, шинээр харах хэрэгтэй болсон талаар өгүүлсэн билээ. Дээрх зорилтын хүрээнд хэд хэдэн зорилго, санаачилга дэвшүүлсний дотор БНСУ-тай албан ёсоор дипломат харилцаа тогтоох санал орсон юм. Ж. Батмөнх дарга хэсэг чимээгүй бодон сууснаа “За, эдгээр асуудлыг сайтар судлах хэрэгтэй юм байна. Хэрвээ нааштай үр дүн гарахаар бол даруйхан ажил хэрэг болго” гэж надад хэллээ.

Энэ явдлаас хойш асар удалгүй социализмын задрал эргэлт буцалтгүй үргэлжилж ёстой л хорвоо ертөнц эргэж, хүмүүний амьдрал эрс өөрчлөгдсөн билээ. Тэр жилийн өвөл нөхцөл байдал улам хүндэрч, ЗХУ-ын тусламж

үндсэндээ зогсон, Монгол улсын эдийн засаг зогсолтгүйгээр унаж, ний нуугүй хэлэхэд элгээрээ хэвтсэн гэж хэлж болно.

Хүнсний барааны картын системд улс орноороо шилжиж, айл өрх бүр тодорхой хэмжээний хүнсний хуваарилалтад оров. Дээр нь тог цахилгаан тасрах нь хэвийн үзэгдэл болсон төдийгүй тэр өвөл Улаанбаатар хот хөлдөж магадгүй эрсдэл бодит байдлаар нүүрлэсэн юм. Энэ үеэр Гадаад явдлын яамны зүгээс БНСУ-ын ГХЯ-ны Азийн газрын тэргүүн Кимийг урихаар тогтов. Ийнхүү цаашдаа хоёр орны дээд хэмжээний айлчлал, уулзалтыг зохион байгуулах, эдийн засгийн тусламжийг авах талаар бид хөөцөлдөж эхэлсэн билээ. БНСУ-ын ГХЯ-ны Азийн хэсгийн дарга Кимийг 12 дугаар сард урьж, БНСУ-ын тал ч манай урилгыг найрсгаар хүлээн авч, айлчлалыг дэмжсэн тул манай тал ч шуурхайлан ажилдаа орсон. Бид ч ажил үүргийн нарийвчилсан төлөвлөгөө зохион, тэр дагуу бэлдсээр байтал айлчлалын хугацаа ч болов¹⁶.

¹⁶ 2021 онд ШУА-ийн Олон улс судлалын Хүрээлэнгээс “Монгол улс, БНСУ-ын харилцаа баримт бичгийн эмхэтгэл (1990-2019)” хэмээх бүтээлд БНСУ-ын Азийн газрын дарга Кимийн айлчлалын талаар байхгүй, харин БНСУ-ын ГХЯ-ны Парламентийн асуудал эрхэлсэн орлогч сайд Ли Ки Чу-гийн айлчлалын талаар нэлээд тодорхой баримтууд оржээ. Тэрбээр Монгол улсад 1990 оны 3-р сарын 24-28-ны өдрүүдэд айлчилсан бөгөөд тэр хугацаандаа буюу 3-р сарын 26-нд хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоох баримт бичигт гарын үсгээ зурсан байна. Үүнийг тус эмхэтгэлийн 44-46-р талаас үзэж болно. Тиймээс энэ дурсамжид

Бид ярилцсаар, ерөөсөө зүгээр нэг албан айлчлал гэхээсээ, БНСУ-ын ГХЯ-д Монгол улсын бодит байдлыг харуулъя, эдийн засаг болон санхүүгийн тусламж нэн яаралтай хэрэгтэй байгааг нөгөө талд ойлгуулъя хэмээн тохиров. Өөрөөр хэлбэл, нийгэм-эдийн засгийн байдал нэн хурдацтай унаж доройтож байгаа учраас юун түрүүнд өөрийн улсын ард түмэн хэрхэн хохирол багатай даван туулах талаар ажлаа танилцуулах нь зүй ёсны хэрэг байлаа.

Бодит байдал болоод бэлдсэн материалынхаа суурийг харуулахын тулд Улаанбаатарын хотыг хойноос нь урагш, төвөөс зүүн тийш чиглэж явж, буцах өглөө нь хотын хажуухан малчин айлаар орж Монгол ахуй, аж амьдралтай танилцуулах нь зөв хэмээн бид тогтсон юм. Ингээд тус улстай дипломат харилцаа тогтоох, эдийн засаг, санхүүгийн тусламж авахаар шат дараатайгаар ажиллаж эхлэв.

Мөн их сургуулиар оруулж, дөнгөж нээгдээд байсан Солонгос хэлний дугуйланг танилцуулахаар тогтсон. 12 сарын 8-нд онгоц Буянт-Ухаад газардаж, БНСУ-аас айлчлан ирсэн зочдыг Их Тэнгэрийн аманд байрлах хүндэт зочдын буудалд буулгасан юм. Хэсэг амраагаад ГХЯ-ны байранд эхний уулзалт эхлэв. Их Тэнгэрийн амнаас буюу урдаас хойш чиглэсэн замаар ирэх үед замын хажуугаар гандуухан хувцастай, даарч хөрсөн хүмүүс хааяахан алхаж харагдаж, нэлээд олон

газар гэрэл унтраастай эсвэл бүдэгхэн байгаагаас л эдийн засаг, иргэдийн амьдрал хэцүү байгаа нь сүүмэлзэн харагдах тэр гэрлээс ойлгомжтой харагдах мэт.

Тэр оройн уулзалт хөнгөхөн харилцан танилцах, нүүр хагарах байдлаар явагдсан бол, маргааш нь өдөржин албан ёсны уулзалт өрнөж манай тал БНСУ-тай дипломат харилцаа тогтоох хүсэлтэй буйгаа, хоёр Солонгосын нэгдлийг тууштай дэмжихээ тодорхой илэрхийлэв. Улмаар манай улсын эдийн засгийн нөхцөл байдал хүндэрч буй яриан дундаа дурдсан билээ. БНСУ-ын тал манай саналыг хүлээн авч хоёр улсын хооронд албан ёсоор дипломат харилцаа тогтоох талаар ойрын хугацаанд хариу мэдэгдэхээ амлав.

Уулзалтын дараагийн хэсэг нь оройн хоолыг ГХЯ-ны Азийн газрын даргын гэрт барихаар бэлдсэн маань замд манай хотыг хараад авна, мөн энгийн орчинд найрсаг яриа өрнүүлнэ хэмээн тооцоолсноос үүдэлтэй байсан билээ. Орой 17:30 цагийн алдад бид 1-р хороололд орших орон сууц руу хөдлөв. Тэр үед дээд доод, баян ядуугийн гэх ялгаа байхгүй, амьдралын түвшин нийтээрээ ойролцоо байлаа. 1-р хорооллын байрнууд нэлээн урт, бид хайсаар очих замд тог тасарсан байсан болохоор Улаанбаатар хот ерөнхийдөө харанхуй, түүнийг дагасан юмуу гэмээр тэнгэр ч бүрхэг, хүмүүсийн царай бүдэг бадагт нь уйтгар, түгшүүртэй

гарч буй уулзалт нь үүнээс өмнө буюу 1989 оны 12-р сард болсон гэж таамаглаж байна.

мэдрэгдэж яг л Хойд Солонгост очсон мэт сэтгэгдэл төрнө.

1-р хорооллын гэрэл тэр чигтээ тасарсан болохоор айлуудын цонх нэг бол харанхуй нэг бол лааны гэрэл бүдэгхэн харагдана. Бид явсаар даргын орцны үүдэнд очлоо. Тэр үед гар утас гараагүй байсан болохоор жолооч түрүүлж гаран даргын гэрийн үүдийг олохоор явж, харанхуйд яаж явахаа ойр зуур ярилцаад жолооч маань хайхаар явах гэтэл орцны хаалга нээгдэж дарга амьсгаадсаар гарч ирэв. Яарсан ч нүүрэнд нь инээмсэглэн тодрон бид 8 давхар луу алхлаа. Зочдоо лааны гэрлээр замчлан заах зуурт зочид маань ч гэсэн инээмсэглэсээр шатаар өгслөө.

Даргын доромжлох хэд хэдэн лаа асаан тавьжээ. Зочны өрөөндөө ширээ засан зууш зэргийн дээдийг бэлдэн тавьжээ. Биднийг сууж байх зуур тог ирж бүгд баярлан дуу шуу оров. Гэрэл гэгээ гэгч ийм л ид шидтэй ажээ. Бэлдсэн хоолоо хийн, буузаа ч плиткэн дээр тавив. Хоол унд ч эхнээсээ гарч, архи хундагалан удалгүй тог дахин тасрахад хоол ундаа бэлдэж амжсандаа гэрийн эзэн, эзэгтэй нар их л баяртай харагдана. Тэр оройн зоог ч аятайхан, лааны гэрэлд тод хэр нь энгийн яриа өрнөж, Солонгос хоёр зочин маань ч сэтгэл хангалуун харагдсан. Яриан дундуур өөрсдийн сонирхсон асуултаа ч асууж орой 21 цаг дөхөх үед 3 цаг суусан бид зочдоо үдэн лаагаа асаан урд нь гарч болгоомжлон гарав. Зам саадгүй тул Их Тэнгэрийн ам хүртэл давхисаар очив. Онгоц маргааш өдрийн үдээс хойш байсан

тул өглөө нь МУИС-д шинээр нээгдээд байсан Солонгос хэлний дугуйлантай танилцсан нь Солонгос хүн бүр хангыл гэх өөрсдийн хэл бичгээр бахархан дээдэлдэг тул цагаа олсон явдал боллоо хэмээн бид үзэж байв. Ийн Буянт-ухаа руу явах замд Яармагийн дэнж дээр морь унан явах аав хүү хоёртой тааралдан машинаасаа бууж зураг авхуулав. Хүүд зочид маань гарын бэлэг өгч билээ. Ийнхүү зочид маань нутаг буцан бид үдэж өглөө.

Удалгүй Монголыг дэмжигч, хандивлагч орнуудын зөвлөлдөх уулзалт болж, хүн ам цөөн, ядуу буурай, эдийн засгийн хямралд өртсөн хэдий ч ардчилсан нийгэм, хүний эрхийг дээдлэн тунхагласан Монгол улсыг маань АНУ, Япон, Герман зэрэг орнууд дэмжихээ илэрхийлж, түүний дотор буцалтгүй тусламж үзүүлэхээ мэдэгдэж эхлэв. Гэнэт БНСУ-ын төлөөлөгч гарч ирэн Монгол улсад эдийн засгийн тусламж зээлийг олгохоо мэдэгдэв. Ийнхүү хоёр орны харилцаа амжилттайгаар хөгжиж эхэлсэн юм.

Дүгнэлт

Тус өгүүлэлд өнгөрсөн 20-р зууны Монгол Солонгосын харилцаанд шууд болон шууд бусаар холбогдох магадлал бүхий өвөрмөц үйл явдлууд, хувь хүмүүсийн хувь заяаг аман түүхийн арга зүйд тулгуурлан бичиж тодруулан гаргаж ирэхийг хичээсэн юм. Ингэж бичихдээ Монголын болон Солонгосын түүхийн баримт бичгүүдэд

төдийлөн үлдээгүй, эсвэл маш товч байдлаар үлдсэн, голлон хэрэг явдлын гэрч болсон Монголчуудын дурсамж, дуртгалд тулгуурлан авч үзэв.

Олзлогдсон Япон цэргүүдийн дунд байсан Солонгос нөхрийгөө дагаж цэрэгт явж бас хамт олзлогдон Монголд ирсэн Солонгос эмэгтэй талаар ганц нэг түүхэн хүний дурсамж үлджээ.

Түүнчлэн Монголчуудын уламжлалт хөгжмийн нэг байсан хэдий ч түүхийн явцад зааж сургах багшгүй, сургалтын арга нь мартагдаад байсан ятга хөгжмийг сэргээн заасан Солонгос багшийн намтар ч тун сонирхолтой түүх болно.

Монгол улс БНСУ-тай дипломат харилцаа тогтооход чухал үүрэг гүйцэтгэсэн хоёр орны гадаад албаны ажилтнуудын дурсамж яриа нь орчин үеийн түүхнээ ихээхэн ач холбогдолтой гэж үзэж байна. Тиймээс Монгол Солонгос хоёр орны харилцаатай холбоо бүхий энэ мэт аман түүхийг цаашид улам гүнзгийрүүлэн судлах, шинээр эрдэм шинжилгээний эргэлтэнд оруулах нь өнгөрсөн болоод өнөөгийн харилцааны түүхийг баяжуулах нь лавтай юм.

Эцэст нь тэмдэглэхэд, энэхүү аман түүхэнд тулгуурласан судалгааг цаашид архивын болон бусад эх сурвалжуудаар гүнзгийрүүлэн авч үзэж, түүхэн баримт нотолгоо зэргээр улам баяжуулан дэлгэрүүлэх шаардлагатай байна.

Ном зүй

1. Гадаад харилцааны Төв Архив
2. Баттөр, Ж. (2011). XX зууны Монгол Солонгосын харилцаа, 127-150. (Солонгос хэлээр), Уб., МК Медиа хэвлэлийн газар
3. Лувсан-Очир, Ч. (1998). Дайны дараа Монголд байсан япончуудын хувь заяа, Уб.,
4. Хэрлэн, Л. (2022). Монгол хөгжмийн зэмсгийн өв соёл, Уб.,
5. ШУА-ийн Олон улс судлалын Хүрээлэн. (2021). Монгол улс, БНСУ-ын харилцаа баримт бичгийн эмхэтгэл (1990-2019). Уб.,
6. Санчир, Л. (2021). Ц. Дамдинсүрэнгийн аман өгүүлэг аман түүх болох нь. *Studia Historica, Institute Historiae Ethnologici, Academie Scientiarum Mongoli. Tomus L, Fasciculus 1-19.* Уб.,
7. Цэрэндорж, М. (2007). Алтан гадас одонт С. Гончигсумлаагийн нэрэмжит Хөгжим бүжгийн Коллеж, Уб.,
8. Урангуа, Ж., Эрдэнэбилэг, Б. (2018) Дайны золиос болсон хүмүүс, Монгол улсын их сургууль, Тагнуулын Ерөнхий газар, Шова Эмэгтэйчүүдийн их сургуулиас хамтран эрхлэн хэвлүүлсэн. Уб.,

БНСУ-ЫН ДИЖИТАЛ ХӨГЖЛИЙН ШИНЭ ЧИГ ХАНДЛАГА БА МОНГОЛЫН БОЛОМЖ

Д.Уламбаяр¹

ulambayar@humanities.mn

Abstract

At the end of the 20th century and the beginning of the 21st century, there was a lot of talk and writing about the irreversible globalization based on interdependence, but now I am writing about the irreversible digitization in all fields of the world and its impact on humanity. Digitalization has brought enormous savings to the economy and turned our stereotypes of space-time upside down.

In The Republic of Korea, the digital process has become an irreversible process, covering all socio-economic sectors. Today's South Korea is a country with great material and spiritual potential to make unprecedented progress in science and technology in the New Millennium. It is emphasized again that South Korea ranks highest in the world in terms of digital & ICT, high-tech infrastructure, high-speed internet per capita, and integration and innovation between key economic structures.

One of the important directions of cooperation in the field of strategic partnership between Mongolia and the Republic of Korea is the digital sector, and cooperation in this direction will be deepened.

Keywords: digitization, cyber space, internet, digital revolution, e-society, online trade, soft infrastructure, etc.,

I. Дижитал хувьсгал

XX зууны сүүлчийн улиралд хүн төрөлхтний хамгийн том нээлт нь өөрсдийн амьдрах орон зай, цаг хугацаагаа цоо шинээр, гэхдээ хязгааргүй “тэлсэн” явдал юм. *Cyber space* хэмээх хүний оюуны бүтээл болсон тулааны энэ шинэ орон зай хүн төрөлхтний амьдралд язгуур өөрчлөлт

гаргаж, цаашид ч олон суурь өөрчлөлт, шинэ зүйлсийг буй болгох нь тодорхой болов. XX зууны сүүлч, XXI зууны эхнээс харилцан хамааралд суурилсан *globalization* эргэлт буцалтгүй болж байгаа тухай ихээхэн ярьж бичиж байсан, харин эдүгээ дэлхий нийтийн хэмжээнд бүх салбарт *digitization* эргэлт буцалтгүй болж буй тухай, түүний хүн төрөлхтөнд үзүүлж буй нөлөөллийн тухай ярьж бичиж байна. Дижитал үйл явц эдийн засагт асар

¹ ХИС-ийн Олон улсын харилцаа, нийгэм судлалын сургуулийн захирал, ШУ-ы др, проф. Хүндэт дипломат

их хэмнэлт буй болгож, орон зай, цаг хугацаа, уламжлалт эдийн засгийн тухай бидний *stereotype*-ийг орвонгоор нь өөрчилж эхлэв. Нөгөө талд дижитал технологийн хурдацтай хөгжлийн үр дагавраар дэлхий нийтийн аюулгүй байдал улам эмзэг болж, кибер орон зай дахь сөрөг үйлдлээс санамсаргүй байдлаар өчүүхэн зүйлээс ч их хор хохирол учирч болзошгүй байдал ч үүсээд буйг тэмдэглэх ёстой. Кибер аюулгүй байдлыг хангах нь мэдээллийн аюулгүй байдлаас огт өөр, шинэ ойлголт болно.

Генетикийн түвшинд дижитал оюун ухаан бүтээхээс эхлээд асар том дижитал хувьсгал өрнөж байна. Дубайн World Government Summit дээр хүний тархи болон түүний дижитал хувилбар хоёрын хооронд мэдээлэл солилцох хурдны тухай, тэдгээрийн нэгдлийн тухай, хүний оюун ухааныг нүүлгэн шилжүүлэх өргөн хүрээтэй хэлэлцүүлэг өрнөх болов. *Хүн ертөнцийн мөнх бусыг үзүүлсэн ч түүний бүх мэдээлэл, дижитал хуулбар амьдралаа цааш нь үргэлжлүүлэх боломжийг олгох гэнэ.*

Дижитал оюун ухааны хөгжилд cognitive neuroscience нэн чухал үүрэг гүйцэтгэж байгаа боловч квант компьютерын хөгжил түүнийг орвонгоор нь өөрчлөхөөр байна.

Blockchain технологи хөгжлийн шинэ боломжийг нээсэн хэдий ч квант компьютерын хөгжил түүний схемийг бусниулж, итгэхэд нэн бэрх квант орны цоо шинэ нөхцөл байдлыг буй болгохоор

байна. *Blockchain* сайтын мэдээлснээр биткойны 90 хувийг нэгэнт олборлож, нээлттэй зах зээлд арилжаалагдаж байгаа бөгөөд урьдчилсан тооцооллоор үлдсэн сүүлчийн 10 хувийг өндөр хүчин чадалтай супер компьютер ашигласан ч 2140 оны хоёрдугаар сар хүртэл олборлож, зах зээлд нийлүүлэхээр байгаа ажээ. Өөрөөр хэлбэл 100 илүү жил шаардагдаж байна. Тэгвэл квант компьютер энэ асуудлыг хоромхон зуур шийдвэрлэж чадах ажээ. *Квант компьютерын үйлдэл нь бурханд хамгийн ойрхон дөхөж очих шийдэл болно гэж мэргэжилтнүүд нь тэмдэглэх болжээ.*

Ухаалаг төхөөрөмжүүд (smart objects) өндөр хурдны интернет сүлжээний суурь бүтэц (infrastructure), ложистикоор интеграццилагдаж, объектуудыг алсаас мэдрэх, удирдах, хянах боломжтой (Internet of Things-IoT) болж, 6G хэрэглээнд нэвтэрч эхлэв.

Metaverse бидний параллель ертөнц буюу хоёр дахь амьдрал болохоор байна. Амьдралын нэн чухал зүйлс бүгд дижитал хэлбэр лүү шилжиж, тийнхүү дижитал амьдрал бидний бодит амьдралаас илүү үнэ цэнэтэй орчин болох ажгуу.

OpenAI-ийн эхлүүлсэн ChatGPT нь дижитал оюун ухааны салбарт хурдацтай, урьд өмнө байгаагүй их хэмжээний хөрөнгө оруулалтыг хийж эхэлсэн нь цоо шинэ нөхцөл байдлыг буй болгож байна.

Дижитал технологи урьдаас төсөөлж байгаагүй зүйлсийг бие даан хийж эхлэх л юм бол бид амьдралын цоо шинэ хэлбэртэй нүүр тулсан гэж ойлгох хэрэгтэй болж байна.

Эдүгээ үндэсний эдийн засаг дэлхийн зах зээлийн хуулиар зохицуулагдаж, үндэсний баялаг, түүхий эдийн нөөцөө захиран зарцуулах нь нэг улсын эрх мэдэл, хил хязгаараас шалтгаалахгүй болж, гадаад, дотоод бодлогын зааг ялгаа багасаж байна. Цахим ертөнц ганцхан мэдээлэл солилцох хэрэгсэл байхаа хэдийнээ больж, хил хязгааргүй эдийн засгийн нэгдсэн нэг орон зай болон хувирав.

Гадаад, дотоод бодлогын зааг ялгаа багасаж, даяаршил, дижитал үйл явц үндэсний аюулгүй байдлын шийдвэрлэхүйц хүчин зүйл болов. Их гүрнүүд гадаад бодлогоо тодорхойлохдоо: *economics of power* буюу хүчний эдийн засаг, *power of economics* буюу эдийн засгийн хүч гэсэн 2 зарчмыг баримталж байгаа нь бүхэлдээ дижитал технологид суурилж байна.

Бүр 1989 онд Солонгос гаралтай Японы судлаач Т.В.Канын бичсэн «Солонгос дараагийн Япон мөн үү?: Америкийн дараагийн өрсөлдөгчийн бүтэц, стратеги, тактикийг ойлгох нь» (T.W.Kang)² нэртэй бүтээл Нью-

Йорк хотноо хэвлэгдэн гарсан нь нэлээд дуулиан тарьсан билээ.

Азийн «шинээр аж үйлдвэржсэн» БНСУ нийтлэг шинж бүхий хөгжлийн тодорхой үе шатуудыг дамжиж иржээ. Энэ нь нэгд: 1960-аад онд импортыг орлох үйлдвэрлэлийг бүх талаар хөхүүлэн дэмжих, хоёрт, 1970-аад онд үйлдвэрлэлийн бүтцийг өөрчлөн хүнд үйлдвэр, экспортын чиг баримталсан үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлэх, гуравт, 1980-90-аад оноос оюуны багтаамжтай өндөр технологи, цахим бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэхэд чиглэгдэж иржээ. Дөрөвт, XXI зууны хоёр дахь арван жилээс дижитал технологийн салбарт дэлхийд тэргүүлэх байр суурь эзлэх бодлого явуулж байна гэж үзэж болохоор байна

II. БНСУ-ын дижитал хөгжлийн үйл явц

Өнөөгийн БНСУ нь шинжлэх ухаан-технологийн урьд үзэгдээгүй ахиц, дэвшлийг Шинэ мянганд гаргах материаллаг болон оюун санааны үлэмж чадавхтай орон юм. БНСУ нь мэдээлэл, харилцаа холбооны технологи, өндөр технологийн суурь буюу дээд бүтэц (infrastructure), нэг хүнд оногдох нийтийг хамарсан өндөр хурдны интернетийн сүлжээ, гол эдийн засгийн бүтцүүдийн хоорондох интеграцчилал, инновацчилалаар дэлхийд хамгийн өндөрт орж байна.

² T.W.Kang. Is Korea the next Japan?: Understanding the Structure, Strategy, and Tactics of America's Next Competitor. Free Press. The University of California. N.Y.: 1989

2024 оны гуравдугаар сарын “Forbes” сэтгүүлийн судалгаагаар дэлхийд өндөр хурдны интернет хэрэглэгчид 5.3 тэрбум, е-бизнесийн нийт үнийн дүн 5.8 их наяд ам. доллараар хэмжигдэж, 2.5 тэрбум хүн ажил, амьдралаа явуулж буй ажээ.³ (E-Commerce Statistics of 2024. March 28, 2024 <https://www.forbes.com/advisor/business/ecommerce-statistics/>)

2021 оны долоодугаар сард Женев дэх НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал (UNCTAD) байгууллагын 68 дахь чуулган зохион байгуулагдаж, БНСУ-ыг хөгжингүй орон болсныг зарлаж, статусыг нь шинэчилж санал нэгтгэйгээр тус улсыг хөгжингүй орны гишүүнчлэлд оруулсан.⁴ (UN agency upgrades Korea’s status to developed economy) БНСУ нь олон жилийн турш НҮБ-ын донор гол орнуудын нэгээр явж иржээ. Тус агентлаг 1964 онд үүсгэн байгуулагдсанаасаа хойш анх удаа хөгжиж буй орны бүлгээс аль нэг улсын статусыг хөгжингүй болгон өөрчилсөн нь энэ удаагийн чуулган байв.

2017 онд БНСУ-ын ерөнхийлөгчийн дэргэд байгуулагдсан Аж үйлдвэрийн IV хувьсгалын хороо 2017 оны арван нэгдүгээр сард БНСУ-ын Ерөнхийлөгчийн ивээл дор

«e-Korea: Towards Digitization» сэдэвт олон улсын томоохон арга хэмжээ зохион байгуулагдав. Энэ үеэр шинээр эмхлэн байгуулагдсан Шинжлэх ухаан, мэдээлэл, харилцаа-холбооны технологи, ирээдүй төлөвлөлтийн сайд Юү овогтын (Yu Yeong-min) тэмдэглэснээр: “Дэлхий ертөнц дижитал хувьсгалын үр дүнд үйлдвэрлэлийн хөдөлгөгч хүч, хуваарилалт болон кибер ертөнцийн үйл явцыг хувирган өөрчлөөд зогсохгүй хүмүүсийн өдөр тутмын амьдралын чанар, хэв маягийг ч үндсээр нь өөрчилж байна” гэжээ. Гадаад худалдаа, үйлдвэр, эрчим хүчний сайд Пэйк овогт (Paik Ungyu) хэлэхдээ: “Солонгосын эдийн засаг, үйлдвэрлэлийг үндсээр нь өөрчилж буй гол хүчин зүйл, динамик нь **e-revolution** болж байна” гэжээ. Тэрбээр цааш нь хэлэхдээ: “Бидний ирээдүйг чиглэсэн шинэ үйлдвэрлэл бол IT (information technology), NT (nano-technology), BT (bio-technology), NPM (new and precision materials буюу металл, шингэн, хий, хатуу нягт бодисыг шинэ технологийн инновацчлалын тусалцаатайгаар хослуулж цоо шинэ үеийн материал гаргаж авах), ET (environment and new energy technology), Optical sectors (гэрлийн энерги, долгионы хурд, уртын онцлогийг ашигласан технологийг машин, механизм, үйлдвэрийн эд ангиуд, системийн үйлдвэрлэл, лазерийн үйлдвэрлэл, роботчлол, хараазүйн судлал), Aerospace technology юм. Тиймээс ирэх жилүүдэд R&D

³ E-Commerce Statistics of 2024. March 28, 2024 <https://www.forbes.com/advisor/business/ecommerce-statistics/>

⁴ UN agency upgrades Korea’s status to developed economy July 5, 2021 <https://www.korea.net/NewsFocus/policies/view?articleId=200509>

(Research and Development) чиглэлд үлэмж хөрөнгө оруулалт хийнэ” гэсэн байна. Rockwell International группийн тэргүүн бөгөөд CEO солонгос гаралтай америк Davis Dong тэмдэглэн хэлэхдээ: “*e-manufacturing* гэдэг нь мэдээллийн технологид суурилсан е-бизнесийн моделиар жолоодон тухайлбал, үлэмж том цахилгаан станцын үйлдвэрлэлийг ч энэхүү хувьсгалын үр дүнд кибер орчинд буй болгосон цагт, үлэмж том үйлдвэрлэлийн бодит бүтээмжийг дараагийн түвшинд буй болгох болно”⁵ (e-World: Towards Digitization. Ang Byong-yub speech. “The Korea Times” Nov. 9, 2017) гэсэн байна. Энэ бол *internet economics* буюу *digital economy* ажээ.

“Korea Telecom”-ын 2021 оны тавдугаар сард мэдээлснээр өндөр хурдны сүлжээний үйлчилгээнд тулгуурласан мэдээллийн суурь бүтэц (infrastructure) цогц бүрдсэн нь Солонгосчуудын амьдралын чанарыг үндсээр нь өөрчилж байгаа ажээ. Өндөр хурдны сүлжээний үйлчилгээнд интеграцчилагдсан 290 гаруй төрийн институци⁶ (Нийт төрийн 288 байгууллагын 9.7 хувийг төрийн өмчит 28 компани, төрийн өмчит 83 байгууллага 28.8 хувийг тус тус эзэлж

байна. Ангилалгүй байгууллагын тоо 177 (61. хувь) байгаа ажээ. [e-commerce-т суурилсан *B-to-B*-гийн \(*Business-2-Business*\) гарцтай болсон байна. Мэдээллийн технологид үндэслэсэн бизнесийн хувьсгал ажлын байрны зах зээлийг эрс өргөжүүлж, нэмэгдсэн өртөг илүү өндөр шингээсэн бизнесийг буй болгов. Өндөр хурдны сүлжээнд суурилсан *on-line* эмнэлгийн үйлчилгээ амьдралын чанарыг эрхгүй өөрчилж буй ажээ. Энэ бүгдийн үр дүнд Шинэ](http://nationalatlas.ngii.go.kr/pages/page_579.php#:~:text=) e-government-ийг нэгэнт буй болгож, энэ нь солонгосчуудад хамгийн хурдан шуурхай засаглалын үйлчилгээг санал болгож байна. Өндөр хурдны сүлжээний үйлчилгээнд холбогдсон 200 гаруй их, дээд сургууль⁷ (Number of higher education institutions South Korea 1980–2023, Feb 27, 2024) өндөр зэрэглэлийн чанартай <i>e-education</i> тогтолцоог буй болгожээ. 7.7 сая жижиг, дунд үйлдвэрлэгчид⁸ (Number of SMEs South Korea 2017–2021. March 12, 2024 <a href=)

⁵ e-World: Towards Digitization. Ang Byong-yub speech. “The Korea Times” Nov. 9, 2017

⁶ Нийт төрийн 288 байгууллагын 9.7 хувийг төрийн өмчит 28 компани, төрийн өмчит 83 байгууллага 28.8 хувийг тус тус эзэлж байна. Ангилалгүй байгууллагын тоо 177 (61. хувь) байгаа ажээ http://nationalatlas.ngii.go.kr/pages/page_579.php#:~:text


⁷ Number of higher education institutions South Korea 1980–2023, Feb 27, 2024 <https://www.statista.com/statistics/648374/south-korea-higher-educational-institutions-number/>

⁸ Number of SMEs South Korea 2017–2021. March 12, 2024 <https://www.statista.com/statistics/1223066/south-korea-small-and-medium-enterprises-number/#:~:tex>

мянганы эрин үеийн эхнээс Солонгос нь *e-Society*-г байгуулж байгаа ажээ.⁹ (“Korea Communication Market Data”. Netmanias. 30 May 2021. Archived from the original on 15 August 2022. R)

Өнөөдөр дэлхийн улс орнууд дижитал оюун ухааны асар том өөрчлөлттэй тулгарч байна. БНСУ-ын Засгийн газар 2019 оны арван хоёрдугаар сарын 17-нд хиймэл оюун ухааны үндэсний стратегийг баталсан.¹⁰ (National Strategy for Artificial Intelligence <https://www.msit.go.kr/bbs/view.do?sCode=eng&nttSeqNo=9&bbsSeqNo=46&mId=10&mPid=9>) БНСУ “Мэдээллийн технологиос цааш хиймэл оюун ухаантай дэлхийн удирдагчийн зүгт” (Toward AI World Leader beyond IT) гэсэн алсын хараагаар дижитал технологийг эрс

Бүдүүвч 1. БНСУ-ын цахим засаглалын үе шат, чиглэл



эрчимжүүлэхийг зорьж байна. 2030 он гэхэд өрсөлдөх чадвар, хиймэл оюун ухааны эдийн засгийн асар их үр нөлөөг бий болгож, хүмүүсийн амьдралын чанарыг сайжруулна гэж үзэж байгаа ажээ. Хиймэл оюун ухааны гурван чиглэлээр 9 стратегийн хүрээнд Засгийн газрын хэмжээнд хэрэгжүүлэх 100 үйл ажиллагааны зорилт түүний дотор экосистем, хиймэл оюун ухааны хэрэглээ, хүн төвтэй хиймэл оюун ухаанаас бүрдэж байна.¹¹ (Ibid.)

АНУ, ЕХ, БНСУ, Хятадын тэргүүлэх их сургуулиуд “Хиймэл оюун ухааны бакалавр, магистрын түвшний боловсролын мэргэжлийн хөтөлбөрийг нэгэнт хэрэгжүүлж эхлээд байна.

Дижитал технологийн салбарт зах зээлийн судалгаа хийж, дүн шинжилгээ гаргах, мэргэжлийн өндөр зэрэглэлийн зөвлөгөө үзүүлдэг *Global Brands magazine*

⁹ “Korea Communication Market Data”. Netmanias. 30 May 2021. Archived from the original on 15 August 2022. R

¹⁰ National Strategy for Artificial Intelligence <https://www.msit.go.kr/bbs/view.do?sCode=eng&nttSeqNo=9&bbsSeqNo=46&mId=10&mPid=9>

¹¹ Ibid,

зэрэг олон улсын нэр хүндтэй сэтгүүлийн 2023 оны чансааны үнэлгээгээр дэлхийн хөдөлгөөнт холбооны топ 10 компанийн *тэргүүнд* Samsung Electronics, *хоёрт*, Apple Inc, *гуравт*, Хятадын Xiaomi, *дөрөвт*, Хятадын Oppo, *тавд*, Хятадын Vivo Communication Technology, *зургаад*, Хятадын Huawei, *долоод*, Хятадын Realme, *наймд*, АНУ-ын Google, *есөд*, АНУ-ын Motorola Mobile, *аравт*, Хятадын OnePlus Technology компаниуд орж байна.¹² (Top 10 Mobile Brands in the World 2023. <https://www.globalbrandsmagazine.com/top-10-mobile-brands-in-the-world-2023/>) Өмнөд Солонгосын LG зэрэг бусад үндэстэн дамнасан корпорацууд мөн дээгүүрт ордог.

Дэлхийн хөдөлгөөнт холбооны зах зээл дээр Samsung Electronics-ийу андройд үйлдлийн системтэй Galaxy S загварын гар утас баттай байр сууриа нэгэнт эзлэв. Samsung групп «хатуу диск уншигч» (DHN) үйлдвэрлэгч АНУ-ын Seagate technology хэмээх дэлхийн хамгийн том компанийн өндөр технологийн үйлдвэрлэл, Rolls-Royce Airbus A380 онгоцны Trent 900 загварын хөдөлгүүр, Boeing 787 Dreamliner-ийн төсөлд гол үүрэг гүйцэтгэж байгаа ажээ. Өмнөд Солонгосын *biopharmaceuticals*-ын салбарын хөгжил дэлхийд тэргүүлэх байранд нэгэнт гарч иржээ.

¹² Top 10 Mobile Brands in the World 2023. <https://www.globalbrandsmagazine.com/top-10-mobile-brands-in-the-world-2023/>

2024 оны нэгдүгээр сард Samsung Electronics хамгийн сүүлийн үеийн шинэ бренд “Galaxy S24 Ultra”, “S24 Plus” ухаалаг гар утсаа танилцуулав. Samsung Electronics нь Galaxy хамгийн сүүлийн үеийн загваруудад хиймэл оюун ухааны системийг суулгажээ. Тухайлбал, утсаар ярих үед шууд орчуулах функцтэйгээс гадна камерын үзүүлэлтүүдийг үлэмж сайжруулсан байна.¹³ (Samsung PH sees record pre-orders with Galaxy S24 Series. 1/01/2024 <https://news.samsung.com/ph/samsung-ph-sees-record-pre-orders-with-galaxy-s24-series>)

Мэдээж гол асуудал нь *cyber* ертөнцөд дижитал технологийн аюулгүй байдлыг найдвартай хангах тухай юм. Тиймээс 2002 онд «Кибер орон зайг террорист халдлагаас хамгаалах тухай хууль»-ийг БНСУ-ын хууль тогтоох дээд байгууллага Үндэсний Ассамблейгаас батлан гаргасан байна.

Мэдээлэл, харилцаа холбооны технологийн үсрэнгүй хөгжил уламжлалт эдийн засгийн бүтцийг өөрчилж дижитал эдийн засгийг шинээр буй болгож байна. Тиймээс хүн төрөлхтөн дэлхийн дулаарал, цаг уурын өөрчлөлтөд дасан зохицохоос гадна дижитал ертөнцөд дасан зохицох шаардлагатай болов.

ДНБ-тэй холбоотой шинэ

¹³ Samsung PH sees record pre-orders with Galaxy S24 Series. 1/01/2024 <https://news.samsung.com/ph/samsung-ph-sees-record-pre-orders-with-galaxy-s24-series>

судалгаанд оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээгээр БНСУ тэргүүлж байгаа юм. R&D-д хэн хөрөнгө оруулалт хийж байна, тэнд **digital revolution** явагдаж байна. 2022 онд БНСУ-ын хувийн хэвшил болон Засгийн газрын судалгаа, хөгжилд (R&D) оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ ₮112.64 их наяд (85.46 тэрбум ам.доллар) болсон нь өмнөх оныхоос ₮10.51 их наяд буюу 10.3 хувиар өссөн үзүүлэлт болсон байна.¹⁴ (“Private sector accounts for 80% of Korean R&D investment in 2022” 2023.12.11)

Монгол Улс шинжлэх ухаан, технологийн хөгжилд ДНБ-ий 0.12 хувийг зарцуулж байгаа нь гайхмаар доогуур үзүүлэлт болно.¹⁵ (ДНБ-ий 1 хувийг эрдэм судлалын ажилд зарцуулах хэрэгтэй. 2019.09.27 <https://president.mn/11094/>) Монгол Улс 2019 оны Дижитал өрсөлдөгч чадавхын үнэлгээгээр 63 орноос 62-т,¹⁶ (The Global Competitiveness Report 2019. Klaus Schwab. World Economic Forum http://www3.weforum.org/docs/WEF_TheGlobalCompetitivenessReport2019.pdf) 2019 оны Мэдээлэл харилцаа, холбооны технологийн хөгжлийн

индексээр 176 орноос 91-д,¹⁷ (WEF. The Global Information Technology Report-The NRI 2019 Counrirs. <https://networkreadinessindex.org/2019/nri-2019-countries/>) Монгол Улсын ДНБ-д Мэдээллийн технологийн жин 2,1 хувийг эзэлж байна.¹⁸ (Ibid,)

2022 оны дөрөвдүгээр сард ДНБ-тэй холбоотой шинэ судалгаа, төслүүдэд оруулсан хөрөнгө оруулалтын хувь хэмжээгээр БНСУ дэлхийд тэргүүлжээ. Энэ тухай тус улсын Шинжлэх ухаан, мэдээлэл, харилцаа-холбооны технологи, ирээдүй төлөвлөлтийн яам 2021 оны мэдээлэлд хийсэн дүн шинжилгээнд үндэслэн мэдээлсэн байна. Тус яамны мэдээллээр, ДНБ-тэй холбоотой шинжлэх ухаан-судалгааны болон туршилт-загвар бүтээх ажлын эрчимтэй байдлын үзүүлэлт БНСУ-д 4.55 хувьтай гарчээ. Тус улсын дараагаар Израиль 4.54 хувьтайгаар орсон байна. 2000 онд Өмнөд Солонгосын энэ үзүүлэлт 2.18 хувьтай, харин Израиль улсынх 3.94 хувьтай байжээ. OECD-ын талаарх дундаж үзүүлэлт 2.37 хувьтай байсан нь 2016 оныхоос бага зэрэг өссөн үзүүлэлт байжээ. Энэ нь БНСУ, АНУ, Японтой холбоотой хөрөнгө оруулалт нэмэгдсэнтэй холбоотой байна. Жагсаалтын гуравдугаарт, Швейцарь улс орж, тус улсын дараагаар Швед, Япон, Австри, Дани, Герман,

¹⁴ “Private sector accounts for 80% of Korean R&D investment in 2022” 2023.12.11 https://www.investkorea.org/ik-en/bbs/i-465/detail.do?ntt_sn=492385#:~:text=

¹⁵ ДНБ-ий 1 хувийг эрдэм судлалын ажилд зарцуулах хэрэгтэй. 2019.09.27 <https://president.mn/11094/>


¹⁶ The Global Competitiveness Report 2019. Klaus Schwab. World Economic Forum http://www3.weforum.org/docs/WEF_TheGlobalCompetitivenessReport2019.pdf

¹⁷ WEF. The Global Information Technology Report-The NRI 2019 Counrirs. <https://networkreadinessindex.org/2019/nri-2019-countries/>

¹⁸ Ibid,

АНУ болон Франц улс бичигдэж байв.¹⁹ (Ranking of the companies with the highest spending on research and development worldwide in 2022 (in billion U.S. dollars) <https://www.statista.com/statistics/265645/ranking-of-the-20-companies-with-the-highest-spending-on-research-and-development/>)

График 1. 2022 онд дэлхий даяар судалгаа, хөгжилд хамгийн их мөнгө зарцуулсан компаниудын зэрэглэл (тэрбум ам. доллар)



2019 оны зургаадугаар сард Харилцаа холбооны зургаадугаар үеийн 6G сүлжээний үндсэн технологийг хөгжүүлэх судалгааны төвийг нээсэн тухайгаа “Samsung” компани мэдэгдэв.²⁰ (Samsung opens research center to begin initial work on 6G. May 4, 2019 <https://www.techspot.com/news/80382-samsung-opens-research-center-begin-initial-work-6g.html>) “Samsung Research” судалгаа, боловсруулалтын байгууллага нь гар утасны сүүлийн үеийн технологи, харилцаа холбооны дараагийн үеийн сүлжээг хөгжүүлэх чиглэлд үйл ажиллагаа явуулах юм. “5G” сүлжээ эхний зах зээлүүддээ нэвтэрч, дэлхийн олон орны гар утасны сүлжээнд “4G LTE” сүлжээг ашиглаж буй энэ үед “6G” сүлжээг хөгжүүлэх нь “Samsung” компанийн урт хугацааны бизнес төлөвлөгөөний нэгээхэн хэсэг ажээ. “Samsung” компани өнгөрсөн дөрөвдүгээр сарын эхээр дэлхийн анхны “5G”

¹⁹ Ranking of the companies with the highest spending on research and development worldwide in 2022 (in billion U.S. dollars) <https://www.statista.com/statistics/265645/ranking-of-the-20-companies-with-the-highest-spending-on-research-and-development/>

²⁰ Samsung opens research center to begin initial work on 6G. May 4, 2019 <https://www.techspot.com/news/80382-samsung-opens-research-center-begin-initial-work-6g.html>

сүлжээг дэмждэг “Galaxy S10 5G” ухаалаг гар утсыг худалдаанд гаргасан юм. Дашрамд дурдахад, БНСУ-ын цахилгаан хэрэгсэл үйлдвэрлэгч “LG” компани Солонгосын Шинжлэх ухаан, технологийн хүрээлэнтэй хамтран “6G” технологийг хөгжүүлэх лабораторийг Тэжон хотод 2019 нэгдүгээр сард нээсэн билээ.

2024 оны хоёрдугаар сард 10 гүрэн 6G сүлжээг хөгжүүлэх үндсэн зарчмуудын талаар тохиролцож, тусгай тунхаглал баталсныг Испанийн Барселон хотноо зохиогдсон “Mobile World Congress” үзэсгэлэн нээгдсэнтэй холбогдуулан зарлажээ. Тусгай Тунхаглалд Австрали, Их Британи, Япон, Канад, БНСУ, Франц, Швед, Чех болон АНУ нэгдсэн байна.²¹ (Korea joins 10-nation statement on endorsing 6G principles. 2024-02-27)

Хагас дамжуулагч буюу чипний үйлдвэрлэл бол БНСУ-ын дижитал технологийн дэлхийд тэргүүлэх салбар билээ. БНСУ-ын хагас дамжуулагчийн үйлдвэрлэлийн түүх 1965 оноос эхэлжээ.²² (“The rise of Korea's semiconductor industry”. KBS WORLD. July 10, 2017.) 1983 онд БНСУ нь АНУ, Японы дараа 64K DRAM хөгжүүлсэн дэлхийн гурав дахь орон болсон бол 1992 онд БНСУ DRAM зах зээлд тэргүүлжээ. Харин 2013 онд дэлхийн

анхны 3D V-NAND флаш санах ойг худалдаанд гаргажээ. Тийнхүү БНСУ-д 1980-аад оноос хойш хагас дамжуулагчийг компьютер болон бусад төхөөрөмжид их хэмжээгээр ашигласнаар хагас дамжуулагчийн үйлдвэрлэл эдүгээ эрчимтэй үргэлжлэн хөгжиж байна. Өмнөд Солонгос 2022 онд дэлхийн хагас дамжуулагчийн зах зээлийн 17.7 хувийг эзэмшиж, 2013 оноос хойш 10 дахь жилдээ дараалан дэлхийд хоёрт бичигдсэн хэвээр байна.²³ (“South Korea invests big in becoming a global chip leader”. DW News. January 24, 2024.)

Тус улс дэлхийн санах ойн хагас дамжуулагчийн зах зээлийн 60.5 хувийг эзэлж, DRAM-ын (Dynamic Random Access Memory) зах зээлийн 70.5 хувийг, NAND-ын (not and) зах зээлийн 52.6 хувийг эзэлж байна. БНСУ өрсөлдөх чадвараа хадгалахын тулд судалгаа, боловсруулалт, хөрөнгө оруулалтад тасралтгүй анхаарч байгаа юм. Өөр нэг дурдахад, Өмнөд Солонгос нь хэт нарийн боловсруулалтын (ultra-fine processing) технологид суурилсан цутгамал үйлдвэрийн зах зээлд (foundry market) эзлэх хувийг өргөжүүлэхээр ажиллаж байна. Тус улс дэлхийн цутгамал үйлдвэрийн зах зээлийн 17.3 хувийг эзэлдэг.²⁴ (“South Korea's Semiconductor Output Rises by Most in 14 Years”. Bloomberg. March 29, 2024.)

²¹ Korea joins 10-nation statement on endorsing 6G principles. 2024-02-27 https://www.koreatimes.co.kr/www/tech/2024/04/129_369590.html

²² “The rise of Korea's semiconductor industry”. KBS WORLD. July 10, 2017.

²³ “South Korea invests big in becoming a global chip leader”. DW News. January 24, 2024.

²⁴ “South Korea's Semiconductor Output Rises by Most in 14 Years”. Bloomberg. March 29, 2024.

Бүдүүвч 2. БНСУ-ын чипний үйлдвэрлэл 2022




График 2. Гол хагас дамжуулагч үйлдвэрлэгчдийн зах зээлд эзлэх хувь хэмжээ (2001-2022)






График 3. Амьдралын өндөр дижитал чанар, өрсөлдөх чадварын эрэмбэ-2021



Бүдүүвч 4. Дэлхийн дижитал өрсөлдөх чадвар, Глобал инновацийн индексийн эрэмбэ



Ranked: The Most Innovative Countries in 2023

https://www.visualcapitalist.com/most-innovative-countries-in-023/#google_vignette

November 14, 2023

Дижитал үйл явц эдийн засагт асар их хэмнэлт буй болгож, орон зай-цаг хугацааны тухай бидний *stereotype*-ийг үндсээр нь өөрчилж байгаа тухай дээр тэмдэглэсэн. *Дижитал эдийн засгийн хамгийн эхний үе шат нь халбага үйлдвэрлэж байгаад сэрээ, эсвэл савх үйлдвэрлэхээр бол зүгээр л программыг нь өөрчлөөд “enter” товчлуурыг дарахад л хангалттай. Энэ бол программчлалын хүч юм.*

Дижитал эдийн засгийн хөгжлийн дараагийн үе шатанд интернетэд холбогдсон кибер орон зайд *big data*, ухаалаг төхөөрөмжүүдийн холболтоор үнэ цэнтэй цоо шинэ өртөг буй болгох үйл явц юм. Энэ бол бизнесийн цоо шинэ моделийг угсарч буй хэрэг даруй мөн. Тиймээс энэ бол цахим эдийн засаг биш, мөн тоон технологи ч биш юм. Дижитал эдийн засаг гэдэг нь нэгд, интернет сүлжээн дээр суурилна, *хоёрт*, программ хангамж дээр суурилсан эдийн засаг юм, *гуравт*, application, platform дээр суурилж байна. *Дөрөвт*, кибер хязгааргүй орон зайд ажиллах эдгээр болно.

Тиймээс дижитал эдийн засгийг хөгжүүлэхийн тулд технологийн суурь байгууламж буюу soft & hard дээд бүтэц, ложистик, инновацыг дэмжсэн бодлого, мэдлэг болон мэдээлэлжсэн нийгмийн нөхцөл бүрдсэн байх явдал болно.

Дижитал эдийн засаг нь төр засгийн дэмжих бодлого, нийгэм, мэдлэгийн хүлээж авах бэлэн байдал,

зөөлөн болон хатуу суурь бүтэц (soft & hard infrastructure), үйлчилгээний дээд бүтцээс бүрддэг.

Уур амьсгалын өөрчлөлтөд “тэсвэртэй эдийн засаг”-ийг (climate-resilient economy) цогцлоох тухай өргөн хүрээнд хэлэлцэгдэж байна. Түүнчлэн ногоон эдийн засгийн цөм болсон сэргээгдэх эрчим хүчний хөгжил тодорхой сорилтуудтай тулгарсаар байна. Дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтэй холбоотойгоор гол мөрний ус татарснаар усан цахилгаан станц, салхин станцуудад асуудал үүсэж байгаа ажээ.

БНСУ-ын хувьд дижитал технологид суурилсан халуун цөмийн гинжин урвалын реакторыг бүтээж, наран дээрх эрчим хүчийг гарган авах мөч хаяанд иржээ. Үүнийг “artificial sun” гэж нэрлэж байна.²⁵ (ITER: World's largest nuclear fusion project begins assembly. 28 July 2020 <https://www.bbc.com/news/science-environment-53573294>) Ус төрөгчийн бөмбөгийн дэлбэрэлт нь нарны өдөр тутмын ердийн амьдрал билээ. Энэ бол эрчим хүчний шавхагдашгүй эх сурвалж мөн. Халуун цөмийн реактор нь бүрэн төгс аюулгүй бөгөөд учир нь, түүн дотор дэлбэрэх зүйл огт байхгүй гэдэг нь хамгийн гол онцлог ажээ. Дулааны болон атомын цахилгаан станцуудаас ялгаатай нь халуун цөмийн нэгдлийн

²⁵ ITER: World's largest nuclear fusion project begins assembly. 28 July 2020 <https://www.bbc.com/news/science-environment-53573294>

гинжин урвалын реактор нь хүлэмжийн хийгээр агаар мандлыг бохирдуулахгүй, цацраг идэвхт хорт хог хаягдал ялгаруулахгүй ажээ.²⁶ (ITER: Ceremony marks start of the assembly phase. 28 July 2020, Brussels Energy https://ec.europa.eu/info/news/iter-ceremony-marks-start-assembly-phase-2020-jul-28_en) Энэхүү мега төсөл бол цоо шинэ үеийн технологид суурилсан дэлхийн эрчим хүчний аюулгүй байдлыг хангах тухай асуудал болж байна.

БНСУ-ын эрдэмтэд цөмийн нэгдлийн туршилт (nuclear fusion test) явуулж, нарны цөмөөс долоо дахин их буюу 100 сая хэмийн температурыг үүсгэн дэлхийн дээд амжилтыг тогтоов.²⁷ ('Artificial sun' sets record for time at 100 million degrees in latest advance for nuclear fusion <https://edition.cnn.com/2024/04/01/climate/nuclear-fusion-record-korea-climate-intl/index.html>) Энэхүү туршилт нь ирээдүйн энергийн эх үүсвэрт хүрэх чанарын цоо шинэ алхам болно гэж эрдэмтэд онцолжээ. “Өндөр температур болон өндөр нягтаршилтай плазма нь ирээдүйн цөмийн нэгдлийн дээд амжилтуудыг дахин тогтооход гол үүрэгтэй” гэж туршилтыг амжилттайгаар явуулсан “Fusion Energy” хүрээлэнгийн (KFE)

дэргэдэх “KSTAR” судалгааны төвийн захирал Си-Бу Юн (Si-Woo Yoon) мэдэгджээ.

“KFE”-ийн “хиймэл нар” гэгддэг хайлуулах судалгааны төхөөрөмж “KSTAR” нь 2023 оны арван хоёрдугаар сараас 2024 оны хоёрдугаар сарын хооронд хийсэн туршилтын явцад плазмыг 100 сая градусын температурт 48 секундийн турш барьж чадсан байна. Энэхүү амжилт нь 2021 онд тогтоосон 30 секундийн өмнөх рекордыг ахиулсан юм.

Цөмийн нэгдэл нь нар болон бусад оддын гэрэлтүүлэх урвалыг давтаж, хоёр атомыг нийлүүлснээр хязгааргүй их эрчим хүч ялгаруулах явдал бөгөөд ба нэг элементийн хоёр атомыг нэгтгэж гурав дахь, илүү хүнд элементийн атомыг үүсгэдэг явц ажээ. Реакторын түүхий эд нь uranium 235 биш, харин байгальд элбэг байдаг устөрөгчийн изотопууд болох дейтерий (deuterium) ба тритий (tritium) (хэдэн грамм) ажээ. Тиймээс цацраг идэвхт бодис ялгаруулна гэсэн ойлголт байхгүй юм. Цэвэр эрчим хүчний шийдлийн “ариун дагшин” гэгддэг энэхүү цөмийн нэгдэх явц нь нүүрстөрөгчийг огт ялгаруулахгүйгээр эрчим хүчний шавхагдашгүй эх үүсвэрийг бий болгоход оршино.

Дижитал худалдаа, санхүүгийн технологийг (FinTech) эдүгээ олон нийт өргөн хүрээнд ашигладаг өдөр тутмын энгийн зүйл болов. Финтек гэдэг нь дижитал технологид суурилсан

²⁶ ITER: Ceremony marks start of the assembly phase. 28 July 2020, Brussels Energy https://ec.europa.eu/info/news/iter-ceremony-marks-start-assembly-phase-2020-jul-28_en

²⁷ 'Artificial sun' sets record for time at 100 million degrees in latest advance for nuclear fusion <https://edition.cnn.com/2024/04/01/climate/nuclear-fusion-record-korea-climate-intl/index.html>

санхүүгийн үйл ажиллагаа буюу блокчейн технологийн санхүүгийн салбар дахь access гэж томъёолж болно. Өнөөдөр online худалдаа, санхүүгийн үйл ажиллагааны загварыг дижитал технологийн хөгжүүлэлтийг ашиглан өөрчилж буй шинэ салбар юм.²⁸ (Schüffel, Patrick (2016). Taming the Beast: A Scientific Definition of Fintech. Journal of Innovation Management. pp. 32–54) *Нөгөө талд хөгжлийн чухал тренд нь банк, санхүүгийн байгууллага, үүрэн телефоны компаниуд хоорондын интеграци гэж нэрлэж болно.* Өнөөдөр дэлхий нийтийн хэмжээнд гүйлгээнд буй мөнгөний 90 хувь нь цахим хэлбэрт, 10 хувь нь бэлнээр хийгдэж байгаа бол БНСУ-д 1000 воны 999 нь цахим хэлбэрт, 1 вон нь бэлнээр хэрэглэгдэж байгаа ажээ.

Их өгөгдөл буюу *big data* нь шинэ стратеги, багцыг бий болгох, хэрэглэгчийн зарцуулалтын зуршилд дүн шинжилгээ хийх, залилангийн илрүүлэлтийг сайжруулах, маркетингийн стратегийг буй болгохын тулд үйлчлүүлэгчийн хөрөнгө оруулалт болон зах зээлийн өөрчлөлтийг урьдчилан таамаглах боломжтой болгож байгаа ажээ.²⁹ (Xu, Lei; Gao, Runpeng; Xie, Yu; Du, Peng (January

2019). “To Be or Not to Be? Big Data Business Investment Decision-Making in the Supply Chain”. Sustainability. 11 (8): 2298. doi:10.3390/su11082298.)

III. Монгол Улс дахь дижитал хөгжлийн эрх зүйн орчин

Хууль эрх зүйн орчин: Монгол Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны хурлын үеийн мэдээллээр Монгол Улсын хүн ам цөөн ч 2022 оны долоодугаар сарын байдлаар гар утас хэрэглэгчийн тоо 4.3 саяд хүрчээ. Үүний 3.4 сая ухаалаг гар утас хэрэглэгч байгаагаас 64 хувь нь 4G өндөр хурдны интернет хэрэглэдэг байна. Нийт ухаалаг гар утас хэрэглэгчдийн 93 орчим хувь нь санхүүгийн байгууллагад данстай бөгөөд 22 орчим хувь нь уг дансаа гар утсаараа дамжуулан удирддаг байна. Ухаалагч гар утас хэрэглэгчдийн дийлэнх хувь буюу 2.5 сая хэрэглэгч нийгмийн сүлжээнд идэвхтэй оролцдог. Нийт 96 их, дээд сургуульд 160 орчим мянган оюутан суралцаж байгаагийн 2.3 хувь нь харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын чиглэлээр суралцдаг. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбар ДНБ-ий 2.3 хувийг бүрдүүлдэг. Монгол Улсад нийт 3,500 орчим харилцаа холбоо, мэдээллийн технологийн компани үйл ажиллагаа явуулж байгаагаас 33 хувь нь санхүүгийн, 30 хувь нь боловсролын, 14 хувь нь бусад салбарын чиглэлээр

²⁸ Schüffel, Patrick (2016). Taming the Beast: A Scientific Definition of Fintech. Journal of Innovation Management. pp. 32–54

²⁹ Xu, Lei; Gao, Runpeng; Xie, Yu; Du, Peng (January 2019). “To Be or Not to Be? Big Data Business Investment Decision-Making in the Supply Chain”. Sustainability. 11 (8): 2298. doi:10.3390/su11082298.

ажилладаг байна.³⁰ (УИХ-ын Инновац, цахим бодлогын байнгын хорооноос Монгол Улс, БНСУ-ын мэдээллийн технологийн салбарын байгууллага, мэргэжилтэн, судлаачдын хамтарсан “Цахим шилжилтэд анхаарах асуудал” сэдэвт анхдугаар уулзалт, хэлэлцүүлэг. 2022.07.19 <http://www.parliament.mn/n/1y4yn>) Улаанбаатар хотын орчинд 5G сүлжээнд шилжих бэлтгэлийг Univision эхлүүлээ.

2022 оны II улирлын байдлаар интернет хэрэглэгч 4.1 сая болж, өмнөх оны мөн үеийнхээс 3.4 хувь, кабелийн телевиз хэрэглэгч 975.7 мянга болж, өмнөх оны мөн үеэс 3.5 хувиар тус тус өссөн байна.³¹ (Үндэсний статистикийн хорооны мэдээлэл. 2022.08.17) Дээрх тоон үзүүлэлтээс харахад Монгол Улсад финтек хөгжих боломж хэдийн бүрдсэн гэж дүгнэж болохоор байна.

УИХ-ын Инновац, цахим бодлогын байнгын хорооноос Монгол Улсад цахим шилжилт хийх хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэв. УИХ-ын 2021 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Инновац, цахим бодлогын байнгын хороо дангаараа болон Хууль зүй, Аюулгүй байдал, гадаад бодлогын болон Эдийн засгийн байнгын хороотой

хамтран хэлэлцэж УИХ-ын нэгдсэн чуулган *Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай анхдагч хууль зэрэг таван хуулийг* баталснаар Монгол Улс дэлхий дахинаа өрнөж буй аж үйлдвэрийн IV хувьсгалд суурилсан дижитал үйл явцтай хөл нийлүүлэн алхаж, цахим шилжилт хийх хууль, эрх зүйн орчин бүрдэж байгаа юм. ³² (“ИЦББХ: Монгол Улсад цахим шилжилт хийх хууль эрх зүйн орчныг бүрдүүлээ”)

Дэлхий дахинд өргөн тархаж буй блокчэйн технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээ Монгол Улсад ч өргөн дэлгэрч ялангуяа 2021–2022 онд виртуал хөрөнгийн арилжааны платформын тоо ихээр нэмэгдэж, койн, токен гаргах нь олширч, олон нийтээс хөрөнгө татахын зэрэгцээ иргэд, олон нийт эдгээрт хөрөнгө оруулах сонирхол нь өсөн нэмэгдсээр байгаа юм.

Энэ хууль батлагдсанаар төвлөрсөн бус тархмал систем (блокчэйн), дэвшилтэт технологи дээр суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, виртуал хөрөнгийг хүлээн зөвшөөрдөг, цахим шилжилтийг дэмжсэн, Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн холбогдох харилцааг зохицуулсан эрх зүйн орчинтой улс орон албан

³⁰ УИХ-ын Инновац, цахим бодлогын байнгын хорооноос Монгол Улс, БНСУ-ын мэдээллийн технологийн салбарын байгууллага, мэргэжилтэн, судлаачдын хамтарсан “Цахим шилжилтэд анхаарах асуудал” сэдэвт анхдугаар уулзалт, хэлэлцүүлэг. 2022.07.19 <http://www.parliament.mn/n/1y4yn>

³¹ Үндэсний статистикийн хорооны мэдээлэл. 2022.08.17

³² “ИЦББХ: Монгол Улсад цахим шилжилт хийх хууль эрх зүйн орчныг бүрдүүлээ” <http://parliament.mn/n/ic3yn>

ёсоор болсноор гадаадын хөрөнгө оруулагчдын сонирхлыг татах, цаашид эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх суурь нөхцөл бүрдэж байна.

Монгол Улсын Засгийн газар “Цахим үндэстэн” болох зорилт дэвшүүлж 2020 оны аравдугаар сард “e-Mongolia” нэгдсэн системийг нээж, төрийн 23 байгууллагын 181 үйлчилгээг нэвтрүүлсэн бол өнөөдөр 1.8 сая хэрэглэгчтэй болж, тус системд 86 байгууллагын 1233 үйлчилгээ нэвтэрчээ. “e-Mongolia” жилийн өмнө 3.0 хувилбараа танилцуулж байсан бол өнөөдөр илүү дэвшилтэт 4.0 хувилбараа нээж хэрэглээнд нэвтрүүлээ.

“e-Mongolia 4.0” хувилбар нь иргэдэд зээлийн лавлагаа авах, виза мэдүүлэх, бичиг баримт захиалах зэрэг хэрэгцээт мэдээллийг багцаар санал болгож, дуу хоолойгоор дамжуулж мэдээллээ хайх, чатботоор хүссэн мэдээллээ авах боломжийг бүрдүүлж, иргэд хоорондоо харилцах үндэсний чатыг үүсгэжээ. Мөн эмнэлэгт цаг авах, шинжилгээ, дүрс оношилгооны хариу, эмнэлэг, эмийн танилцуулга, жорын түүх харах зэрэг эрүүл мэндийн олон үйлчилгээг цахимжуулж, замын хураамж, жолоочийн торгууль, оношилгоо, даатгалын мэдээлэл, цаг агаар, үер усны аюул, угаар мэдрэгчийн дохио зэрэг мэдээлэл, сонордуулгыг иргэдэд өгдөг болж байна. “e-Mongolia” систем төрийн үйлчилгээг цахимжуулж, шуурхай, нээлттэй, хүртээмжтэй болгож *иргэдийн мэдэх эрхийг хангахад*

онцгой үүрэг гүйцэтгэж байна. Үүний үр дүнд тухайлбал, далд эдийн засаг ил болж эдийн засаг 43 их наядаас 69 их наядад хүрч, нийгэмд авлигыг үл тэвчих сэтгэл зүй бий болжээ. Үндэсний баялгийн сангийн тухай хууль саяхан батлагдлаа. “e-Mongolia 4.0” Үндэсний баялгийн сангийн мэдээлэлтэй мөн холбогдож байна.

2024 оны тавдугаар сард Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай анхдагч хуулийн төслийн хэлэлцүүлэг болсон юм Энэхүү төсөл нь Мэдээллийн технологийн үндэсний үйлдвэрлэлийн олон улсад өрсөлдөх чадамжийг сайжруулах, эдийн засагт үзүүлэх үр өгөөжийг дэмжих, хөдөлмөрийн зах зээл дэх шинэ ажлын байрыг нэмэгдүүлэх, инновацыг хөгжүүлэх зорилготой төсөл юм. Дээрх хуулийн төсөлд тусгагдсан онцлох заалтуудаас дурдвал:

- Хиймэл оюун ухаан, их өгөгдөл, сансар судлал зэрэг дэвшилтэт технологийн хөгжлийг түлхүү дэмжиж, энэ чиглэлийн хүний нөөц бэлтгэх, судалгаа шинжилгээг хөгжүүлэх, мэдээлэл технологийн компаниудыг татварын болон татварын бус хэлбэрээр төрөөс нэгдсэн бодлогоор дэмжинэ.
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт, оюуны өмчийн шагнал урамшуулал, грант олгоно.

- Мэдээллийн технологийн дэмжлэг үзүүлэх виртуал бүс байгуулж, гадаад дотоодын технологийн компаниуд, хөрөнгө оруулагчдыг бүртгэж, олон улсад гарах зорилготой бүс нутгийн хэмжээний мэдээлэл технологийн хаб байгуулна.
- Хиймэл оюун ухаан, их өгөгдөл, сансрын үйлдвэрлэлийн дэвшилтэт технологид суурилсан сэндбоксын орчин бий болгоно.
- Мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, гарааны компанийн зах зээлийн үнэлгээг Сангийн яам, Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институттэй хамтран хийж эдийн засгийн эргэлтэд оруулахад дэмжлэг үзүүлнэ.
- Монгол Улс нь мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг эдийн засагт үзүүлэх үр өгөөжийг нэмэгдүүлэх замаар цахим эдийн засгийг дэмжиж, хөдөлмөрийн зах зээл дахь шинэ ажлын байрыг нэмэгдүүлэх ажээ.

Дижитал эдийн засгийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг болсон финтех хэмээх хүртээмжтэй санхүүгийн цоо шинэ үйлчилгээ, дижитал худалдаа Монгол Улсад ч хөгжлийн шинэ тренд болов.

IV. Төгсгөл

БНСУ-д дижитал үйл явц нийгэм-эдийн засгийн бүх салбарыг хамарч, эргэлт буцалтгүй үйл явц болов. Өнөөгийн Өмнөд Солонгос нь шинжлэх ухаан-технологийн урьд үзэгдээгүй ахиц, дэвшлийг Шинэ мянганд гаргах материаллаг болон оюун санааны үлэмж чадавхтай орон юм. БНСУ нь мэдээлэл, харилцаа холбооны технологи, өндөр технологийн суурь буюу дээд бүтэц (infrastructure), нэг хүнд оногдох нийтийг хамарсан өндөр хурдны интернетийн сүлжээ, гол эдийн засгийн бүтцүүдийн хоорондох интеграцчилал, инновацчиллаар дэлхийд хамгийн өндөрт буюу эхний топ 10-т орж байгааг онцолж байна.

2023 оны долоодугаар сард БНСУ дижитал худалдааны сүлжээгээ өргөжүүлэхийн тулд Дижитал эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрт нэгдэхийг зөвшөөрчээ. БНСУ тийнхүү үүсгэн байгуулагч орнууд болох Чили, Шинэ Зеланд, Сингапуртай нэгдэн 4 гишүүнтэй эвсэл байгуулав.³³ (#SouthKorea #Digital_Economy_Partnership_Agreement #digital_trade_network. Jun 9, 2023) OECD³⁴-ын (Парис төвтэй Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага) Сайд нарын зөвлөлийн хурлын үеэр Парист анхны гишүүдтэй БНСУ

³³ #SouthKorea #Digital_Economy_Partnership_Agreement #digital_trade_network. Jun 9, 2023 #SouthKorea #digital_content #Arirang_News

³⁴ Парис төвтэй Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага

хэлэлцээ хийжээ. Энэ нь дижитал худалдааны асуудалд шинэ хандлага, хамтын ажиллагааг буй болгосон дэлхийн анхны үндэстэн дамнасан дижитал гэрээ юм. Хэлэлцээрийн дагуу БНСУ дижитал худалдаанд суурилсан экспортыг нэмэгдүүлж, дижитал контент, үйлчилгээг гадаадад өргөжүүлэхээр төлөвлөж байгаагаа мэдэгдэв. Засгийн газар гишүүнчлэлээ 2023 оны эцэст дуусгасан байна.

2023 оны тавдугаар сард Улаанбаатар хотноо Монгол Улс, АНУ, БНСУ-ын гурван талт хамтын ажиллагааны шинэ форматын үндэс суурь тавигдав. Анх удаа зохион байгуулагдсан уулзалтаар талууд бүс нутаг болон олон улсын аюулгүй байдлын харилцан сонирхсон өргөн хүрээний асуудлаар санал солилцож, тээвэр ложистикийн сүлжээ, эрчим хүч, эрдэс баялаг, хүнсний аюулгүй байдал, уур амьсгалын өөрчлөлт, хөгжлийн хамтын ажиллагааны чиглэлээр хамтран ажиллахаар тогтсон байна. Талууд гурван талт уулзалтын механизмыг цаашид тогтмол зохион байгуулахаар тохиролцож, Хамтарсан хэвлэлийн Мэдээ гаргав.³⁵ (Монгол Улс, БНСУ, АНУ-ын гурван талт анхдугаар уулзалт болов. 2023.05.31 <https://mfa.gov.mn/73961>) Хэвлэлийн мэдээнд “...Эрчим хүчний аюулгүй байдал, ашигт малтмалын нөөц, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх, тээвэр,

нийлүүлэлтийн сүлжээ, хүнсний аюулгүй байдал, оюуны өмчийн эрх, түүнчлэн худалдаа, хөрөнгө оруулалтын боломжийг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн түншлэлийн харилцааг гүнзгийрүүлэх хүсэлтэй байгаагаа талууд онцлон тэмдэглэв. Гурван тал энэ зорилгоор янз бүрийн түвшинд, тэр дундаа дэлхийн эрдэс баялгийн нийлүүлэлтийн сүлжээнд Монгол Улсын гүйцэтгэх үүрэг зэрэг асуудлаар өндөр түвшний яриа хэлэлцээг үргэлжлүүлэхээр шийдэв.

Монгол Улсын Засгийн газар цэвэр эрчим хүчний шилжилтийн дэлхийн ханган нийлүүлэлтийн сүлжээг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулах хүсэлтэй байгаагаа илэрхийлж, АНУ, БНСУ-ын Засгийн газрыг 2023 онд Улаанбаатар хотноо удахгүй болох эрдэс баялаг болон холбогдох асуудлаар тусад нь гурван талт уулзалт зохион байгуулахыг урьсан нь амжилттай болов.³⁶ (Joint Press Release on the Launch of the Mongolia–Republic of Korea–United States Trilateral Meeting. May 30, 2023 MFA, Ulaanbaatar, Mongolia <https://mn.usembassy.gov/pr-060523/>)

Дээрх Хамтарсан мэдэгдлийн дагуу АНУ, Монгол, БНСУ гурван талын чухал ач холбогдолтой ашигт малтмалын асуудлаарх анхны яриа хэлэлцээ 2023 оны зургаадугаар сард

³⁵ Монгол Улс, БНСУ, АНУ-ын гурван талт анхдугаар уулзалт болов. 2023.05.31 <https://mfa.gov.mn/73961>

³⁶ Joint Press Release on the Launch of the Mongolia–Republic of Korea–United States Trilateral Meeting. May 30, 2023 MFA, Ulaanbaatar, Mongolia <https://mn.usembassy.gov/pr-060523/>

Улаанбаатарт болж, тус арга хэмжээний үеэр Монгол Улсын хэмжээнд ашигт малтмал хайх, ашиглахыг хориглосон, хязгаарласан талбай нийт нутаг дэвсгэрийн 75 хувийг эзэлж байна, цаашид Монгол Улс өөрийн ашигт малтмалын хэтийн төлөвийг судалж, дэлхийн хэмжээнд нийлүүлэлт дутмаг ашигт малтмалыг олборлох, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг зорьж байгаа тухай мэдээлсэн юм. Уулзалтаар уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарт хөрөнгө оруулалт татах, ашигт малтмалын салбарын хөгжлийг шинэ шатанд гаргах зорилгын хүрээнд чухал ашигт малтмалыг онцлон хэлэлцэв. Чухал ашигт малтмалыг олборлох чиглэлээр АНУ, БНСУ-тай хамтран ажиллаж байна. Мөн “Монгол Улс дэлхийн чухал ашигт малтмалын нөхцөл байдал” сэдвээр илтгэл тавьж Монгол Улсын талаас эрчим хүчний чиглэлээр Засгийн газар хоорондын байнгын хамтын ажиллагааны салбар комисс байгуулах, газрын тос, байгалийн хийн хайгуулын чиглэлээр хамтран ажиллах талаар ярилцаж, салбарын мэргэжлийн боловсон хүчнийг богино хугацаанд чадавхжуулах зорилгоор холбогдох мэргэжилтнийг Монгол Улсад ажиллуулах хүсэлтэй байгааг уламжилсан юм.³⁷ (Inaugural U.S.-Mongolia-ROK Critical Minerals Dialogue Held in Ulaanbaatar. Media

Note. June 27, 2023 <https://mn.usembassy.gov/pr-062723-2/>)

2023 оны арван нэгдүгээр сард Монгол Улс, БНСУ газрын ховор металл, бусад чухал ашигт малтмал нийлүүлэх чиглэлээр хамтран ажиллах Хамтарсан Хороог байгуулав. Хоёр тал БНСУ-аас Монгол Улсад үзүүлэх хөгжлийн албан ёсны тусламжийн хүрээнд газрын ховор элементийн салбарт түншлэх Хамтарсан Төв байгуулах төслийг эхлүүлэв. “Энэхүү төсөл нь Монгол Улсын хувьд газрын ховор металлыг нэмэгдсэн өртөг шингэсэн бүтээгдэхүүн болгон хувиргах, Солонгосын талд дотоодын нийлүүлэлтийн сүлжээгээ бэхжүүлэх боломжийг бүрдүүлнэ гэдэгт найдаж байна” гэж Худалдаа, аж үйлдвэр, эрчим хүчний дэд сайд Ий Хо-хён (Lee Ho-hyeon) Улаанбаатарт болсон ёслолын үеэр мэдэгджээ.³⁸ (Korea, Mongolia launch cooperation committee for rare metals supply. 2023-11-20) Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн 2023 оны хоёрдугаар сард БНСУ-д хийсэн албан ёсны айлчлалын үеэр Газрын ховор элемент нийлүүлэх сүлжээнд Хамтран ажиллах тухай Харилцан Ойлголцлын Санамж бичгийг хоёр тал байгуулсан ба хамтын ажиллагааны хүрээнд Монгол Улсад газрын ховор элементийн судалгааны Төвийг тийнхүү байгуулсан нь хоёр улсын стратегийн түншлэлийн чухал

³⁷ Inaugural U.S.-Mongolia-ROK Critical Minerals Dialogue Held in Ulaanbaatar. Media Note. June 27, 2023 <https://mn.usembassy.gov/pr-062723-2/>

³⁸ Korea, Mongolia launch cooperation committee for rare metals supply. 2023-11-20 https://www.koreatimes.co.kr/www/nation/2023/11/113_363533.html

хэсэг гэж үзэж байна.³⁹ (“South Korea–Mongolia launch rare metals cooperation amid geopolitical risks” November 21, 2023 <https://koreapro.org/2023/11/south-korea-mongolia-launch-rare-metals-cooperation-amid-geopolitical-risks/>)

2024 оны хавраас Солонгос иргэд Монголд, монгол иргэд БНСУ–д өөр өөрийн орны төлбөрийн application ашиглан төлбөр тооцоо хийх эдийн засаг, эрх зүйн боломж бүрдэж байна. Монгол Улсад жилд дунджаар 100 гаруй мянган солонгос иргэд аялал жуулчлалын зорилгоор ирж, нэг тэрбум гаруй долларын орлого оруулдаг бол сурч хөдөлмөрлөх, эмчлүүлэх болон аялал жуулчлалын зорилгоор жилд 120 мянган монголчууд БНСУ руу аялж байгаа юм.⁴⁰ (Солонгос, Монголд төлбөр тооцоог хэмнэлттэй, хурдан хийх боломж бүрдлээ. 2024–04–01 <https://news.mn/r/2711639/>)

Монгол Улсад дижитал шилжилт үйлчилгээний салбараас үйлдвэрлэлийн салбар луу шилжиж байна гэж үзэх үндэс бүрдэж, 4G–гээс 5G рүү шилжих эхлэлийг Unitel компани тавилаа. Тэгэхлээр суурь бүтцийг бүрдүүлэх явдлыг улам эрчимжүүлэх явдал чухал болж байна.

Эцэст нь, Төр засаг хувийн

³⁹ “South Korea–Mongolia launch rare metals cooperation amid geopolitical risks” November 21, 2023 <https://koreapro.org/2023/11/south-korea-mongolia-launch-rare-metals-cooperation-amid-geopolitical-risks/>

⁴⁰ Солонгос, Монголд төлбөр тооцоог хэмнэлттэй, хурдан хийх боломж бүрдлээ. 2024-04-01 <https://news.mn/r/2711639/>

хэвшлийн энтрепренёр чадавхыг үнэлэх, инновац, дижитал технологийн хөгжлийг тууштай дэмжих явдал чухал билээ. Түүнчлэн дурдсан чиглэлд Монгол Улс, БНСУ–ын стратегийн түншлэлийн эдийн засгийн агуулгыг баяжуулахад дижитал салбарын хамтын ажиллагааг улам гүнзгийрүүлэх явдал болно.

Ашигласан эх сурвалж

Works Cited

1. “Private sector accounts for 80% of Korean R&D investment in 2022” 2023.12.11. (n.d.).
2. #SouthKorea #Digital_Economy_Partnership_Agreement #digital_trade_network. Jun 9, 2023 . (n.d.).
3. ‘Artificial sun’ sets record for time at 100 million degrees in latest advance for nuclear fusion <https://edition.cnn.com/2024/04/01/climate/nuclear-fusion-record-korea-climate-intl/index.html> . (n.d.).
4. “Korea Communication Market Data”. Netmanias. 30 May 2021. Archived from the original on 15 August 2022. R. (n.d.).
5. “South Korea invests big in becoming a global chip leader”. DW News. January 24, 2024. (n.d.).
6. “South Korea–Mongolia launch rare metals cooperation amid geopolitical risks” November 21, 2023 <https://koreapro.org/2023/11/south-korea-mongolia-launch-ra>

- re-metals-cooperation-amid-geopolitical-risks/. (n.d.).
7. “South Korea's Semiconductor Output Rises by Most in 14 Years”. Bloomberg. March 29, 2024. (n.d.).
8. “The rise of Korea's semiconductor industry”. KBS WORLD. July 10, 2017. (n.d.).
9. “ИЦББХ: Монгол Улсад цахим шилжилт хийх хууль эрх зүйн орчныг бүрдүүлээ”. (n.d.).
10. “ИЦББХ: Монгол Улсад цахим шилжилт хийх хууль эрх зүйн орчныг бүрдүүлээ”. (n.d.).
11. D. Ulambayar. (n.d.). Dean, School of International Relations & Social Studies, University of the Humanities, Ulaanbaatar, Mongolia.
12. E-Commerce Statistics of 2024. March 28, 2024 <https://www.forbes.com/advisor/business/ecommerce-statistics/>. (n.d.).
13. e-World: Towards Digitization. Ang Byong-yub speech. “The Korea Times” Nov. 9, 2017. (n.d.).
14. Ibid., (n.d.).
15. Ibid., . (n.d.).
16. Inaugural U.S.-Mongolia-ROK Critical Minerals Dialogue Held in Ulaanbaatar. Media Note. June 27, 2023 <https://mn.usembassy.gov/pr-062723-2/> . (n.d.).
17. ITER: Ceremony marks start of the assembly phase. 28 July 2020, Brussels Energy https://ec.europa.eu/info/news/iter-ceremony-marks-start-assembly-phase-2020-jul-28_en. (n.d.).
18. ITER: World's largest nuclear fusion project begins assembly. 28 July 2020 <https://www.bbc.com/news/science-environment-53573294>. (n.d.).
19. Joint Press Release on the Launch of the Mongolia-Republic of Korea-United States Trilateral Meeting. May 30, 2023 MFA, Ulaanbaatar, Mongolia <https://mn.usembassy.gov/pr-060523/>. (n.d.).
20. Korea joins 10-nation statement on endorsing 6G principles. 2024-02-27 . (n.d.).
21. Korea, Mongolia launch cooperation committee for rare metals supply. 2023-11-20 . (n.d.).
22. National Strategy for Artificial Intelligence <https://www.msit.go.kr/bbs/view.do?sCode=eng&nttSeqNo=9&bbsSeqNo=46&mId=10&mPid=9> . (n.d.).
23. Number of higher education institutions South Korea 1980-2023, Feb 27, 2024. (n.d.).
24. Number of SMEs South Korea 2017-2021. March 12, 2024 <https://www.statista.com/statistics/1223066/south-korea-small-and-medium-enterprises-number/#:~:tex>. (n.d.).
25. Ranking of the companies with the highest spending on research and development worldwide in 2022 (in billion U.S. dollars) <https://www.statista.com/statistics/265645/ranking-of-the-20-companies-with-the-highest-spend>

- ing-on-research-and-development/ . (n.d.).
26. Samsung opens research center to begin initial work on 6G. May 4, 2019 <https://www.techspot.com/news/80382-samsung-opens-research-center-begin-initial-work-6g.html>. (n.d.).
27. Samsung PH sees record pre-orders with Galaxy S24 Series. 1/01/2024 <https://news.samsung.com/ph/samsung-ph-sees-record-pre-orders-with-galaxy-s24-series>. (n.d.).
28. Schöffel, Patrick (2016). Taming the Beast: A Scientific Definition of Fin-tech. *Journal of Innovation Management*. pp. 32–54. (n.d.).
29. T.W.Kang. (n.d.). Is Korea the next Japan?: Understanding the Structure, Strategy, and Tactics of America’s Next Competitor. Free Press. The University of California. N.Y.: 1989.
30. The Global Competitiveness Report 2019. Klaus Schwab. World Economic Forum http://www3.weforum.org/docs/WEF_TheGlobalCompetitivenessReport2019.pdf. (n.d.).
31. Top 10 Mobile Brands in the World 2023. <https://www.globalbrandsmagazine.com/top-10-mobile-brands-in-the-world-2023/>. (n.d.).
32. UN agency upgrades Korea’s status to developed economy. (n.d.).
33. WEF. The Global Information Technology Report-The NRI 2019 Countries. <https://networkreadinessindex.org/2019/nri-2019-countries/>. (n.d.).
34. Xu, Lei; Gao, Runpeng; Xie, Yu; Du, Peng (January 2019). “To Be or Not to Be? Big Data Business Investment Decision-Making in the Supply Chain”. *Sustainability*. 11 (8): 2298. doi:10.3390/su11082298. (n.d.).
35. Д.Уламбаяр. ХИС-ийн Олон улсын харилцаа, н. с. (n.d.).
36. ДНБ-ий 1 хувийг эрдэм судлалын ажилд зарцуулах хэрэгтэй. 2019.09.27 <https://president.mn/11094/>. (n.d.).
37. Монгол Улс, БНСУ, АНУ-ын гурван талт анхдугаар уулзалт болов. 2023.05.31 <https://mfa.gov.mn/73961>. (n.d.).
38. Нийт төрийн 288 байгууллагын 9.7 хувийг төрийн өмчит 28 компани, төрийн өмчит 83 байгууллага 28.8 хувийг тус тус эзэлж байна. Ангилалгүй байгууллагын тоо 177 (61. хувь) байгаа ажээ. http://nation-alatlas.ngii.go.kr/pages/page_579.php#:~:text=. (n.d.).
39. Парис төвтэй Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага. (n.d.).
40. Солонгос, Монголд төлбөр тооцоог хэмнэлттэй, хурдан хийх боломж бүрдлээ. 2024-04-01 <https://news.mn/r/2711639/>. (n.d.).
41. УИХ-ын Инновац, цахим бодлогын байнгын хорооноос Монгол Улс, БНСУ-ын мэдээллийн технологийн салбарын байгууллага, мэргэжилтэн, судлаачдын хамтарсан “Цахим шилжилтэд анхаарах асуудал” сэдэвт анхдугаар уулзалт, хэлэлцүүлэг. 2022.07.19 <http://www.parliament.mn/>. (n.d.).
42. Үндэсний статистикийн хорооны мэдээлэл. 2022.08.17. (n.d.).

ОХУ-ЫН ЗУРАГТЫН “ЗВЕЗДА” СУВАГ СОЛОНГОСЫН ХУВААГДЛЫН ТУХАЙ

Д. Нарантуяа¹

hiimoritoi@gmail.com

Хураангуй

Оросын Холбооны Улсын зүгээс 1950-аад оны Солонгосын хойгийн хуваагдлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр яаж тайлбарлаж байгааг шинжлэх зорилгоор Солонгосын асуудалтай холбоотой Война миров нэвтрүүлэгт баримтын судалгаа хийлээ. Эдгээр нэвтрүүлэг нь Солонгосын тухай холбогдох баримт материалыг Оросын түүхчдийн оролцоотой тайлбарлахын зэрэгцээ аливаа өдөөн хатгалт, хуваагдлын эх үүсвэр нь АНУ-аас улбаатай гэсэн санааг үзэгчдэдээ илгээжээ. Нэвтрүүлэгт дэлгэсэн баримтууд Солонгосын хуваагдал нь АНУ-тай төдийгүй ЗХУ-тай холбоотойг илтгэж байлаа. Үүгээрээ тэд санаатай болон санаандгүйгээр аливаа гүрний “ивээл” ба өдөөн хатгалгад (өөрсдөө ч, өөрсдөд нь ч) буурьтай хандахыг анхааруулжээ.

Түлхүүр үг: Звезда, Война миров нэвтрүүлэг, Солонгосын хуваагдал, баримтат кино, АНУ

Удиртгал

Дэлхийн 2 дугаар дайны Азид үүрлэсэн сүүлчийн голомтыг унтраахад АНУ ба Зөвлөлт Холбоот Улс (ЗХУ) түүчээлэн оролцсон билээ. 1945 оны 8 дугаар сард Зөвлөлтийн Улаан арми, Манжуурыг болон Солонгосын хойд нутгийг Японоос чөлөөлжээ. 1945 оны 9 дүгээр сарын 2-нд Америкийн байлдааны Миссури усан онгоц дээр Японы зэвсэгт хүчний командлал үг дуугүй бууж өгөх тухай актад гарын үсэг зурж, Япон бууж өгснөө албан ёсоор зарласнаар Дэлхийн II дайн шувтарсан юм. АНУ, Японтой

хийсэн дайнаа дуусгамагц 38 дугаар шугамаас өмнөх Солонгосын нутгийг чөлөөлж төвхнүүлэх төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхээр 1945 оны 9 дүгээр сард Инчеоны эрэгт цэргээ буулгаж, Сөүл нийслэлтэй цэргийн засгийн газрыг байгуулжээ.

Солонгосын хойгийг өмнөд, хойд болгон хуваасан 38 дугаар шугам нь өргөрөг биш, “Штабын дарга нарын зөвлөгөөний дагуу нарийн бичгийн дарга Стимсоны шугам татах санаачилгад үндэслэн гаргасан цэвэр цэргийн шийдвэр” байсан (National Archives:4) бөгөөд энэ шугамын хойно

¹ МУИС, НУС-ийн зөвлөх дэд профессор, социологийн ухааны доктор. Аман түүхч

10 сая, өмнө нь 20 сая хүн аж төрж байлаа. 1945 оны 12 дугаар сарын Их Британи, АНУ, ЗХУ-ын Гадаад явдлын сайд нарын Москвагийн бага хурлаар Солонгосын байдлыг хэлэлцээд “Холбоотнуудын ивээл”-ийн 5 хүртэлх жилийн дэглэм тогтоосон ч солонгосууд аливаа ивээл, эрхшээлийн эсрэг байв.

Хоёр Солонгост ардчилсан сонгууль явуулах санаачилгыг АНУ НҮБ-д тавьснаар 1948 онд өмнөдөд анхдугаар сонгууль явагдаж, Ли Сын Ман ерөнхийлөгчөөр сонгогдсон юм. 1948 оны 8 дугаар сарын 15-нд Бүгд Найрамдах Солонгос Улсыг тунхаглаж, 1948 оны 9 дүгээр сарын 9-нд Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс (БНАСАУ) тусгаар тогтнолоо зарласан байна. Зөвлөлтийн нөлөөн дэх умард, Америкийн ивээл дэх өмнөдийнхөн бие биеэ өдөөн хатгасаар, эцэстээ нэг нь нөгөөгөө хүчээр нэгтгэхээр 1950 оны 6 дугаар сард дайн дэгдээжээ. Энэ дайн 3 жил гаруй үргэлжилсэн ч Солонгосыг хуваасан шугам ямар байсан түүгээрээ үлдсэн юм.

Солонгосын хойгийг чөлөөлөгч бөгөөд “ивээгч” улсуудын нэг болох ЗХУ Солонгосын дайны тухай мэдээ материалыг нууцалж байсныг Оросын Холбооны Улс (ОХУ) задалж эхэлсэн билээ. Солонгосын дайнд оролцсон орнуудын архивын мэдээ материал ил болж байгаа ч гол баримтууд нууц хэвээр байгаа нь дайнд оролцогчдын нэг тал одоог хүртэл энх тайвны гэрээг

албан ёсоор үзэглээгүйтэй холбоотой гэж тайлбарлах нь бий.

ОХУ-ын Батлан Хамгаалах Яамны харьяа Үндэсний телевизийн “Звезда” компани 2021 оны намрын дунд сараас эхлэн Война миров буюу үгчлэн орчуулбал Дэлхий ертөнцийн дайн гэсэн нэр дор янз бүрийн дайны тухай баримтат кино нэвтрүүлгийг нийтэд үзүүлэх болсон юм. Ингэхдээ нэвтрүүлгийг зурагтаар төдийгүй Звездагийн цахим сангаас интернет ашиглан нөхөж үзэх боломжийг үзэгчдэдээ олгожээ.

Энэхүү судалгаа нь ОХУ-ын төрийн зүгээс Солонгосын хуваагдлын асуудлыг Украин-Орос, Израйл-Палестины дайн өрнөж байгаа ээдрээтэй энэ үед хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд тайлбарлахдаа энэ хуваагдлын тухай түүх баримтаас юуг яагаад онцлов, түүгээрээ юу өгүүлэв? гэсэн асуултад хариу өгөхийг зорьсон юм.

Дэлхийн 2 дугаар дайны шувтаргаар Японы колоничлолоос Солонгосыг чөлөөлж, “ивээл хамгаалалтдаа” багтааж байсан их гүрнүүдийн нэг нь дайтагч, нөгөө нь дайны дам оролцогч болон хоорондоо тэрсэлдэж, улс түмний энх тайвныг бусниулж байгаа өнөө үед Солонгосын хойгийн асуудлыг ОХУ хэрхэн тайлбарлаж буйг шинжилж дүгнээд, ямар сургамж авч болохыг таниулж байгаад энэхүү өгүүллийн ач холбогдол оршино.

Арга зүй

Макс Веберийн тодорхойлсноор, “Текстээс үнэ цэнтэй дүгнэлт хийхийн тулд цогц горимуудыг ашигладаг судалгааны аргыг агуулга шинжилгээний арга гэдэг. Ийм дүгнэлт нь текстийг илгээгч, тухайн текст, эсвэл текстийн уншигчдын тухай байдаг” (Bauer, 2000:133). Эдгээрийг цогцоор нь эс бол дан дангаар нь судалж болно. Манай судалгааны хувьд


Текстийг илгээгч нь: ОХУ-ын Батлан Хамгаалах Яам

Текст нь: Солонгосын хойгийн хуваагдал байв.

Хэрэглэгчид нь оросууд, орос хэлтнүүд байж болох ч телевиз үзэлт ба үзэгчдийн талаарх статистик мэдээллийг шинжилж дүгнэх боломж байгаагүй. Оросын үзэгчдийн талаарх мэдээллийг 2023 оны 10 дугаар сард ОХУ-д явагдсан Мэдээллийн технологи болон мэдээлэл теле-харилцааны сүлжээг хэрэглэгчдийн талаарх түүвэр судалгаанаас ашиглах гэсэн боловч түүнийг нууцалсан байлаа. Манай улсын хувьд Харилцаа холбооны зохицуулах хорооноос болон Махима Медиа ХХК-аас гаргадаг холбогдох тайлан мэдээнд “Звезда” сувгийг хамруулдаггүй.

Энэхүү судалгаанд Война миров-ын гарааны өдөр болох 2021 оны 10 дугаар сарын 14-өөс эхлэн

2024 оны 5 дугаар сарын 25-ны өдөр хүртэлх хугацаанд цацагдсан кино нэвтрүүлгүүдээс 1950-аад оны Солонгосын асуудлыг хөндсөн бүх нэвтрүүлгийг хамруулж, тэдгээрийг баримтын судалгааны аргаар шинжилж дүгнэхийг зорилоо. Ийм баримтат нэвтрүүлэг нийтдээ хоёр байсан ба энэ нэвтрүүлгүүдийн агуулгыг семантик аргаар шинжилсэн. Өөрөөр хэлбэл, зорилтот түүврийн аргаар сонгогдсон хоёр нэвтрүүлгийн баримт материалыг задлан ангилж, нэгтгэн шинжлэх замаар тэдгээрийн ил ба далд утгыг тайлсан юм.



“Звезда”

“Звезда” нь 2015 оны 5 дугаар сарын 18 - д улсдаа албан ёсоор бүртгэгдсэн ОХУ-ын Батлан Хамгаалах Яамны буюу төрийн мэдэлд байдаг, Москвад төвтэй Үндэсний телевизийн компани юм. Звезда гэдэг нь од гэсэн утгатай орос үг. Звезда сувгийн таних тэмдэг болох улаан хүрээтэй цагаан таван хошуу нь тэнгэрийн од гэхээсээ Кремлийн “од”, цагаан улаан армийн

болон баатрын таван хошууны бэлэг тэмдгийг илүүтэй санагдуулна.

“Звезда” компани нь Оросын Холбооны нутагт болон гадаадад орос хэлээр нэвтрүүлгээ цацдаг. Түүнийг Украины засгийн газар 2021 оны 5 дугаар сарын 21-д хориглосон бол Оросын зэвсэгт хүчин Украин руу довтолсонтой холбогдуулан 2022 онд Канадын засгийн газар, 2023 онд Европын холбооны улсууд бас хориг тавьжээ. Эдүгээ барууны орнуудад “барууны эсрэг” сурталчлагч гэдгээрээ нэрд гараад байгаа. Нутагтаа бол Звезда нь “Эх оронч” гэсэн тодотголтой зурагтын суваг юм.

Зурагтын Звезда сувгийг Монгол улсад ямар нэг хаалт, хяналтгүй үздэг. “Звезда” компани 2021 оны 10 дугаар сарын 14-ээс эхлэн Война миров гэсэн түүхч судлаачдын тайлбар бүхий дайны тухай баримтат киног тавьж эхэлснээс хойш өнөөдрийг хүртэл нийт 104 баримтат кино нэвтрүүлэг хийжээ. Эдгээрийн бүтцийг харвал, 2021–22 онд тавигдсан 46 баримтат кино нэвтрүүлгийн 1/4-ээс илүүд нь ЗХУ, Фашистын Германтай тулалдсан түүхийг, 10 гаруй хувьд нь Европын тухайлсан зарим улсуудын дайн самуунтай холбоотой сэдвийг хөндсөн байдаг. Япон, АНУ-тай холбоотой сэдвээр тус бүр хоёр, Солонгосын хойгийн асуудалтай холбоотой нэг нэвтрүүлэг цацагдсан байна.

2023 оны 40 цувралын тал нь Дэлхийн 2 дугаар дайнд ЗХУ-ын

оройлох үүрэгтэй оролцсон тухай, тэр дундаа Украины төлөөх тулалдааны тухай нэвтрүүлгүүд байв. Мөн Украин, Румын, Польш зэрэг улсын урвалтын тухай баримтат кинонуудыг илүү олноор тавьжээ. 2023 оны нэвтрүүлгүүд ханилж яваад “урвасан” гэх европыхны талаарх урьд өмнө дэлгэгдээгүй баримтуудыг нийтийн хүртээл болгосноороо онцлог байлаа.

2024 он эхэлснээс хойш 5 сарын хугацаанд 18 нэвтрүүлэг бэлтгэж үзэгчдэдээ хүргэжээ. Тэдгээрийн 1/3 нь Америк маягийн геноцид, Америк маягийн төрийн эргэлт ба Чаушескуд зориулсан өнгөт хувьсгал гэх зэрэг АНУ-ын эрх баригчдын бодлогыг шүүмжилж буруутгасан нэвтрүүлгүүд байв. Үүний нэг нь 2024 оны 2 дугаар сард гарсан “38 дугаар шугам” ажиллагаа ба Вашингтон Солонгосыг хэрхэн хуваасан тухай баримтат кино нэвтрүүлэг юм.

Нэгтгэн үзвэл, Война миров нэвтрүүлгүүд эхэндээ ЗХУ-ын ард түмний эх оронч, баатарлаг түүхийг илүүтэй тодотгож байсан бол дараа нь социалист ертөнцөд ах дүү гэгдэж явсан Европын зарим улсын урвалтыг болон фашизмын эсрэг холбоотнуудын гэмт хэргийг илчилсэн, эцэст нь аливаа улс үндэстний хагаралд, тэр дундаа өнгөрсөн зууны Солонгосын хойгийн хуваагдал, өнөө үеийн Украин Оросын дайнд АНУ-ын урт гар шургалсныг буруутгасан шинжтэй байв.

Дэлхийн Банкны статистик

мэдээгээр 2022 онд ОХУ-ын хүн амын 90 хувь нь интернет ашиглаж байжээ (World Bank, 2022). Зурагтын суваг дээгүүр эрэмбэлэгдэхэд нэг ангит кино 70 гаруй хувийн нөлөө үзүүлдэг (Максима Медиа, 2020:29) ба киног бүх насныхан үздэг. Война миров баримтат төрлөөрөө Звездагийн эрэмбийг хэр дээшлүүлснийг, хэр олон үзэгчтэйг хэлэх боломжгүй ч, орос хөвгүүдийн эцэг эхэд өнгөрсөн дайн байлдааны түүхийг сануулах, тайлбарлах, үзэгчдийн эх оронч сэтгэлгээ, дайны ялалтад итгэх итгэлийг нэмэгдүүлэх зорилготой гэдгийг харж болохоор байв. Гэхдээ энэ судалгааны нэгж нь нэвтрүүлгийн үзэгч биш тухайн нэвтрүүлэг билээ.

“Звезда” Солонгосын хойгийн хуваагдлын тухай

ОХУ-ын “Звезда” компаниас Война миров гаргаснаас хойш 2 жил 7 сар гаруй хугацаанд Солонгосын тухай 40 орчим минутын хоёр баримтат кино нэвтрүүлэг хийжээ. Эдгээр нь

1. 2022 оны 9 дүгээр сарын 24-ний Корейский рубеж. Битва интересов. *(Солонгосыг тойрсон ашиг сонирхлын тулаан)*
2. 2024 оны 2 дугаар сарын 14 ны Операция “38 параллель” Как Вашингтон разделил Корею (“38 дугаар шугам” ажиллагаа ба Вашингтон Солонгосыг хэрхэн

хуваасан тухай)

Дээрх хоёр нэвтрүүлэг нь бүхэлдээ Солонгосын хойгийн хуваагдал ба түүнийг тойрсон баримтат түүхийг хүүрнэдэг. Үүний зэрэгцээ Солонгосыг нэгтгэхийн төлөө солонгосчуудын тэмцлийг ашиглан АНУ, ЗХУ-ыг дайнд уриалан дуудсан тухай өгүүлдэг. Мөн аливаа өдөөн хатгалт, хагарал хуваагдлын эх үүсвэр нь АНУ-аас улбаатай гэсэн санааг нэвтрүүлдэг. Тиймдээ Солонгосын хойгийн талаарх анхны нэвтрүүлгээ Солонгост шууд холбоотой асуудлаар биш, харин 1950 оны 10 дугаар сарын 8-д Америкийн F-80 гэсэн 2 сөнөөгч онгоц Владивостокийн талаас наашилсаар Приморийн хязгаар дахь Зөвлөлтийн техникийг галласан нь АНУ-ын өдөөн хатгалт байв уу, ЗХУ-ыг Солонгосын дайнд татан оролцуулах гэсэн тэдний оролдлого байв уу? гэсэн асуулт бүхий кино зургаар эхлүүлжээ.

Солонгосын хойгийн хуваагдал Америкаас эхтэй гэдгийг бататгахын тулд Война миров-ын дээрх 2 нэвтрүүлэгт хэд хэдэн баримт материал оруулжээ. Үүнд:

1945 оны 2 дугаар сард Ялтад Гитлерийн эсрэг эвслийн орнуудын тэргүүнүүд уулзаж Японы эзэнт гүрэнд харьяалагдах нутаг дэвсгэрийн тухай асуудлыг хэлэлцэх үеэр түүний колони Солонгосыг ивээлдээ авцгаах саналыг Рузвелт Сталинд тавьсан. Энэ нь 100 хувь америкийн талын санаачилга байв. (Москлагийн Олон Улсын Харилцааны

Дээд

Сургуулийн багш К.Водопьяновын



тайлбар ярианы хэсгээс2)

- 1945 оны 8 дугаар 15-д ЗХУ-ын Улаан арми Японы Квантуны армийг бут цохиж, Солонгосын хойгийг 38 дугаар шугам хүртэл чөлөөлсний дараа Хөдөлмөрчдийн ардын хороод Солонгос даяар байгуулагдаж, коммунистуудын үйл ажиллагаа идэвхэжсэн ч өмнөдөд америкчууд барууны радикалуудтай нийлж тэднийг



зэрлэгээр нухчин дарсан байна.

- 1945 оны 9 дүгээр сарын 8-д буюу Инчеоны эрэгт Америкийн цэргүүд буусан тэр өдөр 38 дугаар шугамын түүх-Солонгосын хуваагдал эхэлсэн.
- 1948 оны 4 сарын 3-д Чэжүдо

² 2022 оны 9 дүгээр сарын 24-ны *Корейский рубеж. Битва интересов. 7 мин: 24 сек*

арал дээр АНУ, НҮБ-аас зохион байгуулж буй ард түмний гэх сонгууль болон Солонгосыг хуваахыг эсэргүүцсэн босогчдыг америкчууд, Ли Сын Мань хагас дээрмийн бүлэгтэй нийлж



харгислан дарав.

- АНУ-ын Тагнуулын Төв Газраас нууцалж байгаад ил болгосон 1948 оны 1 дүгээр сарын 2-ы мэдээндээ: “Зөвлөлтийн ноёрхол дор Солонгос нэгдвэл АНУ-ын хувьд улс төрийн томоохон ялагдал болно”³ гэжээ.

Дээрх хоёр нэвтрүүлэг нь Оросын зурагтын сувгаар гарч байсан ижил төстэй баримтат кинонуудаас, жишээ нь 2016 оны “Война в Корее” буюу Солонгос дахь дайн гэсэн нэртэй нийт 204 минутын Стар Медиагийн кино цувралаас Америкийг буруутгасан өнгө аясаараа ялгарч байлаа.

ОХУ Война миров нэвтрүүлгээрээ Солонгосын хойгийн хуваагдлын

³ 2024 оны 2 дугаар сарын 14-ий *Операция “38 параллель” Как Вашингтон разделил Корею. 4 мин: 39 сек*

түүхийг 1945 оны 9 дүгээр сарын 8-д буюу Инчеоны эрэгт Америкийн цэргүүд буусан тэр өдөр эхэлсэн гэж онцолжээ. Эрх чөлөөт, тусгаар улс үндэстэн байх гэсэн солонгос түмний эрмэлзэлд нийцсэн тийм нэгдмэл Солонгосыг байгуулахыг ЗХУ зөвшөөрөхгүй, байнга эсэргүүцэж байсны улмаас цэргүүдээ оруулсан гэж Америкийн тал тайлбарладаг (National Archives: 5). Чухамдаа Солонгосын хойгийг талласан 38 дугаар шугам, түүнээс улбаалсан хурцадмал байдал ЗХУ ба АНУ-ыг холбоотон болгож, Солонгосыг нэгтгэхийн төлөөх бодит тэмцэл тэднийг талцуулсныг нэвтрүүлгийн бусад материалаас харж болно. Жишээ нь:

- Дээр тэмдэглэгдсэн 1945 оны 9 дүгээр сарын 8-ы өдрөөс хорь гаруй хоногийн өмнө ЗХУ-ын Улаан арми умард Солонгосыг 38 дугаар шугам хүртэл чөлөөлөөд “зогссон”.
- 1945 оны 12 дугаар сарын дундуур хуралдсан Их Британи, АНУ, ЗХУ-ын Гадаад явдлын сайд нарын Москвагийн бага хурлаар Солонгост үүссэн хурцадмал байдлыг хэлэлцээд
 1. Нэгдсэн Солонгосын түр засгийн газрыг байгуулах
 2. Түр засгийн газрыг дэмжих Зөвлөлт-Америкийн хамтарсан комиссыг байгуулах

3. “Холбоотнуудын4 ивээл” –ийн

⁴ АНУ, ЗХУ, ИХ Британи ба Хятад.

5 хүртэлх жилийн дэглэм тогтоохоор болсон

- Америк, Зөвлөлтийн ивээгчид Солонгосын хойгт тогтоосон нөлөөллөө алдахгүйн тулд сэргэлцөж, Солонгосын дайнд АНУ хүч түрж тулалдсан, ЗХУ дайны сүүлийн эгзэгтэй шатанд туршлагатай нисэгчдээ Америкийн нисэх хүчний эсрэг агаарын тулаанд оруулж байлдсан, дайны төгсгөлд Солонгосыг хуваасан шугам ямар байсан түүгээрээ үлдсэн зэрэг болно.

Солонгосын дайны эхэнд умардын тал өмнөд нутаг руу эрчтэй давшилсан бол АНУ-ын зэвсэгт хүчин дайнд оролцсоноор өмнөдийнхөн умард руу довтолж, тэднийг хойд солонгосчууд Хятадын сая орчим цэрэгтэй хавсран шахан гаргажээ. Дайны сүүлийн шатанд ЗХУ хойд Солонгос руу нисэх хүчнээ нууцаар оруулсан байна. Тооны хувьд илт дутуу ч байлдааны их туршлага, ур чадварынхаа давуугаар оросын нисэгчид америкийн талд ихээхэн хохирол учруулжээ.

Үүнээс үзвэл Солонгосын хойгийн хуваагдалд Америк, Зөвлөлтийн аль алиных нь гар хөл оролцжээ. АНУ-ын Үндэсний Архиваас дэлгэсэн Тагнуулын төв агентлагийн 1947 оны 11 дүгээр сарын 18-ы баримтад: “ЗХУ бүх Солонгосыг дагуул болгож авах санаатай нь Солонгос дахь Зөвлөлтийн тактикаас ил тод харагдаж байна” (Central Intelligence Agency, 1947:1)

гэсэн байдаг. Хэдийгээр Солонгосын газар нутаг, хүн амыг харьцангуй бага, сонирхол татахуйц бус гэж үзэж байсан ч капиталист, коммунист гүрнүүдийн аль аль нь өөрийн гэсэн ашиг сонирхолтой байсныг архивын баримт бичиг (National Archives: 3) илтгэдэг.

Война миров эртний түүхт улс үндэстний хуваагдлыг эсэргүүцэхдээ аль нэг талыг дэмжиж байгаагаа илэрхийлээгүй байна. Судлаач миний зүгээс БНАСАУ-ын эрх баригчид батлан хамгаалах хүчээ зузаатгаж, орчин үеийн зэвсэг техникээр хөөцөлдөж, сүр хүчийг үзүүлэх болсныг Солонгосын дайнд цэргийн техник хэрэгслээр сул дорой байсан, түүнээс их хохирол, сургамж авсан, дайны төгсгөлд байгуулсан энхийн гэрээг нөгөө тал гүйцэд үзэглээгүй, коммунизмын өлгий-ЗХУ задран унасан зэрэгтэй холбоотой гэж үзсэн юм.

“Звезда”, ЗХУ-ыг Солонгосын дайнд татан оруулах санаархал АНУ-д байсныг Солонгосыг тойрсон ашиг сонирхлын тулаан нэвтрүүлэгт дурдсан бол ОХУ-ыг Украинд довтлуулж, дэлхийн орнуудыг Оросын эсрэг босгох нь мөн л Америкийн санаа мөн гэж хоёр дахь нэвтрүүлгийнхээ эцэст тэмдэглэсэн байна. Хагалан бутаргагчийг мэдсээр байгаад түүнд автсан нь Оросын тал ч хянуур хандаагүй гэсэн санаа бас ойлгогддог.

Солонгосын аль талаас дайн эхэлсэн талаар Война миров нэвтрүүлэг “Энэ нь одоог хүртэл маргаан

дагуулсаар байгаа” гэж тэмдэглэжээ. 1950 оны 4 дүгээр сарын 8-д Ким Ир Сен Гадаад явдлын Яамны сайдын хамт Москвад нууцаар айлчлахдаа өмнөд Солонгос руу довтлох төлөвлөгөөг авч ирсэн гэдэг. Түүний айлчлалыг харуулсан кино зургийг Война миров нэвтрүүлэг үзүүлэхийн зэрэгцээ, Америкийн цэргийн зөвлөхүүдийн тэргүүн генерал В. Робертс өмнөд Солонгосын удирдлагад хандан “БНАСАУ руу халдахад бүрэн бэлэн. Олон нийт л харин Ким Ир Сенийг дайн эхэлсэн гэдэгт итгэхэд бэлэн байх ёстой” гэсэн үгийг хавсаргажээ.

Солонгосын дайн хаанаас эхтэй тухай цэргийн түүхч судлаачдын логик гаргалгаанууд бий боловч баримт нотолгоо хангалтгүйн улмаас энэ асуудал маргаантай хэвээр байгааг монгол хэл дээр орчуулагдсан дорвитой ганц бүтээл – Б.Камингсын “Солонгосын дайн” (2017) номд ч тэмдэглэжээ. Үүнийг дурдахын учир нь социалист нийгэм нурснаас хойш манайд дам сурвалжийг ашиглан өмнөх түүхээ “тонгорч” бичих нь ихэссэн ба энэ байдал даамжирвал өнөө үеийн түүх бичлэгүүд нэг талыг дулдуйдсан коммунизмын үеийн түүхээс өөрцгүй болно гэж сэрэмжилснийх буюу.

Ноттой баримт шаарддагаараа түүх шүүх хоёр адилхан.

Дүгнэлт

2021 оны намар гараагаа эхэлсэн ОХУ-ын Батлан Хамгаалах Яамны харьяа Үндэсний телевизийн Звезда компанийн Солонгосын хойгийн хуваагдлыг хөндсөн Война миров баримтат кино нэвтрүүлгүүд хойд, өмнөд Солонгосын аль ч талыг үл баримтлан энэ асуудалтай холбогдох түүхийг эрдэмтэн судлаачдын оролцоотой тайлбарлажээ. Тэд 1945 оны 9 дүгээр сарын 8-д буюу Инчеоны эрэгт Америкийн цэргүүд буусан тэр өдрөөс Солонгосын хойгийн хуваагдлын түүх эхэлсэн гэж онцолсон байна. Хуваах санаачилгыг ч мөн Америкийн талаас тавьсныг тэмдэглэжээ. Үүгээр зогсохгүй аливаа өдөөн хатгалт, хагарал хуваагдлын эх нь АНУ-аас улбаатай гэсэн санааг Солонгосын тухай болон өөр бусад нэвтрүүлгээрээ хүргэхийг зорьжээ. Орос-Украины дайн сунжрахын хэрээр энэ хандлага улам ил болж 2024 оны эхний 5 сарын хугацаанд явуулсан Америкийг буруутгасан баримтат нэвтрүүлгийн тоо 2021-22 оныхтой харьцуулахад 3 дахин ихэссэн байв.

Тэгвэл 오빠 (ubbā) кинонд ямар шилжсэн утгаар илэрч байгааг “별에서 온 그대 (Тэнгэрээс буусан чи) олон ангит киноны хэсгээс авч үзье.

유세미: 오빠 아직도 그 사진 수사해? (чиндам)

Юү Сэми: Ах аа, танд тэр хэрэг сонин хэвээрээ л байна уу? (төрсөн ах дүү хоёр)

한유라: 나 아는 사람들, 오빠 아는 사람들, 최다 온 거 같은데... (연인)

Хан Юра: Миний таньдаг хүмүүс, ах таны таньдаг хүмүүс бүгд... (үерхдэг хосууд)

천송이: 오빠 어떻게 알았어요? (친구의 친형제)

Чон Суни: Ах аа та яаж мэдсэн юм бэ? (найзынх нь ах)

썸녀: 오빠들, 안 노세요? (초면)

Залуу охин: Ах нар аа, хамт хөгжилдөхгүй юу? (анх удаа уулзаж байгаа хүн)

Дээрх өгүүлбэрүүдэд 오빠 (ubbā) нь эцэг эх нэгтэй төрсөн ахыг, үерхдэг залууг, найзын төрсөн ахыг, тэр бүү хэл анх удаа уулзаж байгаа хүнийг ч мөн зааж байна.

Мөн телевизийн нэвтрүүлэгт ямар утгаар орж байгааг “슈퍼맨이 돌아왔다 (супер аав)” хэмээх нэвтрүүлгийн хэсгээс авч үзье.

박주리: 오빠 왜 그렇게 불안해? (선후배)

Паг Жүри: Ах аа, та яагаад ингээд сандраад байгаа юм бэ? (дээд ангийн оюутан)

Мөн баримтат нэвтрүүлэгт 오빠 (ubbā) ямар утгаар хэрэглэгдэж байгааг KBS сувгийн “부부 클리닉 (эхнэр нөхрийн харилцаа)” нэвтрүүлгийн 2017 оны дугаарын хэсгээс авч үзье.

난 우리 오빠를 만나 이렇게 결혼하는 걸 천만 다행이라고 생각해... 그쵸 오빠?

Би ахтайгаа уулзаад одоо ингээд гэр бүл болсноо үнэхээр азтай явдал гэж боддог.. Тийм биз дээ? Ах аа? (эхнэр нөхөр)

Дээрх нэвтрүүлгийн эхийг ажиглан харвал, 오빠 (ubbā) нэвтрүүлгийн зочин эмэгтэйн энгийн нэг “янаг амраг”, “хайртай хүн” бус албан ёсоор гэрлэсэн “нөхөр”, “хань” хэмээх утгаар илэрч байна. Үүнээс харвал 2000-аад оны сүүл үеэс эхлэн солонгосын нийгэмд

гэр бүлийн харилцаанд эхнэр нь нөхрөө дуудаж, нэрлэхдээ **오빠** (ubbā) –г өргөн ашигладаг болсныг мэдэж болж байна.

2016 онд гаргасан БНСУ-ын Эмэгтэйчүүд, Гэр бүлийн яамнаас авсан судалгаагаар солонгосын гэр бүл ялангуяа залуу гэр бүлийн 60 –70 хувьд эхнэр нь нөхрөөсөө насаар дүү байх тохиолдолд гэрлэхээсээ өмнө хийгээд дараа нь нөхрөө дуудаж, нэрлэхдээ **오빠** (ubbā)–г ашигладаг гэж хариулжээ. Үүний шалтгааныг асуусан асуултад “дотно санагддаг”, “дуудахад амар байдаг”, “нөхөр нь дуртай” гэх мэт хариулт давамгайлж байснаас харвал солонгосын нийгэмд **오빠** (ubbā) нь үндсэн утга санаатай нь харьцуулахад харьцангуй өргөн цар хүрээтэй нийгмийн нэршил болон хэрэглэгдэж байгааг мэдэж болж байна. Мөн **오빠** (ubbā)–г ийнхүү нийгмийн өргөн хүрээтэй нэршил болоход зөвхөн охид, эмэгтэйчүүдийн дан ганц оролцоо дутагдалтай болохыг мөн дээрх “нөхөр нь дуртай байдаг” асуулгын хариултаас харагдаж байна.

Эцэст нь **오빠** (ubbā) бусад үгтэй нийлж хэрхэн шинэ утга илэрхийлэх болсныг зарим нэг жишээн дээр тайлбарлаж, түүний нийгмийн ямар хэл шинжлэлд ямар үүрэг гүйцэтгэж буйг тайлбарлахыг хичээе.

오빠 바보 (ubbā rabu):

бабога 될 정도로 친오빠나 연상의 남자 친구를 따르는 여동생이나 여자

친구를 이르는 말 (Төрсөн ах эсвэл насаар ахмад найз залуудаа тэнэг юм шиг дэндүү сайн хандах, маш дотно нөхөрлөдөг эмэгтэй дүү эсвэл охиныг дууддаг үг)

Энэ үг **팔바보** (dali rabu) буюу охиноосоо өөр хэнийг ч мэддэггүй, охиндоо дэндүү хайртай аавуудыг нэрлэдэг үгээс үүсэлтэй байж болзошгүй бөгөөд тухайн үгийн хэрэглээнээс үзэхэд, төрсөн ахыг заах утгаас илүү эмэгтэй хүний эрэгтэй хүнийг гэх “нэг талын хайр” эсвэл “хэт гүнзгий хайрлах” утгыг илэрхийлдэг бололтой.

교회 오빠 (kyuhe ubbā):

교회에 다니는 오빠 혹은 교회에 다니는 것 같은 이미지의 남성을 지칭한다. 요즘은 전자의 의미보다 후자의 의미로 많이 사용된다

Энэ үг сүмд явдаг ах гэсэн утгатай бөгөөд анх энэ үгийн утга нь анхны утгаар буюу сүм, хийдэд очиж мөргөл хийдэг насаар ахмад эрэгтэй хүнийг нэрлэдэг үг байсан бол орчин үед түүний утга өөрчлөгдөж “сүмд явдаг хүн шиг сайхан сэтгэлтэй, боловсон, гитар сайн тоглодог, цэвэрхэн хувцасладаг, өөдрөг үзэлтэй эр хүн буюу нэг үгээр хэлбэл охидын мөрөөдлийн залуу” хэмээх утга давамгайлах болжээ.

Дүгнэлт

Дэлхий дахины гадаад хэлний боловсролд харилцааны ур чадварыг

юу юунаас ч илүүд үзэх болсон. Энэ нь гадаад хэлийг шинжлэх ухааны байр сууринаас гэхээс илүүтэй хүмүүс хоорондын харилцааны нэг чухал хэрэгсэл болгож үзэх болсонтой нягт холбоотой. Тэгэхлээр гадаад хэлийг сайн эзэмших гэдэг нь хэр олон үг мэддэг, хэдэн төрлийн хэл зүйг ашиглаж чаддагаас бус аливаа нөхцөлд харилцагч хүнтэйгээ хэлэхүйн үйлдлийг хэрхэн зөв хийх эсэхээс хамаардаг болжээ.

Тиймээс ч нийгмийн ийм хөгжлийн үрээр тодорхой хэмжээнд хувьсан өөрчлөгдөж буй шинэ үг хэллэг буюу неологизмийн нэг төрөл болох шинэ утга агуулах хуучин үгийн анализийг хийх гэж оролдлоо. Судалгаанаас харахад солонгос хэлний **오빠** (ubbā)-д үндсэн “ах” гэх ураг төрлийн дуудах нэрээс гадна “нөхөр, хань”, “хайртай хүн”, “янаг амраг”, “краш залуу”, “мөрөөдлийн эр хүн” гэх мэт олон төрлийн нийгмийн харилцааны неологизм утга илэрч байна. Энэ нь Недарландын эрдэмтэн М.Янсений тодорхойлсон неологизмын таван аргын нэг болох diachronic definition буюу үе шат, цаг хугацааны онцлогийн дагуу тухайн хэлэнд илэрч байгаагүй ч одоогийн хэлэнд илэрдэг хэлний бус буюу гадаад хүчин зүйл тухайлбал, нийгэм, эдийн засаг, техник технологи зэргээс ихээхэн хамааралтай болж болох талтай.

Солонгос хэл соёлыг сурч, судалж буй оюутан залуус өөрийн

хэлний харилцааны ур чадварыг нэмэгдүүлэхэд орчин цагийн солонгос хэлний үг хэллэгийн утгын хувьсал, хэрэглээний өөрчлөлтийг ч мөн адил мэдэх, мэдрэх шаардлага зайлшгүй тулгарч байна. Дээрх жишээ баримтад үндэслэн солонгос хэлэнд **오빠** (ubbā) хэмээх нэг үг ямар өргөн цар хүрээтэй утга санааг өөртөө агуулж байгааг олж мэдлээ. Цаашлаад солонгос хэл шинжлэлийн онол, арга зүй, мэдлэгийг бодит хэрэглээтэй холбоотой асуудлыг шийдвэрлэхэд ашиглах, хэлний неологизм утгыг орчуулгын хичээлд оновчтой ашиглах, ийм төрлийн судалгааны ажлыг гүнзгийрүүлэн хийх нь зүйтэй.

Ном зүй

1. Бадамдорж, Д. (2001). Монгол хэлний утга судлал, Уб.,
2. Гэрэлмаа, Г. (2012). Хэрэглээний хэл шинжлэл, Уб.,
3. Өлзийнаран, А., Наранчимэг, Б. (2018). Монгол хэлэнд илэрч буй неологизм ба түүний орчуулгын асуудалд, Орчуулга зүй, ЭШБ, №06 (481),
4. Хэрэглээний хэл шинжлэл. (2016). ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, №7. Уб.,
5. Равдан, Э. (2009). Хэл шинжлэлийн утга зүй, Уб.,
6. БНСУ-ын Эх хэлний үндэсний хүрээлэн, Солонгос хэлний их тайлбар толь,

7. 강현자. 방송언어의 호칭어 사용 양상 연구, 언어와 문화 2, 201-218., 2017
8. 강희숙. 호칭어 사용에 대한 사회언어학적 분석, 10-1 한국사회언어학회., 2002
9. 김동식. 오빠의 의미론을 위하여, 월간문화예술. 한국문화예술위원회., 2004
10. 정달영. 한국어의 친족 호칭어와 지칭어 연구, 한민족문화연구, 197-211., 2010

Цахим эх сурвалж: www.korean.go.kr

Солонгос хэл суралцагчдын мэргэжил сонголтод нөлөөлж буй хүчин зүйлсийг судлах нь¹

Б.Туяа²

tuya.b@ulaanbaatar.edu.mn

Б.Энхмаа³

Absract

대학에 진학하려는 학생들에게 어떤 대학, 어떤 전공을 선택할지는 대학생 생활뿐만 아니라 장래의 진로 결정과 인생 계획에도 영향을 미치는 중요한 문제이다. 최근 들어 감소세를 보이고 있긴 하지만, 고졸자의 75.4%가 대학에 진학하고 있는 몽골 같은 경우는 대학 진학이 인생의 매우 중요한 전환점이 되고 있음을 알 수 있다. 그러나 고등학생들은 실제 정보 없이 대학에 입학하고(D. Jargalmaa 2017; B. Bayarzul 2021), 일부 학생들은 자신이 선택한 직업에 대해 혼란스러워하며(Nyamdorj, 2015), 자신이 공부한 직업에 종사하는 사람들의 95%가 직업을 잘못 선택했다(N. Tsogzolmaa 2015)는 선행 연구 결과가 있다. 부모가 교사였다거나, 그런 직업이 수요가 많다는 이유 때문에 아이의 적성이나 능력에 맞는지를 알지 못한 채 학생에게 어떠한 전공을 선택하도록 강요하는 경우도 있다.

선행 연구는 고등학교 3학년 학생들을 대상으로 한 연구가 대다수이어서 본 연구에서는 한국어 학습자인 재학생을 중심으로 해서 그들의 전공 선택에 미치는 요인을 파악하였다. 연구 결과, 한국학, 한국어교사, 한국어통-번역 학과 학생 중 거의 절반(49.7%)이 취미와 관심을 바탕으로 한국어를 선택하고 해당 직업에 종사하고 싶어하는 것은 긍정적인 현상이다. 그러나 전공에 따라서 예를 들어, 한국학, 한국어 교사 등의 전공은 가족의 강요가 차지하는 비율(30%)이 적지 않다. 그리고 학생들이 무엇보다 “한국에서 공부할 가능성이 높다”는 이유로 한국어를 선택하여 공부하고 있으며, 그들의 최종 목표는 한국에서 공부하고 한국에서 생활하는 것이다. 한편으로는 한국의 외국인 유학생 정책이 이에 영향을 미치는 것으로 추측할 수 있으며, 이 문제에 대한 추가 연구를 통해 흥미로운 결과가 나올 수 있기를 기대한다.

주제어: 한국어 학습자, 전공 선택, 영향 요인

¹ This work was supported by the Core University Program for Korean Studies of Ministry of Education of Republic of Korea and the Korean Studies Promotion Service at the Academy of Korean Studies (AKS-2022-OLU-2250006)

² ОУУБИС-ийн солонгос хэлний боловсролын тэнхимийн профессор, доктор

³ ОУУБИС-ийн Солонгос хэл соёлын тэнхимийн төгсөгч

1. Удиртгал

Их, дээд сургуульд суралцах хүсэлтэй оюутнуудын хувьд аль их сургууль, ямар мэргэжлийг сонгох вэ гэдэг нь оюутны амьдралд төдийгүй ирээдүйн карьераа шийдэх, амьдралаа төлөвлөхөд чухал нөлөө үзүүлэх асуудал юм. Хэдийгээр сүүлийн жилүүдэд ЕБС төгсөгчдийн тоо багассан ч их, дээд сургуульд элсэгчдийн түвшин 75.4 хувьтай⁴ байгаа нь их, дээд сургуульд элсэн суралцах нь амьдралын маш чухал шийдвэрлэх мөч болохыг харуулж байна.

Гэтэл ЕБС-ийн сурагчид бодитой мэдээлэлгүйгээр их дээд сургуульд элсэн суралцаж (Д.Жаргалмаа 2017, Б.Баярзул 2021), зарим оюутнууд сонгосон мэргэжлийнхээ талаар эргэлзэж (Нямдорж, 2015), суралцсан мэргэжлээрээ ажиллаж байгаа хүмүүсийн 95% нь мэргэжлээ буруу сонгосон байна. Энэ нь хувь хүн, айл өрхийн болоод албан байгууллага, салбар цаашлаад улсын хөгжилд сөрөг нөлөөтэй болох нь тодорхой юм (Н.Цогзолмаа 2015). Үүнд нөлөөлж байгаа хүчин зүйлсийн нэг нь суралцагч ур чадвар гэхээсээ илүүтэйгээр ЭЕШ-ын оноогоор их, дээд сургууль, мэргэжлээ сонгох хандлага өндөр

байна. Их, дээд сургууль гэдэг хувь хүн нийгэмд хөл тавихаасаа өмнө өөрийн авьяас чадвараа хөгжүүлдэг газар байтал ЭЕШ-ын онооноос шалтгаалж сонголт хийснээр элсэн орсныхоо дараа суралцах сонирхолгүй болж, мэргэжлээ сольж, эсвэл сэтгэл ханамжгүй, хүсэл тэмүүлэлгүй суралцаж төгсөхөд хүрдэг. Мөн хүүхдийнхээ онцлог, ур чадварт тохирох эсэхийг анхаарахгүйгээр аав нь багш байсан юм чинь багш болчих, эсвэл ийм мэргэжил эрэлт хэрэгцээтэй гэх зэргээр нэг ёсны шахалтад орж сонголт хийх тохиолдол ч байдаг.

ЕБС төгсөгчид их сургуульд элсэх талаар, их сургуульд элсэхэд тухайн элсэх их, дээд сургуулийн нэр хүнд, сургалтын орчин, эцэг, эхийн нөлөө, ажлын байрны олдоц, зах зээлийн эрэлт хэрэгцээ хэрхэн нөлөөлж байгаа талаар судалгаанууд хийгдсэн байна. Тухайн мэргэжлээр элсэн суралцаж буй оюутнуудаас хүссэн их сургууль, мэргэжлээр суралцахад нь ямар хүчин зүйлс хэрхэн нөлөөлж, ямар хүчин зүйлийг хамгийн түрүүнд авч үзэхэд хүргэж байгааг судалсан судалгаа дутмаг байх шиг байна. Иймд бид энэхүү судалгаагаар солонгос хэл суралцагч оюутнуудын мэргэжил сонголтод “сургуулийн онцлог, мэргэжлийн онцлог, мэргэжлийн эрэлт хэрэгцээ, мэргэжлээрээ ажиллах боломж, мэргэжлээрээ ажиллах хүсэл, суралцагчийн зорилго, солонгос хэлийг сонгосон шалтгаан, бусдын нөлөө” гэх мэт хүчин зүйлс хэрхэн нөлөөлснийг

⁴ 2022~2023 оны хичээлийн жилд их, дээд сургуульд элсэгчдийн дотор тухайн жилд бүрэн дунд боловсрол эзэмшигчдийн эзлэх хувь 75.4 хувь болж, 2021~2022 оны хичээлийн жилийнхээс 7.2 нэгж хувиар буурсан байна (Үндэсний статистикийн хороо, 2022).

шинжлэхийг зорьж байна. Түүнчлэн дээрх хүчин зүйлсийн хооронд хамаарал байгаа эсэхийг судлахыг зорив. Зөвхөн нэгдүгээр курсийн оюутнуудаар зогсохгүй 2, 3, 4 курсийн оюутнуудын хувьд мэргэжил сонголтын ялгаа байгаа эсэхийг шинжлэв.

2. Сэдвийн судлагдсан байдал

2014 оноос хойших ахлах ангийн сурагчид болон оюутнуудын мэргэжил сонголтод нөлөөлж буй хүчин зүйлсийн талаарх судалгаанууд цөөнгүй байна.

Н.Цогзолмаа (2014) “Мэргэжил сонголтын чиг баримжааг судалсан нь” бүтээлдээ мэргэжил сонголтын талаар хийсэн хэдэн судалгааг танилцуулсан байгаа бөгөөд түүний танилцуулсан Ч.Нямдоржийн (2015) судалгааны дүн сурагчид ирээдүйн мэргэжлээ сонгохдоо мэргэжлийн онцлог давуу байдлыг харгалзан үзэхээс гадна их, дээд сургууль, урамшуулалт тэтгэлэг зэрэг нийгмийн хүчин зүйлсийг илүү анхаарснаас мэргэжлээ буруу сонгоход хүрч байна. Мөн сурагчдын мэргэжил сонголтод тухайн элсэх их, дээд сургуулийн нэр хүнд, сургалтын орчин, эцэг, эх, багш нарын нөлөө багагүй байгаа нь сурагчид сонирхолгүй мэргэжлээрээ суралцах нөхцөлийг бүрдүүлж байна гэж гаргажээ. Мөн Н.Цогзолмаа (2015) судлаач дээрх судалгаанд МУБИС, Багшийн сургуулийн 1-р курсийн 220 оюутнаас бага боловсролын багшийн мэргэжил сонголтын талаар хийсэн

судалгааны дүнг танилцуулсан байгаа бөгөөд тус судалгаанд хамрагсдын 25.5% нь МУБИС бол улсын сургууль тул сонгосон, 20% нь хэрэгцээтэй мэргэжил гэж үзсэн, 19.5% нь өөрөө сонгосон, 18.6% нь хуваарь таарсан, 14% нь эцэг эх, гэр бүл, хамаатан садан нөлөөлсөн, 2.3% нь тэтгэлэг авах боломжтой гэж үзжээ.

Б.Болормаа, Б.Оюунсүрэн, Ч.Алтангэрэл, Ч.Цолмон (2015) нарын судалгаанд ахлах ангийн сурагчдын 79.3% нь мэргэжлээ сонгосон байна. Эдгээр сурагчдын мэргэжил сонголтод эцэг эх, ах эгч, найз нөхөд, эмээ өвөө, багш, өөрийн сонирхол, зах зээлийн эрэлт хэрэгцээ зэрэг хүчин зүйлүүд нөлөөлсөн байгаа ба эдгээрээс хамгийн ихээр нөлөөлж байгаа нь өөрийн сонирхол, зах зээлийн эрэлт хэрэгцээ, эцэг эхийн нөлөө гэж үзжээ.

Б.Баярмагнай (2015) ЕБС-ийн төгсөх ангийн 719 сурагчдаас мэргэжил сонголтод нөлөөлж буй хүчин зүйлсийн талаарх судалгаа авсан ба судалгаанд хамрагсдын 40.5% нь гэр бүл, ах дүүс, 25.6% нь тухайн чиглэлийн байгууллага, 17% нь найз нөхөд, 10% багш, 6.9% нь бусад гэсэн үр дүн гарчээ. П.Бат-Эрдэнэ (2021) мөн адил ахлах ангийн сурагчдын мэргэжил сонголтод эцэг эхийн нөлөө их байгааг судалсан байна. Энэхүү судалгаанд “Таны хүрээллийн хүмүүсээс хэн нь таныг сонсож, таны сонгосон мэргэжлийн талаар ярилцаж зөвлөлддөг вэ” хэмээх асуултад судалгаанд хамрагсдын 59.3% нь аав

ээж, асран хамгаалагч, 35.9% нь найз нөхөд гэж хариулсан байна. Энэхүү судалгааны үр дүнгээс үзэхэд мэргэжил сонголтод эцэг эх, найз нөхдийн нөлөө их байгаа нь харагдаж байна.

Д.Жаргалмаа (2017) судлаач оюутны мэргэжил сонголтын шийдвэр гаргалтад нөлөөлөх хүчин зүйлсийн судалгааг нягтлан бодогч мэргэжлээр суралцагчдад голчлон хийсэн ба судалгааны үр дүнд ажлын байрны олдоц хамгийн их, үйл ажиллагаа явуулж буй байгууллага бүхэнд ажлын байр тогтмол байдаг гэх ойлголттой байгаа нь оюутнуудын мэргэжил сонголтод нөлөөлж байгаа тул мэргэжил сонгоход туслах чиг үүрэг бүхий ажлын хэсэг гарч, мэргэжлийн зөвлөгөө өгөх арга хэмжээ, мэргэжил сурталчлах өдөрлөгүүдэд тус ажлын хэсэг тухайн мэргэжлийн талаарх үнэн зөв бодитой мэдээллээр оюутнуудыг хангаж ажиллах шаардлагатай байна гэж үзжээ. Мөн Б.Баярзул (2021) ЕБС-ийн төгсөх ангийн сурагчдын хувьд мэргэжил сонголт, ажил мэргэжлийн чиг баримжааны талаарх мэдээлэл өнгөц, сонголт хийх хүрээ бага байгаа тул ажил мэргэжлүүд, ажлын байрны орчин нөхцөл, олдоц, ажилтанд тавигдах шаардлага зэргийн талаар бодитой, үнэн зөв мэдээллээр хангах ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна гэж үзжээ.

М.Дашбалжин (2022)-гийн сэтгэл судлалын мэргэжлээр суралцаж буй оюутнуудын мэргэжил сонголтод нөлөөлж буй хүчин зүйлсийн талаарх

судалгаанд мэргэжил сонголтоо эрт сонгосон оюутнуудын хувьд өөрсдийн хүсэл сонирхлоо эрт тодорхойлсон гэж үзэж болох ба өөрийн хүсэл сонирхлоо тодорхойлж чадаагүй оюутнууд нь эцэг эхийн зөвлөгөөг дагах, нийгэмд эрэлт хэрэгцээтэй мэргэжил гэх мэтчилэн мэргэжил сонголтоо хийж байна гэсэн дүгнэлтэд хүрсэн байна.

3. Судалгааны арга

Судалгаанд хамрагсдын ерөнхий мэдээллээс гадна өмнөх судалгааны ажлуудад үндэслэн солонгос хэл суралцагчдын мэргэжил сонголтод нөлөөлж буй хүчин зүйлийг “сургуулийн онцлог, мэргэжлийн давуу тал, мэргэжлийн эрэлт хэрэгцээ, мэргэжлээр ажиллах боломж, мэргэжлээрээ ажиллах хүсэл, бусдын нөлөө, солонгос хэл сонгосон шалтгаан, суралцагчийн зорилго” гэх мэт 8 хувьсагчаар тодорхойлсон. Судалгааны түүврийг сонгохдоо солонгос хэлний сургалттай их дээд сургуулиас төлөөлөх чадвар бүхий төрийн өмчит сургуулиас 2 сургууль (МУИС, ШУТИС), хувийн сургуулиас 2 сургууль (ХУИС, ОУУБИС)-ийг сонгон солонгос хэлний орчуулагч, солонгос судлал, солонгос хэлний багшийн ангийн нийт 161 оюутнаас судалгааны өгөгдлийг цуглуулж, SPSS программ ашиглан дүн шинжилгээ хийсэн болно.

Тус судалгаагаар солонгос хэл суралцагч оюутнуудын их, дээд сургуульд элсэн ороход

“сургуулийн онцлог, мэргэжлийн давуу тал, мэргэжлийн эрэлт хэрэгцээ, мэргэжлээрээ ажиллах боломж, мэргэжлээрээ ажиллах хүсэл, бусдын нөлөө, суралцагчийн зорилго, солонгос хэлийг сонгосон шалтгаан” гэх мэт хүчин зүйлсийн аль нь давамгайл нөлөөлж байгааг, мөн эдгээр хүчин зүйлс ба мэргэжлийн хооронд хамаарал байгаа эсэхийг тодорхойлохыг зорилго. Энэхүү зорилгод хүрэхийн тулд дараах асуултыг дэвшүүлж байна.

Солонгос хэл суралцагчдын мэргэжил сонголтод нөлөөлж буй хүчин зүйлс болон суралцагчдын сонгон суралцаж буй мэргэжил хооронд хамаарал байна уу?

Энэхүү асуултад хариулахын тулд эхлээд давтамжийн шинжилгээ ба хураангуй шинжилгээг хийв. Дараа нь дараах 9 таамаглалыг дэвшүүлж, бүлгүүдийн давтамжийн тархалтыг харьцуулах солбицлын шинжилгээ хийж, хувьсагч хооронд хамаарал байгаа эсэхийг Chi-Square test-ээр ач холбогдлын түвшнийг шалгав.

Нэгдүгээр таамаглал:

H_0 : Суралцагчийн суралцаж буй мэргэжил ба сургууль харилцан хамааралгүй.

H_1 : Суралцагчийн суралцаж буй мэргэжил ба сургууль харилцан хамааралтай.

Хоёрдугаар таамаглал:

H_0 : Суралцагчийн суралцаж буй мэргэжил ба курс харилцан хамааралгүй.

H_1 : Суралцагчийн суралцаж буй

мэргэжил ба курс харилцан хамааралтай.

Гуравдугаар таамаглал:

H_0 : Суралцагчийн суралцаж буй мэргэжил ба мэргэжлийн давуу тал харилцан хамааралгүй.

H_1 : Суралцагчийн суралцаж буй мэргэжил ба мэргэжлийн давуу тал харилцан хамааралтай.

Дөрөвдүгээр таамаглал:

H_0 : Суралцагчийн суралцаж буй мэргэжил ба сургуулийн онцлог харилцан хамааралгүй.

H_1 : Суралцагчийн суралцаж буй мэргэжил ба сургуулийн онцлог харилцан хамааралтай.

Тавдугаар таамаглал:

H_0 : Суралцагчийн суралцаж буй мэргэжил ба мэргэжлээрээ ажиллах хүсэл харилцан хамааралгүй.

H_1 : Суралцагчийн суралцаж буй мэргэжил ба мэргэжлээрээ ажиллах хүсэл харилцан хамааралтай.

Зургаадугаар таамаглал:

H_0 : Суралцагчийн суралцаж буй мэргэжил ба бусдын нөлөө харилцан хамааралгүй.

H_1 : Суралцагчийн суралцаж буй мэргэжил ба бусдын нөлөө харилцан хамааралтай.

Долоодугаар таамаглал:

H_0 : Суралцагчийн суралцаж буй мэргэжил ба солонгос хэл сонгосон шалтгаан харилцан хамааралгүй.

H_0I Суралцагчийн суралцаж буй мэргэжил ба солонгос хэл сонгосон шалтгаан харилцан хамааралтай.

Наймдугаар таамаглал:

H_0 : Суралцагчийн суралцаж буй мэргэжил ба суралцагчийн зорилго харилцан хамааралгүй.

H_1 : Суралцагчийн суралцаж буй мэргэжил ба суралцагчийн зорилго харилцан хамааралтай.

Есдүгээр таамаглал:

H_0 : Суралцагчийн солонгос хэл сонгосон шалтгаан ба цаашдын зорилго харилцан хамааралгүй.

H_1 : Суралцагчийн солонгос хэл сонгосон шалтгаан ба цаашдын зорилго харилцан хамааралтай.

4. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг дараах /ОУУБИС, МУИС, ХУИС, ШУТИС/ сургуулиудад солонгос хэлний орчуулагч, солонгос хэлний багш, солонгос судлал мэргэжлээр суралцаж буй 161 оюутнаас Google forms программ ашиглан судалгаа авсан бөгөөд SPSS программ ашиглан анализ хийв.

Судалгаанд хамрагсдын 86.3% нь эмэгтэй, 13.7% нь эрэгтэй байгаа бөгөөд 36.6% нь 17–20 насныхан, 51% нь 21–23 насныхан, 12.4% нь 24–өөс дээш насныхан байна. Судалгаанд оролцогчдын 63.4% нь “солонгос хэл орчуулга”, 22.4% нь “солонгос судлал”, 14.3% нь “солонгос хэлний багш” мэргэжлээр суралцдаг байна. Мөн тэдний 21.1% нь 1–р курс, 23.6% нь 2–р курс, 28.6% нь 3–р курс, 26.7% нь 4–р курсийн оюутнууд байна. Эдгээр оюутнуудын дийлэнх нь буюу 60.2% нь “одоохондоо ТОРИК–ийн оноогүй” байгаа ба 8.7% нь “ТОРИК–ийн 1~2” дугаар түвшинтэй, 22.4% нь “ТОРИК–ийн 3~4” дүгээр түвшинтэй, 8.7% нь

“ТОРИК–ийн 5~6” дугаар түвшинтэй байна.

Мэргэжил сонголтод сургуулийн онцлог хэрхэн нөлөөлсөн талаар сургуулийн нэр хүнд 26.1%, багшийн нэр хүнд 4.3%, өмчийн хэлбэр 6.2%, солонгос багш ихтэй 30.4%, тэтгэлэг авах боломж их 16.1%, сургалтын орчин 11.2%, төгсөгчдийн карьер 5.6% гэж үзжээ. Үүнээс үзэхэд “солонгос багш их” хэмээх хүчин зүйл бусад хүчин зүйлсээс давамгайлж байна. Харин мэргэжил сонголтод тухайн мэргэжлийн давуу тал хэрхэн нөлөөлсөн талаар нийт оюутнуудын 42.2% нь “солонгост суралцах боломж өндөр”, 17.4% нь “мэргэжлийн хүсэл сонирхол”, 10.6% нь “мэргэжлээрээ ажиллах боломж өндөр”, 9.9% нь “ахисан түвшинд суралцах боломж өндөр” гэж үзжээ. Судалгаанд хамрагсдын 14.9% нь өөрийн суралцаж буй мэргэжлийн нийгэм дэх эрэлт хэрэгцээг “маш өндөр”, 43.5% нь “өндөр”, 37.3% нь “дунд”, 3.7% нь “бага”, 0.6% нь “маш бага” гэж үнэлсэн байна. Судалгаанд оролцогчдын 37.9% нь төгсөөд мэргэжлээрээ ажиллах боломж “өндөр” гэж үзсэн бол 48.4% нь “дунд”, 7.5% нь “бага”, үлдсэн 6.2% нь сайн мэдэхгүй байна гэж үзжээ. Мөн судалгаанд оролцогчдын 70.8% нь сургуулиа төгсөөд мэргэжлээрээ ажиллахыг хүсэж байгаа бол 5.0% нь мэргэжлээрээ ажиллахыг хүсэхгүй, 24.2% нь мэргэжлээрээ ажиллах эсэхээ сайн мэдэхгүй байна.

Дэлхийн олон хэл дундаас яагаад зөвхөн солонгос хэлийг сонгон суралцах

болсон шалтгааныг асуусан асуултад 49.7% нь “хобби, сонирхлын үүднээс”, 19.9% нь “солонгос хэл хэрэглэгчдийн тоо ихсэж байгаа учраас”, 0.6% нь “солонгосын зан заншил болон соёлыг гүн гүнзгий судлахын тулд”, 10.6% нь “дуртай жүжигчдийнхээ тоглосон уран бүтээлүүдийг эх хэл дээр нь хадмалгүй үзэхийн тулд”, 14.9% нь “өгүүлбэрийн бүтэц нь монгол хэлтэй төстэй тул сурахад хялбар санагдсан учраас”, 4.3% нь “дуудлага нь зөөлөн учраас” гэж дүгнэжээ. Суралцагчдыг солонгос хэл сурахад нөлөөлсөн бусдын нөлөөнөөс 52.2% нь “солонгосын соёлын давлагаа”, 24.8% нь “солонгос компани эсвэл солонгостой холбоотой ажил”, 13.7% нь “амьдралын шаардлага”, 6.2% нь “гэр бүлийн шахалт”, 3.1% нь “найз нөхөд” гэж хариулжээ. Нийт

оролцогчдын талаас дээш хувь нь солонгосын соёлын давлагаагаар дамжуулан солонгос хэлийг хобби болон сонирхлынхоо дагуу сонгон суралцаж байгаа нь харагдаж байна.

Солонгос хэл сурч буй зорилгын 29.8% нь “солонгост ахисан түвшинд суралцах”, 27.3% нь “солонгост ажиллаж амьдрах”, мөн 27.3% нь “мэргэжлийн боловсон хүчин болох”, 11.2% нь “хэлний мэдлэгээ дээшлүүлэх”, 3.7% нь “диплом л авахын тулд”, 0.6% нь “монголд ахисан түвшинд суралцах” гэж гарчээ. Нийт судалгаанд оролцсон оюутнуудын ихэнх нь солонгос улсад ахисан түвшинд суралцах, тэнд ажиллаж амьдрах сонирхолтой болох нь харагдаж байна. Дээрх агуулгыг доорх хүснэгтэд харуулав

ангилал		давтамж ба хувь	ангилал		хувь
хүйс	эр	(22) 13.7%	нас	17-20	(59) 36.6%
	эм	(139) 86.3%		21-23	(82) 51%
мэргэжил	солонгос хэлний орчуулагч	(102) 63.4%	курс	24 ба түүнээс дээш	(20) 12.4%
	солонгос судлал	(36) 22.4%		1-р курс	(34) 21.1%
ТОPIK-ийн түвшин	солонгос хэлний багш	(23) 14.3%		2-р курс	(38) 23.6%
	ТОPIK 1-2	(14) 8.7%		3-р курс	(46) 28.6%
	ТОPIK 3-4	(36) 22.4%		4-р курс	(43) 26.7
	ТОPIK 5-6	(14) 8.7%		сургуулийн нэр хүнд	(42) 26.1%
	Одоохондоо ТОPIK оноогүй.	(97) 60.2%		багшийн нэр хүнд	(7) 4.3%

мэргэжлийн давуу тал	ахисан түвшинд суралцах боломж өндөр	(16) 9.9%	сургуулийн онцлог	өмчийн хэлбэр (улсын, хувийн)	(10) 6.2%
	мэргэжлээрээ ажиллах боломж өндөр	(17) 10.6%		солонгос багш ихтэй	(49) 30.4%
	мэргэжлийн хүсэл сонирхол	(28) 17.4%		тэтгэлэг авах боломж их	(26) 16.1%
	солонгост суралцах боломж өндөр	(68) 42.2%		сургалтын орчин	(18) 11.2%
мэргэжлийн эрэлт хэрэгцээ	маш их	(24) 14.9%	мэргэжлээрээ ажиллах хүсэл	төгсөгчдийн карьер	(9) 5.6%
	их	(70) 43.5%		тийм	(114) 70.8%
	дунд	(60) 37.3%		үгүй	(8) 5.0%
	бага	(6) 3.7%		мэдэхгүй байна	(39) 24.2%
	маш бага	(1) 0.6%			
мэргэжлээрээ ажиллах боломж	өндөр	(61) 37.9%	бусдын нөлөө	солонгосын соёлын давллага	(84) 52.2%
	дунд	(78) 48.4%		солонгостой холбоотой ажилд орох	(40) 24.8%
	бага	(12) 7.5%		амьдралын шаардлага	(22) 13.7%
	мэдэхгүй	(10) 6.2%		гэр бүлийн шахалт	(10) 6.2%
				найз нөхдийн нөлөө	(5) 3.1%
суралцагчийн зорилго	мэргэжлийн боловсон хүчин болох	(44) 27.3%	солонгос хэлийг сонгосон шалтгаан	хобби, сонирхол	(80) 49.7%
	монголд ахисан түвшинд суралцах	(1) 0.6%		солонгос хэл хэрэглэгчдийн тоо	(32) 19.9%
	солонгост ахисан түвшинд суралцах	(48) 29.8%		солонгос орны зан заншил, соёл	(1) 0.6%
	солонгост ажиллаж амьдрах	(44) 27.3%		дуртай жүжигчдийн тоглосон уран бүтээл	(17) 10.6%
	хэлний мэдлэгээ дээшлүүлэх	(18) 11.2%		өгүүлбэрийн бүтэц нь монгол хэлтэй төстэй тул сурахад хялбар	(24) 14.9%
	диплом л авахын тулд	(6) 3.7%		дуудлага нь зөөлөн	(7) 4.3%

Судалгаанд хамрагдсан оюутнуудын суралцаж буй мэргэжлээс шалтгаалан мэргэжил сонголтод нөлөөлж буй хүчин зүйлсийн давтамжийн тархалт хэр зэрэг байгааг мөн суралцагчдын суралцаж буй “мэргэжил” ба “суралцаж буй сургууль”, “суралцаж буй курс”, “сургуулийн онцлог”, “мэргэжлийн давуу тал”, “суралцагчийн зорилго”, “солонгос хэл сонгосон шалтгаан”, “бусдын нөлөө”, “мэргэжлээрээ ажиллах хүсэл”, мөн “солонгос хэл сонгосон шалтгаан” ба “суралцагчийн зорилго” гэх мэт хүчин зүйл тус бүр хоорондоо хамааралтай эсэхийг Chi-Square test ашиглан шинжилж үзсэн ба түүний үр дүнг доор тайлбарлав.

Нэгдүгээр таамаглал:

H_0 : Суралцагчийн суралцаж буй мэргэжил ба сургууль харилцан хамааралгүй.

H_1 : Суралцагчийн суралцаж буй мэргэжил ба сургууль харилцан хамааралтай.

Судалгаанд хамрагдсан суралцагчдын суралцаж буй мэргэжил тус бүрээр сургуулийн ялгаатай байдлыг авч үзвэл солонгос хэлний орчуулагч мэргэжлээр ОУУБИС-д суралцагсад 45.1% буюу бусад сургуулиас өндөр хувийг, солонгос судлал мэргэжлээр суралцагсад ОУУБИС болон МУИС-д ижил 50.0%-ийг, солонгос хэлний багш мэргэжлээр ОУУБИС-д суралцагсад 60.9% буюу бусад сургуулиас өндөр хувийг эзэлж байна. Ач холбогдлын түвшин $p=.001$ байгаа тул нэгдүгээр таамаглалын хувьд тэг таамаглал үгүйсгэгдэж, алтернатив таамаглал багтлагдав. Өөрөөр хэлбэл суралцагчийн сонгон суралцаж буй мэргэжил ба сургуулийн хооронд хамаарал байна.

(N=161)

Ангилал			Сургууль				
			ОУУБИС	МУИС	ХУИС	ШУТИС	Нийт
Мэргэжил	солонгос хэлний орчуулагч		46 (45.1%)	28 (27.5%)	19 (18.6%)	9 (8.8%)	102 (100.0%)
	солонгос судлал		18 (50.0%)	18 (50.0%)	0 (0.0%)	0 (0.0%)	36 (100.0%)
	солонгос хэлний багш		14 (60.9%)	2 (8.7%)	7 (30.4%)	0 (0.0%)	23 (100.0%)
	Нийт		78 (48.4%)	48 (29.8%)	26 (16.1%)	9 (5.6%)	161 (100.0%)
Chi-Square (p)			23.853 ^a (.001)***				

* $p<0.05$, ** $p<0.01$, *** $p<0.001$

Хоёрдугаар таамаглал:

H_0 : Суралцагчийн суралцаж буй мэргэжил ба курс харилцан хамааралгүй.

H_1 : Суралцагчийн суралцаж буй мэргэжил ба курс харилцан хамааралтай.

Суралцагчдын суралцаж буй мэргэжлээс шалтгаалан курсийн ялгаатай байдлыг авч үзвэл солонгос

хэлний орчуулагч мэргэжлийн хувьд 2, 3 дугаар курст ижил 27.5%-ийг эзэлж байгаа бол солонгос судлал мэргэжлийн хувьд 3 дугаар курст илүү төвлөрсөн байна. Харин солонгос хэлний багш мэргэжлээр суралцагчид 1, 4 дүгээр курст ижил тэнцүү 39.1%-ийг эзэлж байна. Ач холбогдлын түвшин $p=.045$ байгаа тул суралцагчийн сонгон суралцаж буй мэргэжил ба курсийн хооронд хамаарал байна.

(N=161)

Ангилал			Курс				
			1	2	3	4	Нийт
Мэргэжил	солонгос хэлний орчуулагч		20	28	28	26	102
			(19.6%)	(27.5%)	(27.5%)	(25.5%)	(100.0%)
	солонгос судлал		5	9	14	8	36
			(13.9%)	(25.0%)	(38.9%)	(22.2%)	(100.0%)
	солонгос хэлний багш		9	1	4	9	23
			(39.1%)	(4.3%)	(17.4%)	(39.1%)	(100.0%)
Нийт			34	38	46	43	161
			(21.1%)	(23.6%)	(28.6%)	(26.7%)	(100.0%)
Chi-Square (p)			12.866 ^a (.045)*				

* $p<0.05$, ** $p<0.01$, *** $p<0.001$

Гуравдугаар таамаглал:

H_0 : Суралцагчийн суралцаж буй мэргэжил ба мэргэжлийн давуу тал харилцан хамааралгүй.

H_1 : Суралцагчийн суралцаж буй мэргэжил ба мэргэжлийн давуу тал харилцан хамааралтай.

Солбицлын шинжилгээний үр дүнгээс суралцагчийн сонгон суралцаж буй мэргэжлээс шалтгаалаад мэргэжлийн ямар давуу талыг илүүд үзсэнийг харвал, солонгос хэлний

орчуулагч (52.9%), солонгос судлал (50.0%) мэргэжлээр суралцаж буй оюутнууд солонгост суралцах боломж өндөр гэж үзэж байгаа бол солонгос хэлний багш мэргэжлээр суралцаж буй оюутнуудын дийлэнх (34.8%) нь мэргэжлээрээ ажиллах боломж өндөр гэж үзжээ. Хувьсагч хоорондын хамаарал 0.05-ын ач холбогдлын түвшинд үндэслэн хүлээн зөвшөөрөгдөж ($p=.005$) байгаа тул суралцагчийн сонгон суралцаж буй мэргэжил ба мэргэжлийн давуу талын хооронд хамаарал байгаа нь батлагдав.

(N=161)

Ангилал		Мэргэжлийн давуу тал				Нийт
		Мэргэжлийн дур сонирхол	Мэргэжлээрээ ажиллах боломж өндөр	Ахисан түвшинд суралцах боломж өндөр	Солонгост суралцах боломж өндөр	
Мэргэжил	солонгос хэлний орчуулагч	24 (23.5%)	9 (8.8%)	15 (14.7%)	54 (52.9%)	102 (100.0%)
	солонгос судлал	11 (30.6%)	2 (5.6%)	5 (13.9%)	18 (50.0%)	36 (100.0%)
	солонгос хэлний багш	3 (13.0%)	8 (34.8%)	6 (26.1%)	6 (26.1%)	23 (100.0%)
	Нийт	38 (23.6%)	19 (11.8%)	26 (16.1%)	78 (48.4%)	161 (100.0%)
Chi-Square (p)		18.542 ^a (.005)**				

*p<0.05, **p<0.01, ***p<0.001

Дөрөвдүгээр таамаглал

H_0 : Суралцагчийн суралцаж буй мэргэжил ба сургуулийн онцлог харилцан хамааралгүй.

H_1 : Суралцагчийн суралцаж буй мэргэжил ба сургуулийн онцлог харилцан хамааралтай.

Мэргэжил ба сургуулийн онцлогийн солбицлын шинжилгээний үр дүнгээс харахад сургуулийн онцлогт нөлөөлж буй бүх хүчин зүйлс солонгос хэлний орчуулагчийн мэргэжилд төвлөрч байгаа ба р утга .584 байгаа нь статистик ач холбогдолгүй бөгөөд суралцагчийн суралцаж буй мэргэжил ба сургуулийн онцлог харилцан хамааралгүй болохыг илтгэж байна.

(N=161)

Ангилал		Мэргэжил			
		Солонгос хэлний орчуулагч	Солонгос судлал	Солонгос хэлний багш	Нийт
Сургуулийн онцлог	Сургуулийн нэр хүнд	28 (66.7%)	10 (23.8%)	4 (9.5%)	42 (100.0%)
	Багшийн нэр хүнд	6 (85.7%)	0 (0.0%)	1 (10.0%)	7 (100.0%)
	Өмчийн хэлбэр (улсын, хувийн)	6 (60.0%)	3 (30.0%)	1 (10.0%)	10 (100.0%)
	Солонгос багш ихтэй	31 (63.3%)	10 (20.4%)	8 (16.3%)	49 (100.0%)
	Тэтгэлэг авах боломж их	12 (46.2%)	9 (34.6%)	5 (19.2%)	26 (100.0%)
	Сургалтын орчин	12 (66.7%)	2 (11.1%)	4 (22.2%)	18 (100.0%)
	Төгсөгчдийн карьер	7 (77.8%)	2 (22.2%)	0 (0.0%)	9 (100.0%)
	Нийт	102 (63.4%)	36 (22.4%)	23 (14.3%)	161 (100.0%)
	Chi-Square (p)		10.361 ^a (.584)		

*p<0.05, **p<0.01, ***p<0.001

Тавдугаар таамаглал:

H_0 : Суралцагчийн суралцаж буй мэргэжил ба мэргэжлээрээ ажиллах хүсэл харилцан хамааралгүй.

H_1 : Суралцагчийн суралцаж буй мэргэжил ба мэргэжлээрээ ажиллах хүсэл харилцан хамааралтай.

Мэргэжил тус бүрээр мэргэжлээрээ

ажиллах хүсэл хэрхэн байгааг шинжилж үзэхэд солонгос хэлний орчуулагч мэргэжлийн хувьд 73.5% нь, солонгос судлал мэргэжлийн хувьд 55.6% нь, солонгос хэлний багшийн 82.6% нь мэргэжлээрээ ажиллахыг хүсэж байна. Ач холбогдлын түвшин $p=0.076$ байгаа тул суралцагчийн сонгон суралцаж буй мэргэжил ба мэргэжлээрээ ажиллах хүслийн хооронд хамааралгүй байна.

(N=161)

Ангилал		Мэргэжлээрээ ажиллах хүсэл			
		Тийм	Үгүй	Мэдэхгүй байна	Нийт
Мэргэжил	солонгос хэлний орчуулагч	75 (73.5%)	3 (2.9%)	24 (23.5%)	102 (100.0%)
	солонгос судлал	20 (55.6%)	3 (8.3%)	13 (36.1%)	36 (100.0%)
	солонгос хэлний багш	19 (82.6%)	2 (8.7%)	2 (8.7%)	23 (100.0%)
	Нийт	114 (70.8%)	8 (5.0%)	39 (24.2%)	161 (100.0%)
Chi-Square (p)		8.459* (.076)			

* $p<0.05$, ** $p<0.01$, *** $p<0.001$

Зургаадугаар таамаглал:

H_0 : Суралцагчийн суралцаж буй мэргэжил ба бусдын нөлөө харилцан хамааралгүй.

H_1 : Суралцагчийн суралцаж буй мэргэжил ба бусдын нөлөө харилцан хамааралтай.

Мэргэжил сонголтод бусдын нөлөө хэр зэрэг байсныг мэргэжлээр нь аваад үзвэл, солонгос хэлний орчуулагч мэргэжлийн хувьд солонгосын соёлын

давлагаа хэмээх хүчин зүйл бусад хүчин зүйлээс илүү буюу 52.9 хувийг эзэлж байна. Харин солонгос судлал, солонгос хэлний багш мэргэжлийн оюутнуудын хувьд “гэр бүлийн шахалт” тус бүр 33.3%, 30.4%-ийг эзэлж байгаа нь бусад хүчин зүйлсээс илүү хувийг эзэлж байна. Chi-Square test-ийн үр дүнгээс харахад $p=.686$ байгаа ба энэ нь суралцагчийн суралцаж буй мэргэжил ба бусдын нөлөө харилцан хамааралгүй болохыг илэрхийлж байна.

(N=161)

Ангилал		Бусдын нөлөө					
		Солонгосын соёлын давлагаа	Солонгостой холбоотой ажилд орох	Найз нөхөд	Гэр бүлийн шахалт	Амьдралын шаардлага	Нийт
Мэргэжил	солонгос хэлний орчуулагч	54 (52.9%)	1 (1.0%)	33 (32.4%)	25 (24.5%)	11 (10.8%)	102 (100.0%)
	солонгос судлал	9 (25.0%)	0 (0.0%)	9 (25.0%)	12 (33.3%)	4 (11.5%)	36 (100.0%)
	солонгос хэлний багш	6 (26.1%)	0 (0.0%)	6 (26.1%)	7 (30.4%)	3 (13.0%)	23 (100.0%)
	Нийт	44 (27.3%)	1 (1.0%)	48 (29.8%)	44 (27.3%)	18 (11.2%)	161 (100.0%)
		Chi-Square (p)					
		5.650* (.686)					

*p<0.05, **p<0.01, ***p<0.001

Долоодугаар таамаглал

H_0 : Суралцагчийн суралцаж буй мэргэжил ба солонгос хэл сонгосон шалтгаан харилцан хамааралгүй.

H_1 : Суралцагчийн суралцаж буй мэргэжил ба солонгос хэл сонгосон шалтгаан харилцан хамааралтай.

Суралцагчийн сонгон суралцаж буй мэргэжлээс шалтгаалаад солонгос хэл сонгосон шалтгааныг авч үзвэл,

бусад хүчин зүйлээс илүү “хобби, сонирхол”-ийн эзлэх хувь 3 мэргэжлийн хувьд адилхан өндөр (солонгос хэлний орчуулагч 53.9%, солонгос судлал 36.1%, солонгос хэлний багш 52.2%) байна. Chi-Square test-ийн үр дүнгээс харахад $p=.521$ байгаа ба энэ нь суралцагчийн суралцаж буй мэргэжил ба солонгос хэл сонгосон шалтгаан харилцан хамааралгүй болохыг илтгэж байна.

(N=161)

Ангилал		Солонгос хэл сонгосон шалтгаан						
		Хэрэглэгчдийн тоо	Хобби, сонирхол	Дуртай жүжигчний бүтээл	Солонгосын соёл, зан заншил	Сурахад хялбар	Дуудлага зөөлөн	Нийт
Мэргэжил	солонгос хэлний орчуулагч	19 (18.6%)	55 (53.9%)	9 (8.8%)	1 (1.0%)	15 (14.7%)	3 (2.9%)	102 (100.0%)
	солонгос судлал	9 (25.0%)	13 (36.1%)	5 (13.9%)	0 (0.0%)	4 (17.4%)	0 (0.0%)	36 (100.0%)
	солонгос хэлний багш	4 (17.4%)	12 (52.2%)	3 (13.0%)	0 (0.0%)	4 (17.4%)	0 (0.0%)	23 (100.0%)
	Нийт	32 (19.9%)	80 (49.7%)	17 (10.6%)	1 (0.6%)	24 (14.9%)	7 (4.3%)	161 (100.0%)
Chi-Square (p)		9.116* (.521)						

*p<0.05, **p<0.01, ***p<0.001

Наймдугаар таамаглал:

H_0 : Суралцагчийн суралцаж буй мэргэжил ба суралцагчийн зорилго харилцан хамааралгүй.

H_1 : Суралцагчийн суралцаж буй мэргэжил ба суралцагчийн зорилго харилцан хамааралтай.

Солбицлын шинжилгээний үр дүнгээс суралцагчийн сонгон суралцаж буй мэргэжлээс шалтгаалаад цаашдын зорилго юу болохыг авч үзвэл солонгос хэлний орчуулагч мэргэжлээр

суралцагчдын 32.4% нь цаашид солонгост ахисан түвшинд суралцах, солонгос судлалын мэргэжлийн оюутнуудын 33.3% нь солонгост ажиллаж амьдрах, солонгос хэлний багш мэргэжлээр суралцаж буй оюутнуудын 30.4% нь солонгост ажиллаж амьдрахыг хүсэж, зорьж байгаа нь харагдаж байна. Chi-Square test-ийн үр дүнгээс харахад ач холбогдлын түвшин 986 байгаа ба “мэргэжил”, “суралцагчийн зорилго”-ын хооронд хамааралгүй байна.

(N=161)

Ангилал		Суралцагчдын зорилго						
		Мэргэжлийн боловсон хүчин болох	Монголд ахисан түвшинд суралцах	Солонгост ахисан түвшинд суралцах	Солонгост ажиллаж амьдрах	Хэлний мэдлэгээ дээшлүүлэх	Диплом л авах	Нийт
Мэргэжил	солонгос хэлний орчуулагч	29 (28.4%)	1 (1.0%)	33 (32.4%)	25 (24.5%)	11 (10.8%)	3 (2.9%)	102 (100.0%)
	солонгос судлал	9 (25.0%)	0 (0.0%)	9 (25.0%)	12 (33.3%)	4 (11.5%)	2 (5.6%)	36 (100.0%)
	солонгос хэлний багш	6 (26.1%)	0 (0.0%)	6 (26.1%)	7 (30.4%)	3 (13.0%)	1 (4.3%)	23 (100.0%)
	Нийт	44 (27.3%)	1 (1.0%)	48 (29.8%)	44 (27.3%)	18 (11.2%)	6 (3.7%)	161 (100.0%)
Chi-Square (p)				2.770* (.986)				

*p<0.05, **p<0.01, ***p<0.001

Есдүгээр таамаглал:

H_0 : Суралцагчийн солонгос хэл сонгосон шалтгаан ба цаашдын зорилго харилцан хамааралгүй.

H_1 : Суралцагчийн солонгос хэл сонгосон шалтгаан ба цаашдын зорилго харилцан хамааралтай.

Суралцагчдын солонгос хэл сонгосон шалтгаан ба цаашдын зорилгын солбицлын шинжилгээний үр дүнгээс авч үзвэл, солонгос хэл хэрэглэгчдийн тоо ихсэж байгаа учраас мэргэжлийн боловсон хүчин болохыг зорьж буй суралцагчийн хувь (43.8%) өндөр байна. Хобби, сонирхолдоо хөтлөгдөн солонгос хэлийг сонгон

суралцаж байгаа оюутнуудын хувьд цаашид солонгост ажиллаж, амьдрах зорилго өндөр хувь (33.8%)-тай байна. Сурахад хялбар, дуудлага зөөлөн гэж үзэж байгаа суралцагчдын хувьд ч мөн адил солонгост ахисан түвшинд суралцах (50%), тэнд ажиллаж амьдрах (42.9%)-ыг зорьж байгаа нь өндөр хувийг эзэлж байна. Chi-Square test-ийн үр дүнгээс харахад p утга .013 байгаа тул есдүгээр таамаглалын хувьд тэг таамаглал үгүйсгэгдэж, алтернатив таамаглал батлагдав. Өөрөөр хэлбэл суралцагчдын солонгос хэлийг сонгон суралцаж буй шалтгаан ба цаашдын зорилгын хооронд хамаарал байна.

(N=161)

Ангилал	Суралцагчдын зорилго						
	Мэргэжлийн боловсон хүчин болох	Монголд ахисан түвшинд суралцах	Солонгост ахисан түвшинд суралцах	Солонгост ажиллаж амьдрах	Хэлний мэдлэгээ дээшлүүлэх	Диплом л авах	Нийт
Солонгос хэл сонгосон шалтгаан	Хэрэглэгчдийн тоо	14 (43.8%)	0 (0.0%)	10 (31.3%)	3 (9.4%)	4 (12.5%)	32 (100.0%)
	Хобби, сонирхол	20 (25%)	0 (0.0%)	21 (26.3%)	27 (33.8%)	11 (13.8%)	80 (100.0%)
	Дуртай жүжигчний бүтээл	4 (23.5%)	0 (0.0%)	5 (29.4%)	5 (29.4%)	1 (5.9%)	17 (100.0%)
	Солонгосын соёл, зан заншил	0 (0.0%)	0 (0.0%)	0 (0.0%)	1 (100%)	0 (0.0%)	1 (100.0%)
	Сурахад хялбар	5 (20.8%)	1 (4.2%)	12 (50%)	5 (20%)	1 (4.2%)	24 (100.0%)
	Дуудлага зөөлөн	1 (14.3%)	0 (0.0%)	0 (0.0%)	3 (42.9%)	1 (14.3%)	7 (100.0%)
	Нийт	44 (27.3%)	1 (0.6%)	48 (29.8%)	44 (27.3%)	18 (11.2%)	161 (100.0%)
	Chi-Square (p)	43.150* (.013)**					

* $p < 0.05$, ** $p < 0.01$, *** $p < 0.001$

4. ДҮГНЭЛТ

Судалгааны үр дүнд үндэслэн солонгос хэл суралцагчдын мэргэжил сонгохтой холбоотой асуудлуудыг дараах байдлаар нэгтгэн дүгнэв.

Солонгос хэлний орчуулагч, солонгос судлал, солонгос хэлний багш 3 мэргэжлээр суралцагсдын тал шахам хувь буюу 49.7% нь хобби, сонирхолдоо хөтлөгдөн солонгос хэлийг сонгон суралцаж байгаа 3 мэргэжлийн оюутнуудын аль аль нь мэргэжлээрээ ажиллахыг хүсэж байгаа нь эерэг үзэгдэл байна.

Судалгаанд хамрагсдын сонгон суралцаж буй аль ч мэргэжлийн хувьд дийлэнх (солонгос хэл орчуулагч 85.3%, солонгос хэлний багш 87%, солонгос судлал 88.9%) нь эмэгтэй оюутан байгаагаас харахад олон улсад гарч байгаа мэргэжлийн хүйсийн ялгаа манай нийгэмд ч маш тодорхой харагдаж байна. Өмнөх судалгаануудаас харахад мэргэжлүүдийг хүйсээр ялгах асуудал нь жендерийн хэвшмэл ойлголт нөлөөлж байгааг өгүүлсэн байдаг (Хөөрхөн зүрх ТББ:2023)¹.

¹ Бага наснаас эхлэн жендерийн үзэл баримтлалаас хамаарч ялгаатай боловсролыг олгох, тоглож буй тоглоом, сонирхон суралцах сэдвийг хязгаарладаг. Мөн гэр бүл, нийгмийн хүрэн дэх хэвшмэл ойлголтоор дамжуулан тухайн хүний хувийн хүсэл сонирхол, мэргэжил сонголт, ажлын байрны талбарт тэгш бус боломжийг бий болгох дам болон шууд нөлөөг үүсгэдэг байна. Жишээ нь эмэгтэй хүүхдүүдийг хүнтэй ажилладаг, гүйцэтгэх шатны албан тушаалд илүүтэй ажиллахыг шаарддаг. Харин эсрэгээрээ

Хэдийгээр тус судалгааны үр дүнд солонгос хэлний багш, солонгос хэлний орчуулагч, солонгос судлал мэргэжлээр суралцагчдын 49.7% нь солонгос хэл сурах хүсэл сонирхолдоо хөтлөгдөн мэргэжлээ сонгосон хэдий ч тухайн мэргэжлээс шалтгаалан тухайлбал, солонгос судлал, солонгос хэлний багш мэргэжлийн хувьд гэр бүлийн шахалт багагүй хувь (30 гаран)-ийг эзэлж байгаа нь ЕБС-ийн багш гэх мэт нийгэм, хүмүүнлэгийн салбарын мэргэжил бол эмэгтэй хүнд зохимжтой гэж үздэг нийгмийн хандлагатай холбоотой гэж үзэж болно.

Суралцагчийн сонгон суралцаж байгаа мэргэжил ба сургууль, мэргэжил ба курс, мэргэжил ба мэргэжлийн давуу тал, мэргэжил ба сургуулийн онцлог, мэргэжил ба ажиллах хүсэл, мэргэжил ба бусдын нөлөө, мэргэжил ба солонгос хэл сонгосон шалтгаан, мэргэжил ба суралцагчдын цаашдын зорилго, солонгос хэл сонгосон шалтгаан ба суралцагчдын цаашдын зорилго хооронд хамаарал байгаа эсэхийг солбицлын шинжилгээ хийж, ач холбогдлын түвшнийг шалгав. Үүний үр дүнд мэргэжил ба сургуулийн онцлог, мэргэжил ба мэргэжлээрээ ажиллах хүсэл, мэргэжил ба бусдын нөлөө, мэргэжил ба солонгос хэл сонгосон шалтгаан, мэргэжил ба суралцагчдын цаашдын зорилгын хооронд хамаарал

эрчүүдэд дэвшилтэт технологитой ажиллах, оюуны өндөр чадамж шаардсан, шийдвэр гаргах түвшний ажлын байруудад ажиллах боломж өндөр байдаг байна.

байхгүй байна. Харин мэргэжил ба сургууль, мэргэжил ба курс, мэргэжил ба мэргэжлийн давуу талын хооронд хамаарал байгаа нь мэргэжлийн давуу талаас шалтгаалаад сургууль, мэргэжлээ сонгодог болохыг харуулж байна. Солонгос хэлний багшийн мэргэжлээр суралцаж буй оюутнууд мэргэжлийнхээ онцлогийг “мэргэжлээрээ ажиллах боломж өндөр” гэж үзэж байгаа бол солонгос хэлний орчуулагч, солонгос судлалаар суралцаж байгаа оюутнууд “солонгост суралцах боломж өндөр” гэдгийг илүүд үзэж байна. Мөн солонгос хэлийг сонгон суралцсан шалтгаан ба суралцагчдын зорилгын хооронд хамаарал байна. Солонгос хэлийг сонгон суралцахад хүргэсэн “солонгос хэл хэрэглэгчдийн тоо, хобби сонирхол, дуртай жүжигчний бүтээл, солонгосын соёл, зан заншил, сурахад хялбар, дуудлага зөөлөн” зэрэг бүх хүчин зүйлс суралцагчдыг мэргэжлийн боловсон хүчин болох, солонгост ахисан түвшинд суралцах, тэнд ажиллаж амьдрах зорилго руу хөтөлж байна. Нэг үгээр хэлбэл судалгаанд хамрагсад өөрсдийн хүсэл сонирхолдоо хөтлөгдөн солонгос хэлийг сонгон сурч байгаа ба тэдний цаашдын зорилго бол солонгост ахисан түвшинд суралцаж, тэнд ажиллаж амьдрах явдал юм. Үүнд нэг талаас БНСУ-аас гадаад оюутнуудад баримталж байгаа бодлого нөлөөлж байна гэж таамаглаж болох ба энэ талаар цаашид судалгаа хийвэл сонирхолтой үр дүн гарна гэж найдаж байна.

Солонгос хэлийг сонгон суралцаж байгаа оюутнуудын дийлэнх нь 2+2 болон оюутан солилцоо зэрэг хөтөлбөрт хамрагдан солонгос улсад суралцах юмуу үргэлжлүүлэн ахисан шатны сургалтад хамрагдан тэндээ удаан хугацаагаар ажиллаж амьдрах сонирхолтой байна. Иймд гадаадад боловсрол эзэмшиж амьдрах нь хувь хүний сонголт, эрх хэдий ч эх орондоо ирж ажиллаж амьдрахгүй байх нь улс эх орны ажиллах хүчин болоод нийгэм, эдийн засагт сөргөөр нөлөөлөх талтай. Цаашлаад харийн нутагт эх хэл болон өв соёлоо умартах, үр хүүхдэдээ өвлүүлэхгүй байх нь эх хэлний дархлаанд сөрөг үр дагавар учруулах магадлалтайг цаашид анхаарах хэрэгтэй байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

1. Бат-Эрдэнэ, П. (2021). Ахлах ангийн сурагчдын мэргэжил сонголтод эцэг эхийн үзүүлэх нөлөө, Уб., ОУУБИС,
2. Баярзул, Б. (2021). Ахлах ангийн сурагчдын мэргэжил сонголтонд нөлөөлж буй хүчин зүйлсийг судалсан нь, Уб., ОУУБИС,
3. Баярмагнай, Б. (2013). Мэргэжил сонголтод нөлөөлөх хүчин зүйлс, бизнесийн байгууллагын оролцоо, Уб., ОУУБИС,
4. Болормаа, Б., Оюунсүрэн, Б., Алтангэрэл, Ч., Цолмон, Ч. (2015). Ахлах ангийн сурагчдын мэргэжил сонголтыг судалсан нь, Уб., Анагаахын шинжлэх ухааны INNOVATION сэтгүүл,
5. Дашбалжин, М. (2022). Сэтгэл судлалын мэргэжлээр суралцаж буй оюутнуудын мэргэжил сонголтод хийсэн судалгааны үр дүн, Уб., МУИС ,
6. Жаргалмаа, Д. (2017). “Оюутны мэргэжил сонголтын шийдвэр гаргалтад нөлөөлөх хүчин зүйлсийн судалгаа”, МУИС,
7. Хулан-Үжин, О. (2013). Солонгосын соёлын урсгал орчин үеийн Монголд нөлөөлөх нь ,Уб., ОУУБИС,
8. Хөөрхөн зүрх ТББ (2023). Сурагчдын мэргэжил сонголтод жендерийн хэвшмэл ойлголт нөлөөлөх нь, Хөөрхөн зүрх ТББ,
9. Пүрэвсүрэн, Г. (2012). Оюутны мэргэжил сонголтын сэдлийн талаарх онол арга зүйн асуудалд, МУБИС-ийн Лавай сэтгүүл, ЭШБ (12):176–180,
10. Цогзолмаа, Н. (2014). Мэргэжил сонголтын чиг баримжааг судалсан нь, МУБИС-ийн Лавай сэтгүүл, ЭШБ (14):77–82,
11. Эрдэнэчулуун, Д. (2019). Мэргэжил сонголтын сэтгэл зүйн үндэс, Уб., Соёмбо,